

ГАР АРГААР АЛТ ОЛБОРЛОГСДЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ - МОНГОЛД СУДАЛГААНЫ ТАЙЛАН

.....



НҮБ-ЫН ХҮН АМЫН САН



ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГУУЛЬ

Улаанбаатар хот
2007

Тайланг эмхэтгэсэн баг:

Тайланг хянасан: Н. Сүмбэрзүл
Ц. Болормаа

Загварыг гаргаж эмхтгэсэн: Нанжидын Хүдэрчулуун
Очирын Чимэдсүрэн
Өлзийбаярын Ганчимэг

Тайлбар: Энэхүү тайлан англи хэлээр хэвлэгдсэн бөгөөд тайланд гарч байгаа үнэлэлт, дүгнэлтийг нь судлаачдын санал болно.

Санал хүсэлт байвал доорх хаягаар холбоо барина уу.

Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль,
Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль,
Эпидемиологи Биостатистикийн тэнхим

И-мэйл: huderchuluun@hsum.edu.mn
Факс: 976-11-321249
Утас: 976-11-329126

Улаанбаатар хот 2007

Өмнөх үг

Монгол улс дахь НҮБ-ын Хүн Амын Сан нь Монголд гар аргаар алт олборлогсод болон шилжин суурьшигчдын нийгэм эдийн засгийн нөхцөл байдлын талаар хийсэн энэхүү судалгааны тайланг та бүхэнтэй хуваалцаж байгаадаа туйлын баяртай байна. Энэ тайлан нь дээр дурьдсан эмзэг бүлгийнхэнд тулгарч буй улс төр, нийгэм, эдийн засгийн хүндрэлүүдэд хийсэн томоохон судалгааны нэг хэсэг юм.

«Гар аргаар алт олборлогсод болон шилжин суурьшигчдын нийгэм эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах» төслийн хүрээнд Монгол улсын Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургуулийн судлаачдын баг энэ судалгааг явуулсан билээ. Энэхүү төслийг НҮБ-ын Хүний Аюулгүй Байдлын Төлөөх Итгэлцлийн Сангийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хүн Амын Сангаас хэрэгжүүлж байгаа юм.

Төслийн гол зорилго нь төсөл хэрэгжиж буй бүс нутагт /Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Төв, Сэлэнгэ, Овөрхангай аймаг, Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг/ гар аргаар алт олборлогсод болон шилжин суурьшигчдын эрүүл мэндийн тусламж, нийгмийн даатгал, халамж үйлчилгээ, иргэний бүртгэл болон боловсрол зэрэг нийгмийн суурь үйлчилгээг хүртэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн эмзэг бүлэгт ээлтэй бодлого, журмыг боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулахад оршино.

Судалгааны дүнгээс үзэхэд гар аргаар алт олборлогсод болон шилжин суурьшигчдын үлэмж хэсэг нь үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлж чадахгүй байна. Иргэний бүртгэл, нийгмийн даатгал, халамж үйлчилгээний бичиг баримтыг олж авах, шилжүүлэх зохицуулалтын талаарх мэдлэг хангалтгүй болон төрийн үйлчилгээ аваад гарч буй бэрхшээлүүдээс үүдэн гар аргаар алт олбордогсод болон шилжин суурьшигчид нь нийгмийн суурь үйлчилгээг хүртэх, хөдөлмөр эрхлэх боломжоор хомс байна. Судалгаагаар хүн амын эмзэг бүлгийнхэнд тулгарч буй эдгээр хүндрэлтэй асуудлуудыг онцгойлон судалж, шинэлэг тоон болоод чанарын мэдээллүүдийг дүгнэж гаргалаа.

Монгол улсын Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургуулийн судлаачдын баг, нэн ялангуяа О. Чимэдсүрэн, У. Ганчимэг, Н. Хүдэрчулун, Н. Сүмбэрзүл, Б. Алтанзагас, С. Мөнхбаатар нар болон дэмжлэг туслалцаа үзүүлсэн Д. Чимэддулам, Д. Гантуяа, Э. Золжаргал, Д. Оюунбилэг, Т. Ганзориг, О. Хүдэрбат, Д. Оюунчимэг, Б. Түмэнтогтох, А. Сэргэлэнханд, Ч. Батбаяр, П. Эрдэнэчимэг, Н. Цэцэгмаа нарт гүнээ талархаж байгаагаа илэрхийлье. Мөн НҮБ-ын ХАС-ийн Төслийн Зохицуулагч Ч. Оюунцэцэг, Төслийн Ажилтан З. Болор болон арга техникийн зааварчилгаа өгч байсан хөтөлбөр/техникийн ажилтнууд, ялангуяа С. Навчaa /Шадар Суурин Төлөөлөгч/ болон Б. Аюуш /Төслийн Зохицуулагч асан/ нарт талархлаа илэрхийлье.



Делиа Барселона
НҮБ-ын ХАС-ын суурин төлөөлөгч

Үдиртгал

Алтны эрэлт, хэрэгцээ тасралтгүй өсөж байгаатай уялдан дэлхийн зах зээл дээр түүний үнэ нэмэгдсээр байгаа бөгөөд Монгол улсын хувьд алт олборлох үйл ажиллагаанд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжин 1990 оноос Засгийн газрын «Алт-1», 2000 оноос «Алт-2» хөтөлбөрийг хэрэгжүүлснээр алт олборлож буй аж ахуйн нэгж 1991 онд 4 байсан бол 2006 оны байдлаар 153 болж, олборлож буй алтны хэмжээ 11.6 тонн болж 2 дахин нэмэгджээ. Алт олборлолтыг лиценз бүхий уурхайнуудаас гадна иргэд хувиараа олборлон түүнийг тойрсон нийгмийн олон талт асуудал үүсэж байгаатай уялдан бий болсон харилцааг зохицуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын зарим гишүүд, Засгийн Засгийн газраас санаачилсан «Гар үйлдвэрлэлийн аргаар ашигт малтмал олборлох хууль»-ийн төслийг боловсруулан хэлэлцэж байгаа билээ.

Хэдийгээр гар аргаар алт олборлогсдын эрүүл мэнд, ажлын нөхцөл, хөдөлмөр хамгааллын талаар хэд хэдэн судалгаа хийгдсэн ч тэдний хөдөлмөрлөх, сурч боловсрох, нийгмийн халамж үйлчилгээ хүртэх эрхийг хангах бодлого, шийдвэр боловсруулахад ашиглагдах нотолгоонд суурилсан мэдээ, мэдээлэл хомс байгаатай уялдан «Гар аргаар алт олборлогсдын нийгэм, эдийн засгийн байдал, тусламж үйлчилгээний хүртээмж, хэрэгцээ» судалгааг НҮБХАС-ын захиалгаар Японы Засгийн Газрын «Хүний Аюулгүй Байдлын Төлөө Итгэлцлэлийн Сан»-ийн санхүүжилтээр ЭМШУИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн Сургуулийн (НЭМС)-ийн судалгааны баг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгаа нь гар аргаар алт олборлогсдын иргэний бүртгэл, эдийн засгийн байдал, нийгмийн тусламж үйлчилгээний хүртээмж, хэрэгцээг тодорхойлох, хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцлийг үнэлэх зорилгоор тоон судалгааны аргаас гадна асуудалд оролцогч талуудын төлөөллийг оролцуулан чанарын судалгааг өргөн цар хүрээнд явуулснаараа онцлог юм.

Гар аргаар алт олборлогсдын ажлын нөхцөл байдал, хөдөлмөр хамгааллын байдлыг ажлын байранд ажиглалт хийн үнэлэхийн зэрэгцээ эрүүл мэндэд үзүүлэх ажлын ба орчны зарим эрсдэлт хүчин зүйлсийг хэмжин үнэлгээ, дүгнэлт гарган тэдний зан үйл, соёлын зарим асуудал, түүнээс урган гарах нийгэм-сэтгэлзүйн асуудлыг илрүүлэх оролдлого хийсэн анхны судалгаа боллоо.

Судалгааны үр дүн, дүгнэлт, санал, зөвлөмж нь гар аргаар алт олборлогсдын иргэний эрх, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх зэрэгт ашиглагдах боломжтой.

Судалгааны үр дүнг гар аргаар алт олборлогсдын ерөнхий шинж, иргэний бүртгэл, ажил эрхлэлт, орлогын байдал, хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэнд, нийгмийн халамжийн хүртээмж, хэрэгцээ, зан үйл, соёлын зарим асуудал гэсэн үндсэн 7 бүлгээр Та бүхэнд толилуулж байна.

О.Чимэхчурт .

ЭМШУИС, НЭМС-ийн ЭБТ-ийн эрхлэгч,
О.Чимэдсүрэн /АУ-ны доктор/

Талархал

Энэхүү судалгааг явуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн НУБХАС, Японы Засгийн Газрын «Хүний Аюулгүй Байдлын Төлөө Итгэлцлэлийн Сан»—дуг судалгааг түйцэтгэсэн ЭМШУИС, НЭМС-ийн судалгааны багийн өмнөөс талархал илэрхийлье.

«Гар аргаар алт олборлогсод ба шилжин суурьшигчдын нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах төсөл»—ийн Үндэсний зохицуулагч Б. Аюуш, судалгааны түүвэр тооцох, мэдээ, мэдээллийг боловсруулах, мэргэжлийн үнэтэй санал, зөвлөмж өгч зөвлөхөөр ажилласан МУИС-ийн ХАССТ-ийн багш, эдийн засгийн ухааны доктор, эдийн засагч Ц.Болормаа, судалгаа явуулах нөхцлийг бүрдүүлэн, судалгааны тайланг хянан тохиолдуулсан НЭМС-ийн захирал, дэд профессор, АУ-ны доктор Н.Сүмбэрзул нарт судалгааны багийн хамт олны нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Тус судалгааг гардан зохион байгуулж, аргачлал боловсруулах шатнаас үр дүнг хүлээлгэн өгөх хүртэлх ажилд цаг зав, сэтгэл гарган ажилласан судалгааны ажлын Зохицуулагч, НЭМС-ийн ЭБТ-ийн багш, эдийн засагч - статистикч Н.Хүдэрчулуун болон судалгаанд мэргэжлийн чиглэлийн дагуу оролцон баг болж ажилласан бусад гишүүд, мэргэжил нэгт нөхөддөө чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Судалгааг амжилттай явуулахад дэмжлэг, туслалцаа үзүүлсэн ЭМШУИС-ийн захиргаа, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Төв, Сэлэнгэ аймгийн холбогдох сумдын Засаг дарга, тэдний орлогч нар, байгаль орчны байцаагчид, цагдаа, эмнэлгийн эмч ажилтнууд, гар аргаар алт олборлогсод, мөн мэдээ, мэдээлэл цуглуулах, компьютерт мэдээ оруулах, үр дүнг боловсруулах, нэгтгэх зэрэгт идэвхийлэн оролцсон НЭМС-ийн магистрант, оюутнуудад баярласнаа илэрхийлье

О.Чимэдсүрэн

О.Чимэдсүрэн
ЭМШУИС, НЭМС-ийн ЭБТ-ийн эрхлэгч,
АУ-ны доктор,
Төслийн удирдагч

Судалгааны баг

Удирдагч:

Очирын Чимэдсүрэн

ЭБС-ийн тэнхмийн эрхлэгч, НЭМС, ЭМШУИС

Зохицуулагч:

Нанжидын Хүдэрчулуун

ЭБС-ийн тэнхмийн багши, НЭМС, ЭМШУИС

Зөвлөх:

Ц.Болормаа

ЭЗС-ийн багши, МУИС

Редактор:

Н.Сүмбэрзул

НЭМС-ийн захирал

Сургалч:

О.Чимэдсүрэн

ЭБС-ийн тэнхмийн эрхлэгч, НЭМС, ЭМШУИС

Н.Хүдэрчулуун

ЭБС-ийн тэнхмийн багши, НЭМС, ЭМШУИС

Ө.Ганчимэг

ЭБС-ийн тэнхмийн багши, НЭМС, ЭМШУИС

Мэдээлэл цуглуулсан баг:**Багийн ахлагчид:**

О.Чимэдсүрэн

ЭБС-ийн тэнхмийн эрхлэгч, НЭМС, ЭМШУИС

Н.Хүдэрчулуун

ЭБС-ийн тэнхмийн багши, НЭМС, ЭМШУИС

Б.Алтанзагас

УСАУ-ны тэнхмийн багши, НЭМС, ЭМШУИС

С.Мөнхбаатар

НХУ-ны тэнхмийн багши, НЭМС, ЭМШУИС

Ярилцлага авагчид:

Д.Чимэддулам

УСАУ-ны тэнхмийн багши, НЭМС, ЭМШУИС

Д.Гантуяа

ЭБС-ийн тэнхмийн багши, НЭМС, ЭМШУИС

Э.Золжаргал

НЭМС-ийн магистрант

Д.Оюунтунгалааг

НЭМС-ийн магистрант

Д.Оюунбилэг

НЭМС-ийн магистрант

Т.Ганзориг

НЭМС-ийн магистрант

О.Хүдэрбат

Судлаач

Д.Оюунчимэг

Судлаач

Б.Түмэнтогтох

Судлаач

А.Сэргэлэнхад

Судлаач

Ч.Батбаяр

Судлаач

Мэдээлэл засварлалт, шивэлт хийсэн баг:

П.Эрдэнэчимэг	Туслах ажилтан, НЭМС, ЭМШУИС
Э.Золжаргал	НЭМС-ийн магистрант
Д.Оюунбилэг	НЭМС-ийн магистрант
Д.Оюунтунгалаг	НЭМС-ийн магистрант
Н.Цэцэгмаа	НЭМС-ийн магистрант
Т.Мөнхбаяр	АУС-ийн оюутан
Ж.Цэлмэг	БАС-ийн оюутан
М.Пүрэвдорж	БАС-ийн оюутан

Шинжилгээ, боловсруулалт хийсэн баг:

Н.Хүдэрчулун	ЭБС-ийн тэнхмийн багш, НЭМС, ЭМШУИС
Ө.Ганчимэг	ЭБС-ийн тэнхмийн багш, НЭМС, ЭМШУИС

Туслах ажилтан:

П.Эрдэнэчимэг	Туслах ажилтан, НЭМС, ЭМШУИС
---------------	------------------------------

Тайлан бичсэн баг:

Очирын Чимэдсүрэн	ЭБС-ийн тэнхмийн эрхлэгч, НЭМС, ЭМШУИС
Нанжидын Хүдэрчулуун	ЭБС-ийн тэнхмийн багш, НЭМС, ЭМШУИС
Өлзийбаярын Ганчимэг	ЭБС-ийн тэнхмийн багш, НЭМС, ЭМШУИС
Лхаасүрэнгийн Оюунтогос	УСАУ-ны тэнхмийн багш, НЭМС, ЭМШУИС
Гомбожавын Даваа	ЭБС-ийн тэнхмийн багш, НЭМС, ЭМШУИС
Цэрэннадмыдын Нямсүрэн	НХУ-ны тэнхмийн багш, НЭМС, ЭМШУИС
Лувсангийн Мөнх-Эрдэнэ	ЭМЭЗ-ийн тэнхмийн багш, НЭМС, ЭМШУИС
Сэнгэдоржийн Мөнхбаатар	НХУ-ны тэнхмийн багш, НЭМС, ЭМШУИС

Тайланг англи хэл рүү хөрвүүлсэн

Н.Хулан

Гарчиг

Өмнөх үг	i
Удиртгал	ii
Талархал	iii
Судалгааны баг	iv
Гарчиг	vi
Товчилсон үтийн жагсаалт	x

БҮЛЭГ I. УДИРТГАЛ	1
1.1 Удиртгал	2
1.2 Судалгааны зорилго	2
1.3 Судалгааны загвар	3
1.4 Судалгааны түүвэрлэлт	6
БҮЛЭГ II. ХҮН АМЫН БОЛОН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖ БАЙДАЛ	9
2.1 Хүн ам зүйн шинж байдал	10
2.2 Нийгэм, эдийн засгийн шинж байдал	12
2.3 Ажиллаж амьдарч буй ахуйн нөхцөл	15
2.4 Дүгнэлт, Санал зөвлөмж	16
БҮЛЭГ III. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД	19
3.1 Шилжилт хөдөлгөөн, иргэний бүртгэл	20
3.2 Иргэний бүртгэлийн үеийн хүндрэл	24
3.3 Ажил эрхлэлт ба орлого	25
3.4 Алтны борлуулалт ба хуримтлал	28
3.5 Дүгнэлт, Санал зөвлөмж	29
БҮЛЭГ IV. АЖЛЫН НӨХЦӨЛ БА ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ	31
4.1 Гар аргаар алт олборлогсдын хөдөлмөрийн болон орчны эрүүл ахуйн нөхцөл	32
4.2 Химийн хүчин зүйлсийн нөлөө	37
4.3 Хөдөлмөрийн багаж хэрэгсэл ба хөдөлмөрийн хуваарь	41
4.4 Эргономикийн болон осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлс	43
4.5 Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, түүний хэрэглээ	45
4.6 Ариун цэврийн байгууламж, унд-ахуйн болон технологийн хэрэгцээний усан хангамж	47
4.7 Гар аргаар алт олборлогсдын ажил, амралтын горим	48
4.8 Дүгнэлт, Санал зөвлөмж	50

БҮЛЭГ V. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ХЭРЭГЦЭЭ	53
5.1 Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний хүртээмж	54
5.2 Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний хэрэгцээ	62
5.3 Дүгнэлт, Санал зөвлөмж	63
БҮЛЭГ VI. НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ	65
6.1 Гар аргаар алт олборлогсдын нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдалт	66
6.2 Гар аргаар алт олборлогсдын нийгмийн даатгалын хэрэгцээ	70
6.3 Дүгнэлт, Санал зөвлөмж	71
БҮЛЭГ VII. ЗАН ҮЙЛ, СОЁЛЫН ЗАРИМ АСУУДАЛ	73
7.1 Нийтлэг бэрхшээл	74
7.2 Осол гэмтэлд өртөх, амь насаа алдах зэрэгт хандах байдал	77
7.3 Зан байдлын өөрчлөлт, амьдрах арга барилын үнэлэмж	78
7.4 Дүгнэлт, Санал зөвлөмж	80
БҮЛЭГ VIII. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ	83
I. Дүгнэлт	84
II. Бодлогын зөвлөмж	86
ХАВСРАЛТ	89
Хавсралт 1. Ашигласан номын жагсаалт	90
Хавсралт 2. Гар аргаар алт олборлогч иргэдийн асуулга	92
Хавсралт 3. Гар аргаар алт олборлогчдын нийгмийн тусlamжийн чиглэлээр хийх ярилцлагын удирдамж	105
Хавсралт 4. Хөдөлмөрийн болон орчны эрүүл ахуйн тохиромжгүй хүчин зүйлсийг тодорхойлох хяналтын хуудас	117

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.1	Судалгаанд хамрагдсан орд газар	4
Хүснэгт 1.2	Түүврийн хэмжээ	6
Хүснэгт 1.3	Чанарын судалгааны хамралт, ярилцлагад хамрагдагсдын тоо	7
Хүснэгт 1.4	Асуумж судалгааны хамралт	7
Хүснэгт 2.1	Судалгаанд хамрагдсан гар аргаар алт олборлогсдын хувийн жин, сонгосон үзүүлэлтүүд, ажиллаж буй ордоор	12
Хүснэгт 2.2	Судалгаанд хамрагдагсдын нийгэм, эдийн засгийн шинж байдал, хувийн жин	14
Хүснэгт 3.1	Гар аргаар алт олборлогсдын ам бүлийн тоо, ажиллаж буй хугацаа	21
Хүснэгт 3.2	Иргэний бүртгэлд бүртгүүлэх үеийн хүндрэл, хувийн жин	25
Хүснэгт 3.3	Судалгаанд хамрагдсан иргэдийн гар аргаар алт олборлох болсон шалтгаан, насны бүлгээр, хувийн жин	26
Хүснэгт 3.4	Гар аргаар алт олборлогсдын хоногт ажилладаг цаг ба өдөрт олборлож буй алтны хэмжээ	26
Хүснэгт 3.5	Гар аргаар алт олборлогсдын орлогын хэмжээ, ажиллаж буй ордоор, хувийн жин	27
Хүснэгт 4.1	Ажлын байрны тоосны ерөнхий хэмжээ	33
Хүснэгт 4.2	Судалгаанд хамрагдсан гар аргаар алт олборлогсдын ажлын нөхцөл, ажиллаж буй ордоор, хувийн жин	34
Хүснэгт 4.3	Ажлын байрны шуугианы түвшин	35
Хүснэгт 4.4	Ажлын байран дахь доргионы түвшин	36
Хүснэгт 4.5	Ажлын байрны бичил цаг уурын үзүүлэлтүүд	37
Хүснэгт 4.6	Гар аргаар алт олборлогсдын мөнгөн усны хэрэглээ ба хадгалалт	39
Хүснэгт 4.7	Төв аймгийн Борнуур, Жаргалан сумын уурхай орчмын усны эх үүсвэрүүд дэх мөнгөн усны агууламж (мг/л)	40
Хүснэгт 4.8	Төв аймгийн Борнуур, Жаргалан сумын уурхай, тээрэм орчмын хөрсөн дэх мөнгөн усны нэгдлийн агууламж (мг/кг)	41
Хүснэгт 4.9	Алт олборлогсдын ажил, амралтын горим	49
Хүснэгт 5.1	Гар аргаар алт олборлогсдын эрүүл мэндийн тусlamжийн төрөл	56
Хүснэгт 5.2	Гар аргаар алт алт олборлогсодод тохиолдож буй осол, түүний шалтгаан	60
Хүснэгт 6.1	Тэтгэвэр, тэтгэмж ба эрүүл мэндийн даатгалын хамралт	67
Хүснэгт 6.2	Нийгмийн даатгалын шимтгэл төлж буй байдал, сарын дундаж орлогын хэмжээ	67
Хүснэгт 7.1	Гар аргаар алт олборлогсодод тулгарч буй соёлын бэрхшээл	75
Хүснэгт 7.2	Гар аргаар алт олборлогсдын зохисгүй хэрэглээ	76
Хүснэгт 7.3	Алт олборлох ажил хийж эхэлснээс хойш зан чанар өөрчлөгдсөн байдал, хувийн жин	79
Хүснэгт 7.4	Алт олборлох болон түүнээс өмнөх амьдрах арга барилаа үнэлсэн байдал	80

Зургийн жагсаалт

Зураг 2.1	Гар аргаар алт олборлогсдын нас, хүйсийн суврага	10
Зураг 2.1a	Хүн амын нас, хүйсийн суврага (Шороон ордод ажиллагсад)	11
Зураг 2.1b	Хүн амын нас, хүйсийн суврага (Үндсэн ордод ажиллагсад)	11
Зураг 2.2	Судалгаанд хамрагдсан гар аргаар алт олборлогсдын боловсролын түвшин, хүйсээр	13
Зураг 2.3	Боловсролын түвшин насыны бүлгээр, хувийн жин	13
Зураг 2.4	Алт олборлох үед тохиолддог бэрхшээл, хувийн жин	16
Зураг 3.1	Иргэний бичиг баримттай эсэх, хувийн жин	22
Зураг 4.1	Гүйцэтгэдэг ажлын төрөл, хүйсээр	41
Зураг 4.2	Алт олборлогсдын хоногт газар доор ажилладаг хугацаа, цагаар, хүйсээр	42
Зураг 4.3	Алт олборлогсдын хоногт угаадаг шорооны хэмжээ, насыны бүлэг, хүйсээр	42
Зураг 4.4	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл	46
Зураг 4.5	Алт олборлогсдын хөдөлмөр хамгааллын хувцас ашиглалттай холбоотой хүндрэл	47
Зураг 5.1	Алт олборлогсдын эрүүл мэндийн тусlamж авахад тулгардаг бэрхшээл	61
Зураг 5.2	Гар аргаар алт олборлогсдын эрүүл мэндийн тусlamжийн хэрэгцээ, хувийн жин	62
Зураг 6.1	Гар аргаар алт олборлогсдын нийгмийн даатгал ба эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, аймгаар	68
Зураг 6.2	Нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байгаа шалтгаан	68
Зураг 6.3	Нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдлыг үнэлсэн байдал	69
Зураг 6.4	Сайн дурын даатгалын талаар мэднэ гэж хариулсан алт олборлогсод, насыны бүлгээр	69
Зураг 6.5	Гар аргаар алт олборлогсдын нийгмийн даатгалын хэрэгцээ, даатгалын төрлөөр /хувиар/	70
Зураг 6.6	Одоо шаардлагатай байгаа нийгмийн халамж, үйлчилгээ, хүйсээр	71
Зураг 7.1	Алт олборлогсдын осол гэмтэлд өртөх, амь наасаа алдах зэрэгт хандах хандлага, хувийн жин	77
Зураг 7.2	Алт олборлогсдын зан байдалд гарч байгаа өөрчлөлт, хувийн жин	79

Товчилсон үгийн жагсаалт

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АУ	Анагаах ухаан
АУС	Анагаах ухааны сургууль
БАС	Био-Анагаахын сургууль
НЭМХ	Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МШӨ	Мэргэжлээс Шалтгаалах Өвчин
ХАССТ	Хүн Амын Сургалт Судалгааны Төв
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НХУ	Нийгэм, хүмүүнлэгийн ухаан
НХХ	Нийгмийн Хамгаалал Хөдөлмөр
НХХЯ	Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам
НЭМ	Нийгмийн Эрүүл Мэнд
НЭМС	Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
НЭМХ	Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ХАС	Хүн Амын Сан
XXX	Хөдөлмөр Хамгаалах Хэрэгсэл
УСАУ	Урьдчилан сэргийлэх анагаах ухаан
ЭМНХ	Эрүүл Мэнд Нийгмийн Хамгаалал
ЭБТ	Эпидемиологи, Биостатистикийн тэнхим
ЭЗС	Эдийн Засгийн Сургууль
ЭМШУИС	Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
MNS	Монгол улсын стандарт

Бүлэг I

УДИРТГАЛ



Бүлэг I. Удиртгал

Алтны эрэлт, хэрэгцээ тасралтгүй өсөж байгаатай уялдан дэлхийн зах зээл дээр түүний үнэ нэмэгдсээр байгаа бөгөөд алт олборлолтоороо Өмнөд Африкийн орнууд, АНУ, Канад, Орос, Хятад зэрэг улсууд тэргүүлсээр байна. Монгол улсын хувьд алт олборлох үйл ажиллагаанд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжин 1990 оноос Застийн газрын «Алт-1», 2000 оноос «Алт-2» хөтөлбөрийг хэрэгжүүлснээр алт олборлож буй аж ахуйн нэгж 1991 онд 4 байсан бол 2006 оны байдлаар 153 болж, олборлож буй алтны хэмжээ 11.6 тонн болж 2 дахин нэмэгджээ. Түүнчлэн энэ салбарт хувиараа алт олборлогсдын тоо эрс нэмэгдсэнтэй уялдан 2002 оноос эхлэн Монгол банк хувь хүнээс алт худалдан авдаг боллоо.

Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын 2005 оны тайланд дурьдсанаар улсын хэмжээнд 30 000 гаруй гар аргаар алт олборлогсод байгаагийн 800 орчим нь Сэлэнгэ, 6000 гаруй нь Баянхонгор аймгийн нутагт ажиллаж байна.

Гар аргаар алт олборлогсдын ажлын нөхцөл, орлого, эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын байдлыг 2002 онд НЭМХ, 2005 онд МУИС-ийн ХАССТ-өөс ОУХБ –ын АЙПЕК хөтөлбөрийн хүрээнд тус тус судалсан байна.

Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар Швейцарын хөгжил, хамтын ажиллагааны агентлагтай хамтран гар аргаар алт олборлогсодод чиглэсэн «Бичил уурхайг дэмжих төсөл»–ийг 2005 оноос хэрэгжүүлж байгаа билээ.

Дээрхи судалгаа, төслийн хүрээнд гар аргаар алт олборлогсдын эрүүл мэнд, ажлын нөхцөл, хөдөлмөр хамгааллын талаар хэд хэдэн судалгаа хийгдсэн хэдий ч тэдний хөдөлмөрлөх, сурч боловсрох, нийгмийн халамж үйлчилгээ хүртэх эрхийг хангах бодлого, шийдвэр боловсруулахад ашиглагдах нотолгоонд суурилсан мэдээ, мэдээлэл хангалтгүй байна. Иймээс гар аргаар алт олборлогсдын иргэний эрх, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах баримт, мэдээллийг бүрдүүлэхийн тулд уг судалгааг явууллаа.

Судалгааны зорилго

Гар аргаар алт олборлогсдын иргэний бүртгэл, эдийн застийн байдал, нийгмийн тусlamж үйлчилгээний хүртээмж, хэрэгцээг тодорхойлох, хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцлийг үнэлэхэд судалгааны ажлын зорилго оршино.

Зорилтууд

Гар аргаар алт олборлогсдын:

- Иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг судлах;
- Ажил эрхлэлт, амьжиргааны эх үүсвэр, орлого, зарлагыг тодорхойлох;
- Нийгмийн суурь тусlamж, үйлчилгээний одоогийн түвшинг үнэлэх, хэрэгцээг тодорхойлох, бэрхшээлийг илрүүлэн шийдвэрлэх боломж, арга замыг тодорхойлох;
- Ажлын нөхцөл байдал, хөдөлмөр хамгааллын байдлыг үнэлэх;
- Зан үйл, соёлын зарим асуудал, түүнээс урган гарах нийгэм-сэтгэлзүйн асуудлыг илрүүлэх

Судалгааны зохион байгуулалт

Судалгааг НҮБ-ын Хүн амын Сангийн (ХАС) санхүүгийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль (ЭМШУИС)-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль (НЭМС)-ийнбагшнараас бүрдсэн судалгааны багарга, аргачлал боловсруулах, түүвэр, түүвэрлэлт хийх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих зэрэг үйл ажиллагааг зохион байгуулан 2006 оны 10 сараас 2007 оны 1 сард явуулав.

Судалгааны мэдээллийг компьютерт оруулах, үр дүнгийн хүснэгтийг боловсруулах, тайланг бичих, мэдээллийн үнэн зөв байдалд үнэлгээ өгөх ажилд НҮБ-ын ХАС, Монгол Улсын Их Сургуулийн багш нараас зөвлөгөө авч, хамтран ажиллалаа.

Судалгааны загвар

Дескриптив загвараар гар аргаар алт олборлогчдын нийгэм, эдийн засгийн байдал, эрүүл мэнд, нийгмийн суурь тусlamж үйлчилгээг, Ажиглалтын ба хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтийн зарим аргаар ажлын нөхцөл, хөдөлмөр хамгааллын байдлыг тус тус судаллаа.

Судалгааны хүн ам

Гар аргаар алт олборлогсод гэдэгт судалгаа авах үед алт олборлох талбар болон түүний ойр орчмын газарт гэр бүлээрээ болон ганцаараа ажиллаж, амьдрэн албан бусаар алт олборлох ажил эрхэлж буй 15 ба түүнээс дээш настай, Монгол Улсын иргэдийг хамруулав. Алт олборлох ажлыг сүүлийн нэг долоо хоног болон түүнээс доош хугацаагаар эрхэлж байгаа иргэнийг судалгаанд хамруулаагүй болно.

Судалгаанд хамрагдсан аймаг ба орд газрууд

Энэ судалгаанд гар аргаар алт олборлолт явагдаж буй сонгогдсон аймгийн нутаг дэвсгэр дэх алтны ордыг хамруулав (Хүснэгт 1.1).

Хүснэгт 1.1 Судалгаанд хамрагдсан орд газар

№	Аймаг	Сум	Орд газрын нэр	Орд газрын төрөл
1.	Архангай	Цэнхэр	Орхон багийн Будант	Шороон орд
2.	Өвөрхангай	Уянга Бат-Өлзий	Өлт, Бөөрөлжүүт, Шар суваг Зүүн, баруун Сөдөт	Шороон орд Шороон орд
3.	Төв	Борнуур Жаргалант Баянгол	Сүжигтэй Нарантолгой, Талбулаг Тариат, Бортолгой, Октябрь-Уул	Шороон орд Шороон орд Шороон орд
4.	Сэлэнгэ	Орхонтуул Ерөө	Тоорой мод, Харганат, Могойт, Ялбагт, дунд ба Өлөнт, Гозон шар	Шороон орд Шороон орд
5.	Дархан-Уул	Шарын гол	Багануур	Шороон орд
6.	Баянхонгор	Галуут Баян-Овоо Баацагаан Бөмбөгөр	Алтан ус, Буйлсан, Бортолгой	Шороон орд Шороон орд Шороон орд Шороон орд

Судалгааны арга

Шаардлагатай мэдээ, мэдээллийг нийгмийн судалгааны тоон болон чанарын аргыг ашиглан цуглуулсан. Үүнд:

- Тоон судалгаанд холбогдох статистик тоо баримт, бусад судалгааны үр дүн, асуумжийг ашиглав.

Асуумжийн бүтэц:

- Удиртгал (I бүлэг)
- Ерөнхий шинж (II бүлэг)
- Шилжилт, бүртгэл, ажил эрхлэлт (III бүлэг)
- Ажлын нөхцөл ба хөдөлмөр амралтын горим (IV бүлэг)
- Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ (V бүлэг)
- Нийгмийн хalamж (VI бүлэг)
- Нийгэм, соёлын саад (VII бүлэг) гэсэн бүлэг бүхий асуултаас бүрдсэн.

Асуултын 85 хувь нь олон сонголт бүхий хариулттай байлаа.

- Чанарын судалгааны ганцаарчилсан ярилцлагаар тухайн орон нутгийн байгаль орчин, засаг захиргаа, нийгмийн үйлчилгээний салбарт гараргааралт олборлогсдын үйл ажиллагаанаас учирч буй дарамт, хүндрэл, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар зорилтот бүлгийн төлөөлөлтэй ярилцан тэдний санал, үзэл бодол, хандлага, тохиолдлыг судаллаа.

Ярилцлагад хамрагдсан бүлэг

- Орон нутгийн удирдлага
- Орон нутгийн нийгмийн тусlamж, үйлчилгээ үзүүлэгч
- Уул уурхайн мэргэжлийн удирдах байгууллагын ажилтан
- Мэргэжлийн хяналтын байцаагч
- Гар аргаар алт олборлогсод
- Бусад

Үндсэн чиглэлийн дагуу судалгааны асуумжийг зорилтот бүлгээр гарган удирдамжийн дагуу ярилцлагаар мэдээ, мэдээллийг цуглуулав.

Ярилцлагын үндсэн чиглэл

- Бүртгэл, шилжилт хөдөлгөөн
 - Иргэний бүртгэлд хамрагдалт, хамрагдаагүй шалтгаан
 - Гар аргаар алт олборлогсод, орон нутгийн удирдлагуудын иргэний бүртгэлтэй холбоотой санал, хандлага
 - Ажил эрхлэлт, орлого
 - Боловсрол
 - Ажил эрхлэлт
 - Орлого, түүний зарцуулалт
 - Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал
 - Ажил амралтын горим
 - Ажлын нөхцөл
 - Хөдөлмөрийн аюулгүй байдал
 - Хөдөлмөрийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ
 - Мэргэжлийн хяналт, үйлчилгээ
 - Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ
 - Тусlamжийн хүртээмж, төрөл
 - Тусlamж үзүүлэх, авах үеийн хүндрэл
 - Хэрэгцээ
 - Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт
 - Нийгмийн халамж, үйлчилгээ
 - Хүртээмж
 - Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл
 - Хэрэгцээ
 - Зан үйл, соёлын зарим асуудал:
 - Соёлын бараа, үйлчилгээ
 - Зан үйлийн зарим асуудал
3. Гар аргаар алт олборлогсдын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, орчны судалгааны арга. Ажлын нөхцөл, хөдөлмөр хамгаалал, орчныг судлахдаа дараах аргуудыг ашиглав. Үүнд:
- Хяналтын хуудас (Хавсралт 3)
 - Ажлын байрны хэмжилт

Судлаач хяналтын хуудсын дагуу ажлын байран дээр ажиглалт хийж, дараах хүчин зүйлс, нөхцлийг үнэллээ. Үүнд:

- Физикийн хортой хүчин зүйлс
- Химийн хортой хүчин зүйлс
- Орчны хүчин зүйлс
- Эргономикийн хүчин зүйлс
- Осол гэмтлийн хүчин зүйлс
- Хөдөлмөрийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ, төрөл
- Ариун цэврийн байгууламж
- Унд-ахуйн усан хангамж ба технологийн хэрэглээний усан хангамж
- Ажил амралтын горим

Сонгогдсон уурхай бүрт дараах хэмжилтийг хийв. Үүнд:

- Дуу, шуугиан – шумомерээр
- Ерөнхий тоосны хэмжээ – жингийн аргаар
- Температур, чийг, агаарын хөдөлгөөн – термометр, гигрометрээр
- Мөнгөн усны агууламж – алт угаасан ус, орчин, седиментэд Атом шингээлтийн хроматографаар тус тус хэмжлээ.

Тухайн уурхайн алт олборлож буй аргаас (нойтон арга буюу усан буу, мөнгөн усаар ялгах, хуурай арга буюу шигших) хамаарч хэмжих үзүүлэлт, давтамжийг тооцов.

Судалгааны түүвэрлэлт

Түүврийн хүрээ ба нэгж

НҮБ-ын ХАС-аас судалгаанд хамруулахаар санал болгосон аймаг суман дахь нийт гар аргаар алт олборлогсдыг түүврийн ерөнхий хүрээ гэж тооцон энгийн санамсаргүй түүврийн зарчмаар судалгаанд оролцогчийг (иргэн) сонгосон.

Түүврийн хэмжээ

Гар аргаар алт олборлогсдын бодит тоо (байнга ажиллагчдын тоо хэмжээг гаргахад хүндрэлтэй, ийм төрлийн тоо мэдээлэл тэр бүр байдаггүй), улирлын хэлбэлзэл зэрэг онцлогийг анхаарч 95 хувийн түвшинд 5.0 хувийн алдааны магадлалтайгаар 395 хүнийг түүвэрлэн судлахад тохиromжтой гэж үзлээ. Үүн дээр түүврийн бус алдааны нөлөөллийг оруулан нийт түүврийн хэмжээг 395-400-д хүргэхээр тооцов. Аймаг, сум тус бүрээс сонгогдох хүн амыг нийт гар аргаар алт олборлогсдын тоонд тухайн аймаг, суманд гар аргаар алт олборлогсдын эзэлж буй хувийн жингийн тархалтыг ашиглан, пропорциональ бус тархалтаар тооцсоныг Хүснэгт 1.2-д үзүүлэв.

Хүснэгт 1.2 Түүврийн хэмжээ

№	Сонгогдсон		Гар аргаар алт олборлогсод		Түүвэр хүн амын тоо	
	Аймаг	Сум	Тоо	Хувийн жин	Пропорциональ	Засварласан
1.	Баянхонгор	Шинэ Жинст	2500	9.1	37	30
2.	Баянхонгор	Баян-Овоо	3500	12.8	39	45
3.	Баянхонгор	Галуут	100	0.4	1	10
4.	Архангай	Цэнхэр	50	0.2	1	10
5.	Өвөрхангай	Бат-Өлзий	500	1.8	7	10
6.	Өвөрхангай	Уянга	7000	25.5	105	70
7.	Сэлэнгэ	Баянгол	2420	8.8	36	30
8.	Сэлэнгэ	Ерөө	5500	20.1	82	60
9.	Сэлэнгэ	Орхонтуул	1300	4.7	19	30
10.	Төв	Сэргэлэн	50	0.2	1	10
11.	Төв	Жаргалант	2500	9.1	37	30
12.	Төв	Борнуур	1000	3.6	15	30
13.	Дархан-Уул	Шарын гол	1000	3.6	15	30
Нийт (түүврийн бус алдааг тооцолгүйгээр)					395	395
Нийт (түүврийн бус алдааг тооцсоноор)					400	400

Эх сурвалж: НҮБ-ын ХАС

Судалгааны хамралт

Гар аргаар алт олборлогсдын асуумж судалгаанд гар аргаар алт олборлогч 400 иргэнийг сонгож, зорилтот бүлгийн 79 иргэнтэй ярилцлага хийлээ. Судалгаанд оролцсон судлаач, бусад ажилтнаас гэмтэж, осолдсон хүн гараагүй.

Хүснэгт 1.3 Чанарын судалгааны хамралт, ярилцлагад хамрагдагсдын тоо

№	Ярилцлагад	Сонгогдсон хүний тоо	Ярилцлагад оролцсон хүний тоо	Хамралтын хувь
1	Аймгийн засаг дарга, түүний олборлогч	3	2	66.7
2	Аймгийн хөдөлмөрийн улсын байцаагч	5	5	100
3	Сумын засаг дарга, түүний орлогч	12	12	100
4	Сумын байгаль орчны улсын байцаагч	12	12	100
5	Сумын хүн эмнэлгийн эрхлэгч, эмч нар	12	12	100
6	Сумын цагдаагийн төлөөлөгч	12	12	100
7	Гар аргаар алт олборлогч	24	24	100
Total		80	79	98.8

Судалгааны явцад зарим сонгогдсон сумын нутагт гар аргаар алт олборлогсод байхгүй байсан учраас өөр сумас нэмж түүвэрлэсэн болно.

Хүснэгт 1.4 Асуумж судалгааны хамралт

Аймаг	Сум	Хамрагдсан гар аргаар алт олборлогсод
Архангай	Цэнхэр	15
Баянхонгор	Баян-Овоо Галуут Бөмбөгөр	45 32 21
Дархан-Уул	Шарын гол	39
Сэлэнгэ	Баянгол Ерөө Орхонтуул	32 34 38
Төв	Жаргалант Борнуур	30 30
Өвөрхангай	Бат-Өлзий Уянга	27 56
Бүгд		399
Сонгогдсон гар аргаар алт олборлогсод		400
Хамралтын хувь		99.8

Мэдээ, мэдээлэл цуглуулалт ба зохион байгуулалт

Ярилцлага авагч нарт зориулсан сургалт явуулж, улмаар судалгааны мэдээлэл цуглуулах багийг тус бүр 4 хүний бүрэлдэхүүнтэй томилсноор мэдээлэл цуглуулах ажил эхэлсэн. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгуудад нэгэн зэрэг эхлэхээр төлөвлөсөн.

Баг бүрт багийн ахлагч томилж ажиллуулсан бөгөөд тухайн өдрийн цуглуулсан мэдээллийг шалган хүлээн авч, алдаатай, тодорхойгүй зүйлийг илрүүлэн шаардлагатай гэж үзвэл газар дээр нь очиж тодруулж байв. Мэдээлэл цуглуулалтын ажлын явцад 7 хоног бүр судалгааны багас хяналт тавьж ажиллалаа. Түүнчлэн аймаг, сум, багийн холбогдох ажилтнууд бидний ажилд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хамтран ажилласан болно.

Урьдчилан бэлтгэсэн ярилцлагын удирдамжийн хүрээнд гар аргаар алт олборлогсод болон бусад оролцогчидтой ганцаарчилсан ярилцлага хийж ярилцлагыг судалгааны багийн ахлагч чиглүүлэн, тэмдэглэл хөтлөхийн зэрэгцээ аудио бичлэгийн аппарат ашиглан бичлэг хийлээ.

Боловсруулалт, шинжилгээ

Тоон судалгааны мэдээллийг оруулж, үр дүнгийн шинжилгээ хийн, мэдээлэл боловсруулахад ISSA, SPSS – 14 программ хангамжийг ашиглав.

Чанарын судалгааны мэдээлэл боловсруулалтад «Simple text analyse» болон үр дүнгийн агуулгын дагуу бүлэглэн «матриц» үүсгэн, нэгтгэж дүгнэлт хийв.

Бүлэг II

**ХҮН АМЫН БОЛОН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖ БАЙДАЛ**




Бүлэг II. Хүн амын болон нийгэм, эдийн засгийн шинж байдал

Судалгаанд хамрагдсан гар аргаар алт олборлогсдын нас, хүйсийн бүтэц, гэрлэлтийн байдал, боловсролын түвшин, ажил эрхлэлт, ажлын нөхцлийн талаар энэ бүлэгт харуулав. Судалгаанд хамрагдагсдыг ажиллаж байгаа ордоор нь алтны үндсэн болон шороон орд гэж ангилан харьцуулалт хийв. Энэ бүлэг нь дараагийн бүлгүүдэд оршил болж тодотгол хийгдэх болно.

2.1 Хүн ам зүйн шинж байдал

Судалгаанд хамрагдагсдын 66.7 хувь нь шороон ордод, 33.3 хувь нь үндсэн ордод ажиллаж байв. Гар аргаар алт олборлогсдын нас хүйсийн суврагыг нийт хамрагдагсад болон үндсэн ба шороон ордод ажиллагсдаар Зураг 2.1-д харууллаа.


Зураг 2.01 Гар аргаар алт олборлогсдын нас, хүйсийн суврага




Судалгаанд хамрагдагсдын 64.7 хувь нь эрэгтэй, 35.3 хувь нь эмэгтэй, хүйсийн харьцаа 1.8 буюу 1 эмэгтэй тутамд 1.8 эрэгтэй ноогдож байна. Энэ нь гар аргаар алт олборлох ажил нь харьцангуй хүнд нөхцөлтэй, эрэгтэйчүүдийн оролцоо их байдагтай холбоотой байж болох юм.

Суврагаас харахад эрэгтэйчүүдийн хувьд 20-24 нас, эмэгтэйчүүдийн хувьд 35-39 насны хүмүүсийн эзлэх хувийн жин харьцангуй өндөр байна. Судалгаанд хамрагдсан 20-24 насны эрэгтэйчүүдийн хувьд 65.4 хувь нь мэргэжилгүй, 88.5 хувь нь ганц бие залуучууд байна. Харин 35-39 насны эмэгтэйчүүдийн хувьд 80.6 хувь нь гэр бүлтэй, үүнээс 74.2 хувь нь гэр бүлтэйгээ хамтран гар аргаар алт олборлох ажлыг хийж байна.

Зураг 2.01.а Хүн амын нас, хүйсийн суврага
(Шороон ордод ажиллагсад)



Зураг 2.01.б Хүн амын нас, хүйсийн суврага
(Үндсэн ордод ажиллагсад)



Насны байдлаар үндсэн ордод 25-29 насны эрэгтэйчүүд, 35-39 насны эмэгтэйчүүд, шороон ордод 20-24 насны эрэгтэйчүүд, 35-39 насны эмэгтэйчүүд илүү ажиллаж байна.

Шороон ордод гар аргаар алт олборлогсдын 61.3 хувь нь эрэгтэй, 38.7 хувь нь эмэгтэй, хүйсийн харьцаа 1.6 бол үндсэн ордод 71.4 хувь нь эрэгтэй, 28.6 хувь нь эмэгтэй, хүйсийн харьцаа 2.6 байна.

Судалгаанд хамрагдсан гар аргаар алт олборлогсдын хувьд голч нас нь 33, (хүн амын насны хувьд медианаар тооцсон нас, судалгаанд хамрагдагсдын 50 хувь нь 33-аас бага настай, 50 хувь нь 33-аас дээш настайг харуулж байна) дундаж нас нь 33.8 бөгөөд 20 настай хүмүүс хамгийн их ажиллаж (судалгаанд хамрагдагсдын хувьд мода-р тооцсон нас, 20 настай хүн бусад наснаас хамгийн олон тохиолдсон) байв.

Гар аргаар алт олборлогсдын насны байдлаас харахад залуучууд их байгааг харж болно.

Хүснэгт 2.1 Судалгаанд хамрагдсан гар аргаар
алт олборлогсдын хувийн жин, сонгосон үзүүлэлтүүд,
ажиллаж буй ордоор

Сонгогдсон үзүүлэлт	Ажиллаж буй орд		Нийт
	Үндсэн орд	Шороон орд	
Хүйс			
Эрэгтэй	71.4	61.3	64.7
Эмэгтэй	28.6	38.7	35.3
Насны бүлэг			
15-24	23.3	22.2	22.6
25-34	31.6	30.1	30.6
35-44	24.8	30.8	28.8
45 ба түүнээс дээш	20.3	16.9	18.0
Гэрлэлтийн байдал			
Огт гэрлээгүй	28.6	30.8	30.1
Гэрлэсэн	64.7	63.9	64.2
Салсан	2.3	1.9	2.0
Бэлэвсэн	4.5	3.0	3.5
Хамтран амьдардаг	0.0	0.4	0.3
Тухайн орон нутагт бүрдүүлсэн байдал			
Бүртгэлтэй	57.9	44.4	48.9
Бүртгэлгүй	42.1	55.6	51.1
Бүгд	100.00	100.00	100.00
Нийт гар аргаар алт олборлогсдын тоо	133	266	399

Судалгаанд 15-аас дээш насны гар аргаар алт олборлогч иргэдийг хамруулсан бөгөөд 45 ба түүнээс дээш насны хүмүүс нийт гар аргаар алт олборлож байгаа иргэдийн хамгийн бага хувийг эзэлж байв.


Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь гэр бүлтэй хүмүүс байсан ба үндсэн болон шороон ордод ажиллаж байгаа иргэдийн гэрлэлтийн байдал ойролцоо байна.

Үндсэн болон шороон ордод гар аргаар алт олборлогсдын шилжилт хөдөлгөөнийг судлахад өөр орон нутгаас ирсэн иргэд тал хувийг нь эзэлж, тухайн орон нутгийн иргэний бүртгэлд бүртгүүлээгүй, шилжилт хөдөлгөөн хийлгээгүй байна.

2.2 Нийгэм эдийн засгийн шинж байдал


Судалгаанд хамрагдагсдын боловсролын түвшинг нийт гар аргаар алт олборлогсдын хүйсээр харьцуулан Зураг 2.2-т харуулав.

Зураг 2.02 Судалгаанд хамрагдсан гар аргаар алт олборлогсдын боловсролын түвшин, хүйсээр



Нийт судалгаанд хамрагдагсдын 42.4 хувь нь бүрэн бус дунд, 34.6 хувь нь бүрэн дунд, 9.3 хувь нь мэргэжлийн болон техникийн, 7.5 хувь нь бага боловсролтой, 3.3 хувь нь боловсролгүй хүмүүс байсан. Гар аргаар алт олборлогсдын боловсролын түвшин нь хүйсийн байдлаар нилээд ялгаатай байна. Бүрэн бус дунд боловсролтой эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 10 пунктээр, бүрэн дунд боловсролтой эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 7 пунктээр тус тус өндөр байлаа. Дээд боловсролтой боловч мэргэжлийнхээ дагуу ажилладаггүй, гар аргаар алт олборлож байгаа иргэд нийт судалгаанд хамрагдагсдын 3 хувь байгаа ба хүйсийн хувьд эмэгтэйчүүд 0.8 пунктээр илүү байна.

Зураг 2.03 Боловсролын түвшин насын бүлгээр, хувийн жин



Гар аргаар алт олборлогсдын хувьд мэргэжлийн болон техникийн боловсролтой иргэдийн 56.8 хувь нь 35-44 насынхан, боловсролгүй иргэдийн 56.8 хувь нь 35-44 насынхан, 24.3 хувь нь 25-34 насынхан байгаа бөгөөд бусад боловсролын шатлалд 15-24 насын залуучуудын боловсролын түвшин бага байгаа нь харагдаж байна.

Боловсролгүй гэж хариулсан гар аргаар алт олборлогсдын 2.5 хувь нь бичиг үсэг мэддэг, харин 0.8 хувь нь огт бичиг үсэг мэдэхгүй байгаа байдал нь хүйсийн хувьд ялгаатай буюу эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс доогуур түвшинд байв.

Хүснэгт 2.2 Судалгаанд хамрагдагсдын нийгэм,
эдийн засгийн шинж байдал, хувийн жин

Сонгогдсон үзүүлэлт	Ажиллаж буй орд		Нийт
	Үндсэн орд	Шороон орд	
Давхар ажил эрхлэлт			
Ажил эрхэлдэг	16.5	24.4	21.8
Ажил эрхэлдэггүй	83.5	75.6	78.2
Мэргэжлийн чиглэл			
ХАА	9.0	18.0	14.8
Боловсролын	1.5	2.3	2.0
Техник, мэргэжлийн	45.1	30.1	34.8
Эрүүл мэндийн	1.5	0.8	1.0
Эдийн засгийн	3.0	1.1	1.8
Худалдаа үйлчилгээний	6.8	6.8	6.8
Хууль, хяналт, хүчний байгууллага	0.0	0.4	0.3
Мэргэжилтүй	33.1	41.0	38.3
Гар аргаар алт олборлох ажил эрхлэж буй хугацаа			
1 жил	15.8	19.2	18.0
1-2 жил	12.8	11.7	12.0
2-5 жил	36.1	30.5	32.3
5-7 жил	18.0	21.4	20.3
7-10 жил	13.5	14.3	14.0
10 түүнээс дээш жил	3.8	3.0	3.3
Нийт	100.0	100.00	100.00
Гар аргаар алт олборлож буй дундаж хугацаа(жилээр)	4.2	4.1	4.1
Нийт гар аргаар алт олборлогсдын тоо	133	266	399

Тайлбар: Мэргэжлийн чиглэлийг давхардсан утгаар тооцсон болно.

Гар аргаар алт олборлогсдын хувьд давхар ажил эрхлэлтийн байдал харьцангуй бага байлаа. Гар аргаар алт олборлохоос гадна өөр ямар нэг төрлийн ажил давхар эрхэлдэг иргэд, давхар ажил эрхэлдэггүй иргэдээс 57 пунктээр бага байгаа ба үндсэн болон шороон ордод гар аргаар алт олборлогсдын давхар ажил эрхлэлтийн байдал 21.8 хувь байна. Мэргэжлийн хувьд үндсэн болон шороон орд дээр ажиллаж байгаа иргэдийн дунд нилээд ялгаа ажиглагдсан. Үндсэн орд дээр ажиллаж байгаа иргэдийн 66.9 хувь нь, шороон орд дээр гар аргаар алт олборлогсдын 59.0 хувь нь ямар нэгэн мэргэжилтэй байгаа ба үүнээс техник, мэргэжлийн чиглэлийн мэргэжилтэй иргэд бусад чиглэлийн мэргэжлээс харьцангуй илүү байна. Харин мэргэжилгүй иргэд үндсэн ордод 33.1 хувь, шороон орд дээр 40.9 хувь байна.

Судалгаанд хамрагдагсдын 32.3 хувь нь гар аргаар алт олборлох ажлыг 2-5 жил хийж байгаа бөгөөд энэ ажлыг эрхэлсэн дундаж хугацаа 4.1 жил байна.

2.3 Ажиллаж, амьдарч буй ахуйн нөхцөл

Энэ хэсэгт судалгаанд хамрагдсан гар аргаар алт олборлогсдын ахуйн нөхцлийн ерөнхий байдлыг харуулав. Тэд алт олборлох газартаа гэр, урц, жижиг модон байшин маягийн сууцанд явуулын байдлаар амьдарч байгаа бөгөөд амьдарч буй байдлаар нь явуулын ба суурин гэж хувааж үзэх боломжтой байна. «Явуулын» алт олборлогч гэдэг нь сумын төв, тухайн уурхайгаас хол газар амьдардаг хүмүүс өдрөөр, 7 хоног, сараар гэх мэт хугацаагаар ирж ажилладаг ба тухайн газартаа ойр амьдардаг хүмүүс нь өдрийн цагаар ажиллаад оройдоо буцдаг бол холын хүмүүс нь тэнд гэр хөлслөх, таньдаг айлдаа түр амьдрах зэргээр ажилладаг байна.

«Суурин» алт олборлогч гэдэгт 6 сараас дээш хугацаатайгаар тухайн уурхайд ажиллаж амьдарч байгаа өөрийн гэр сууцтай иргэдийг хамруулж болох юм.

Амьдарч байгаа орчны хувьд Өвөрхангайн Уянга сумын Өлтийн уурхайн айлуудын хувьд хот айлууд нэгдэж, эсхүл хамаатан саднаараа буусан, харин жижиг уурхайн айлууд нь 1-2 өрхөөрөө нэгдэж, уурхайн орчимд жалга, гуу бараадан суурьшжээ.



Сэлэнгэ, Орхонтуул, Тооройн мод, 2006 он, 11 сар

Өвөрхангай, Уянга. Өлтийн уурхай, 2006 он, 11 сар

Гар аргаар алт олборлогсдын хувьд ажлын байр, амьдрах орчин буюу сууц нь нэг дор байдгаас алт олборлох явцад үүсдэг эрсдэлт хүчин зүйлсийн нөлөөнд 24 цагийн туршид өргөж эмгэг үүсэх «хүч нэмэгдүүлэх» шалтгааны нөлөөнд байнга байна гэж дүгнэх үндэслэлтэй юм. Өөрөөр хэлбэл, алт олборлох ажлын үед үүсэх тоос, дуу шуугианы нөлөө, гэртээ оройд алтаа угаах зэрэг үйл ажиллагааг хийж байгаагаас тухайн хүний эрүүл мэндэд тэдгээрийн үзүүлэх нөлөөний хугацаа, давтамж, үйлчлэл их байх боломжтой байна.

Тэд гэрийг амьдрах, амрах орчин болгохын зэрэгцээ хүн цөөнтэй айлуудын хувьд бусдыг байрлуулах, түрээслэх, гэр «хоолны газар», «баар», «дэлгүүр» зэрэг үйлчилгээний газар болгон ашиглаж байна. Бидний ажиглалтаар гар аргаар алт олборлогч ихтэй Баянхонгорын Алтан ус, Өвөрхангайн Уянга зэрэг газарт нэг гэрт дунджаар 6-8 хүн амьдарч, зарим гэрт 10 гаруй хүн өдөр, шөнийн цагаар ээлжээр амарч байв. Хүний амьдрах орчны хүрэлцээ буюу нэг хүнд ноогдох талбай нь эрүүл ахуйн стандарт хэмжээнээс бага байлаа. Түүнчлэн «суурин» айлын хувьд арай илүү

тохиолд байсан бол явуулын гэрт зөвхөн гал түлэх зуух, унтах дэвсгэрээс өөр зүйл байхгүй байлаа. Орчны тааламжгүй нөлөө, алт олборлох хүнд нөхцлөөс гадна амьдарч буй орчин нь хүний амьдралын наад захын шаардлагыг хангахгүй байна.

ШИГТГЭЭ 2.1 Энд ирээд 2 сар болж байна. Хувцсаа тайлж хөнжилд унтсангүй удаа. Усанд орох, юм угаах талаар мартсан. Угаагаад ч ялгаа алга, орчин нь ийм болохоор дахиад л тоос, шороо болчихдог юм чинь.

Өвөрхангай, Өлтийн уурхай. «Д» 34 настай эрэгтэй,

Гар аргаар алт олборлогсдын хувьд тухайн нутаг оронд очиж ажиллах үед хамгийн түрүүнд тохиолддог бэрхшээл, хүндрэлийг Зураг 2.4-д харууллаа.

Зураг 2.04 Алт олборлох үед тохиолддог бэрхшээл, хувийн жин



Гар аргаар алт олборлох ажил эрхлэх үед хамгийн их тохиолддог бэрхшээл нь ус, цахилгаан, гэр оронтой байхаас илүүтэйгээр дарагдаа, нурал, осол гэмтлээс айх, түгшүүртэй байдал гэж судалгаанд хамрагдагсдын дийлэнхи нь хариулснаас үзэхэд тэдний хувьд байр, хоол, хувцас зэрэг хүний суурь хэрэгцээнээс илүүтэйгээр сэтгэлзүйн бэрхшээл давамгайлж байгааг нотолж байгаа юм.

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдагсдын хүйсийн харьцаа 1.8 байгаа бөгөөд 20-24 эрчүүд ганцаараа, 35-39 насны эмэгтэйчүүд гэр бүлийн хамт гар аргаар алт олборлож байна. Тэдний голч нас 33 байв.
- Нийт судалгаанд хамрагдагсдын 42.4 хувь нь бүрэн бус дунд боловсролтой, боловсролын түвшин нь хүйсийн байдлаар нилээд ялгаатай буюу бүрэн бус дунд боловсролтой эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 10 пунктээр, бүрэн дунд боловсролтой эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 7 пунктээр тус тус өндөр байна.

3. Судалгаанд хамрагдагсдын 32.3 хувь нь гар аргаар алт олборлох ажлыг 2-5 жил хийж байгаа бөгөөд энэ ажлыг эрхэлсэн дундаж хугацаа 4.1 жил байна.
4. Алт олборлох амьдарч буй байдлаар нь явуулын ба суурин гэж хувааж үзвэл явуулын ажиллагсдын хувьд илүү тав тухгүй, эрүүл ахуйн шаардлага хангагүй орчинд байна.
5. Гар аргаар алт олборлогсдын ажлын байр, амьдрах орчин буюу сууц нь нэг дор байдгаас алт олборлох явцад үүсдэг эрсдэлт хүчин зүйлсийн нөлөөнд 24 цагийн туршид өртөж байгаа тул тэд эмгэг үүсэх «хүч нэмэгдүүлэх» шалтгааны нөлөөнд байнга өртөж байна.
6. Тэдний хувьд алт олборлох ажлыг эрхлэх үед хамгийн их тохиолддог бэрхшээл нь ус, цахилгаан, гэр оронтой байхаас илүүтэйгээр дарагдах, нурах, осол гэмтлээс айх, түгшүүртэй байдал гэж үзэж байгаа нь «байр, хоол, хувцас зэрэг хүний суурь хэрэгцээнээс» илүүтэйгээр сэтгэл зүйн бэрхшээл давамгайлж байгааг харуулж байна

Бүлэг III

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД



Бүлэг III. Нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлууд

3.1. Шилжилт хөдөлгөөн, иргэний бүртгэл

Хүн амын шилжих хөдөлгөөн нь Монгол улсын үндсэн хуулиар баталгаажуулсан эрхийн нэг бөгөөд иргэн бүр улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, амьдрах орчноо бүрдүүлэх, нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох, нийгмийн суурь тусламжийг хүртэх эрхтэй.

Монгол улс хүн амын дотоод шилжих хөдөлгөөний асуудлыг Үндсэн хууль, Иргэний бүртгэл, Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын болон бусад холбогдох хууль эрх зүйн баримтаар зохицуулж байна.

Бид гар аргаар алт олборлогсдын шилжилт хөдөлгөөнд оролцож буй байдал, тэдгээрийн иргэний бүртгэлийн хамрагдалт, бүртгэлтэй холбоотой тэдэнд тохиолдож буй бэрхшээл зэргийг энэ бүлэгт харуулав.

Судалгаанд хамрагдсан сумдын нутагт ажиллаж буй гар аргаар алт олборлогсдын 85.2 хувь нь орон нутгийн, 14.8 хувь нь гадны иргэд байлаа. Харин Сэлэнгэд ажиллагсдын 70.2 хувь нь орон нутгийн, 29.8 хувь нь өөр аймаг, хотоос ирэгсэд байна.

Архангайн Цэнхэр сум, Өвөрхангайн Батөлзий, Уянга суманд ажиллагсдын дийлэнх нь тухайн сумын болон ойролцоо сум, аймгийн төвийн иргэд байсан. Энэ нь өвлүүн улиралд ихэвчлэн байнга ажилладаг, тухайн орон нутагт амьдардаг иргэд байдагтай, нөгөө талаар алтны гарцын хэмжээтэй холбоотой байж болох юм. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Архангай, Сэлэнгэ, Төв аймагт 2-3 жилийн өмнө алтны гарц их үед түр хугацаагаар өөр аймаг, хотоос ирж ажиллагсад давамгайлж байсан бол алтны гарц буурсантай уялдан иргэд буцсан гэж нутгийн иргэд, удирдлагууд өгүүлж байв.

Гар аргаар алт олборлогсдын тоо нь улирлын байдлаас ихээхэн шалтгаалдаг бөгөөд дулааны улирал, оюутан, сурагчдын амралт эхэлсэн үед ажиллагсдын тоо эрс нэмэгдэн, тухайлбал Өвөрхангайн Уянга сумын Өлтөд 10 000 -15 000 орчимд хүрдэг гэж дурьдаж байв.

Гар аргаар алт олборлогсдын ихэнх нь гэр бүлээрээ ажилладаг, түүнчлэн нь тэдний 65.2 хувь нь нэгээс дээш жил ажиллан суурьших хандлагатай байгааг харуулж байна. Ажиллаж буй дундаж хугацаа 3.0 жил байсан бөгөөд тэдний 25.0 хувь нь 1-3 жил, 15.5 хувь нь 3-5 жил ажилласан байв (Хүснэгт 3.1).

Уурхайд гэр бүлээрээ, хамаатан саднаараа ажиллах хандлага нийтлэг ажиглагдсан бөгөөд энэ нь гар аргаар алт олборлолт нь ганцаараа ажиллах боломжгүйг, нөгөө талаас тэднийг «баг»-аар буюу нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулж ажиллахад дөхөмтэйг харуулж байна .

Хүснэгт 3.1 Гар аргаар алт олборлогсдын
ам бүлийн тоо, ажиллаж буй хугацаа

Сонгогдсон үзүүлэлт	Ажиллаж буй орд		Нийт
	Үндсэн орд	Шороон орд	
Тухайн уурхайд ажиллаж байгаа ам бүлийн тоо			
Ганцаараа	57.9	39.1	45.4
2 хүн	21.8	37.2	32.1
3-4 хүн	12.8	16.5	15.3
5-аас дээш хүн	7.5	7.1	7.3
Тухайн уурхайд ажиллаж байгаа хугацаа			
3 сар хүртэл	10.5	18.0	15.5
3 сараас 1 жил	20.3	18.8	19.3
1-3 жил	24.1	25.6	25.1
3-5 жил	18.0	14.3	15.5
5-7 жил	17.3	12.0	13.8
7 жилээс дээш хугацаанд	9.8	11.3	10.8
Тухайн уурхайд ажиллаж байгаа (жилээр)	3.2	2.9	3.0
Бүгд	100.0	100.0	100.0
Хүний тоо	133	266	399

Иргэд нийгмийн суурь тусlamж үйлчилгээг хүртэхэд иргэний бүртгэлийн бичиг баримтууд зайлшгүй шаардлагатай байдаг. Гар аргаар алт олборлогсод иргэний бүртгэлд хамрагдаагүй, бичиг баримтгүйгээс болж ажиллаж буй орон нутгаасаа эрүүл мэнд, нийгмийн тусlamж үйлчилгээг хүртэхэд хүндрэл гардаг тухай өмнөх судалгаанд нилээд дурьдсан байдаг.

Бидний судалгаанд хамрагдагсдын 48.9 хувь нь алт олборлож буй орон нутагтаа иргэний бүртгэлтэй, 51.1 хувь нь бүртгэлгүй байна.

Танд одоогоор иргэний бүртгэлийн ямар нэг бичиг баримт байгаа юу гэсэн асуултанд гар аргаар алт олборлогсдын дийлэнх нь иргэний үнэмлэхтэй, тал хувь нь эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй гэсэн хэдий ч 25.1 хувь нь ямар ч бичиг баримтгүй гэжээ. (Зураг 3.1)

Зураг 3.01 Иргэний бичиг баримттай эсэх, хувийн жин



Хэдийгээр судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь нутгийн уугуул оршин суугч байсан боловч тэдний 25.1 хувь нь иргэний ямар нэг бичиг баримтгүй иргэд байгаа нь шилжин суурьшигчдаас гадна орон нутагт бүртгэлгүй иргэд нилээд байгааг харуулж байна. Энэ нь тэд явуулын байдлаар алт олборлох ажлыг эрхэлж буйгаас бүртгүүлэх сонирхол бага, нөгөө талаас орон нутгийн засаг захиргаа иргэдийг бүртгэлд хамруулах талаар анхаарал тавьдаггүйтэй холбоотой байж болох юм.

Сумын засаг дарга, түүний орлогч нараас тухайн сумын нутаг дэвсгэр дээр гар аргаар алт олборлож байгаа иргэдийг бүртгэлд хамруулахын тулд хийсэн болон цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлууд болон тэдний хандлагыг тодруулан ярилцав.



Өвөрхангай. Уянга, Засаг даргын орлогч, байгаль орчны байцаагчтай хийсэн ярилцлагын үе, 2006 он, 11 сар



Баянхонгор, Баян-Овоо, Гар аргаар алт олборлоч иргэнтэй хийсэн ярилцлагын үе, 2006 он, 11 сар

Сэлэнгэ, Төв, Баянхонгор аймгийн хувьд орон нутгийн удирдлагууд гар аргаар алт олборлогсдыг «нөхөрлөл»—ийн зохион байгуулалтанд оруулж бүртгэлжүүлэх нь зүйтэй гэж өгүүлж байсан бол Өвөрхангай аймгийн Уянга сумын удирдлагууд «тосгоны статус»—тай болговол илүү тохиромжтой гэсэн саналыг хэлж байв. Хэдийгээр судалгаа авах үед Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг дахь Өлтийн уурхайд баримжаагаар 4500 гаруй хүн гар аргаар алт олборлож байсан боловч зундаа 7500–15000 хүрдэг гэж нутгийн удирдлагууд үзэж байна. Алт олборлогсдын тоо тогтмол их байдаг, алтны нөөц ихтэй, ашиглах хугацаа урттай энэ мэт газар ажиллаж буй гар аргаар алт олборлогсдыг сумын оршин суугчаар бүртгэхийн оронд тэднийг тусад нь тостоны статустай болгон, засаг захиргааны өөрчлөлт оруулж, бүртгэлд хамруулах нь илүү оновчтой гэж сумын засаг даргын орлогч, байгаль орчны байцаагч нар үздэг байна. Одоогийн хэлэлцэж буй гар аргаар алт олборлогсдын хууль хэрэгжихэд тосгоны статустай байх нь илүү гэж тэд бас онцлон хэлж байлаа.

Шигтгээ 3.1 Манай сумын нутагт 5 жилийн өмнөөс алтны албан уурхайн ажиллаж эхэлсэн ба түүнийг дагаад гар аргаар алт облорлогсод ихэссэн. Бид одоогийн хуулийн төсөлд тусгагдсан «нөхөрлөл» гэдгийг 4 жилийн өмнө байгуулан, үйл ажиллагааны дүрмийг нь гарган ажиллуулж үзсэн. Энэ үнэхээр бүтэхгүй ажил юм байна лээ. Нүх дамжаад ажиллаад яваад өгдөг тэднийг олж авах боломжгүй, тэд газар ашигласаны татвар, нөхөн сэргээлт хийхээс зугтаад олдохгүй болдог. Харин тусдаа тосгоны статустай болгоод тэднийг бүртгээд, үйл ажиллагааг нь цэгцэлбэл илүү дээр байх.

Өвөрхангай, Уянга, байгаль орчны байцаагч «Э»

Иргэний бүртгэлтэй холбогдон гарч буй тэдний хандлага, саналыг дараахь 2 хэлбэрт хувааж болно. Үүнд:

1. Тухайн уурхайн алтны гарц, цаашид ашиглагдах хугацаанаас тэнд ажиллаж буй гар аргаар алт олборлогсдын суурьшилт шууд шалтгаалж байна. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Уянга сумын албан уурхайн хувьд цаашид 10–15 жил ашиглах нөөцтэй, алтны олдоц сайн гэж үздэг учир энэ уурхайг дагасан гар аргаар алт олборлогсдыг суурьшуулж, тухайн орон нутгийн бүртгэлд бүртгэх нь зүйтэй.
2. Архангай аймгийн Цэнхэр, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Баянхонгорын Галуут зэрэг сумдад лиценз авсан албан уурхайн алт олборлолтоо зогсоох, гарц муудсан зэргээс түр хугацаагаар ажиллагсад ирээд дахиад алтны олдоц ихтэй газар руу нүүдэг учраас тухайн уурхайг дагасан гар аргаар алт олборлогч иргэд бүртгүүлэх сонирхолгүй, нөгөө талаас орон нутаг ч бүртгэх шаардлагагүй гэж үздэг байна

Түүнчлэн гар аргаар алт олборлох үйл ажиллагаа нь улирлын шинжтэй, явуулын ажиллагсад ихтэй, ялангуяа оюутан, сурагчдын амралт эхэлсэн, урин дулаан үед ажиллахаар ирэгсэд их байдаг учраас түр оршин суурьшигчаар бүртгэх нь илүү зохимжтой гэж сумын засаг дарга, тэдний орлогч нар өгүүлж байна. Бидний судалгаа явуулсан 11 сарын эцсээр өвлийн хүйтэн эхэлж байсантай холбоотой албан уурхайн алт олборлох ажил зогссон, явуулын алт олборлогчид нутаг буцаж, ихэвчлэн нутгийн уугуул иргэд ажиллаж байв. Тэдний хувьд орон нутагтаа бүртгэлтэй учраас эрүүл мэндийн ба нийгмийн халамж үйлчилгээ хүртэхэд хүндрэл байхгүй гэж өгүүлж байсан.

Дээрхи үр дүнгээс харахад гар аргаар алт олборлогсдын ажлыг бүлгээр нь хоршуулан бичил уурхайн зохион байгуулалтанд оруулж ажиллахыг орон нутгийн удирдлага, иргэд дэмжих хандлагатай байна.

3.2 Иргэний бүртгэлийн үеийн хүндэрэл

Явуулын байдлаар ажиллаж, амьдарч байгаа гар аргаар алт олборлогсод нь тухайн орон нутагтаа бүртгүүлэх хандлага бага байгаа нь тэдэнтэй ярилцах явцад ажиглагдлаа.

Иргэдээс иргэний бүртгэлд бүртгүүлээгүй байгаа шалтгааныг тодруулахад 68.1 хувь нь бүртгүүлэх шаардлагагүй, 9.3 хувь нь яаж бүртгүүлэхээ мэдэхгүй гэж хариулжээ. Харин бүртгүүлэх шаардлагатай гэж үзэж буй бүртгэлгүй иргэдийн 32.5 хувь нь шилжүүлгийн бичиг байхгүй, 30.0 хувь нь иргэний үнэмлэх, бусад бичиг баримтгүй, 47.5 хувь нь хаана бүртгүүлэхээ мэдэхгүй байгаа ажээ.

Шигтгээ 3.2 Төр иргэдээ анхаарал тавьж ядуурлын эсрэг арга хэмжээ авахгүй, залуучуудад ажлын байр байхгүйгээс өөрсдийн болон үр хүүхдийнхээ гэдсийг тэжээх гэж энэ ажлыг хийж байна. Хулгай хийж байгаа бишдээ, биднийг сум орон нутгийн захиргаа үзэн ядах, хөөх, татвараар дарамтлах, эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх зэрэг хүндэрэл их байна. Бидэнтэй яг гэмт хэрэгтэнтэй харьцаж байгаа юм шиг харьцдаг. Энд хүмүүс ажиллаж, амьдарч байна. Тиймээс төр засаг анхааралдаа авч зохих ажлыг хиймээр юм. Энэ орон нутгийн харьяат болоод бид яах юм бэ? Алт олдохгүй бол бид өөр газарт очих болно. Тэгээд ч орон нутгийн ачаалал хэтэрнэ гээд бүртгэж авах дургүй. Хуучин орон нутгаасаа шилжүүлэг авах хэцүү, олон бичиг баримт шаардана, заримыг нь бүрдүүлэх учраа ч ойлгохгүй сүүлдээ залхдаг. Харин сургуулийн хүүхдүүдтэй хүмүүс шилжүүлэг хийхгүй бол хүүхэд хохирч байна даа.

Уянга сумын Өлтийн орд, гар аргаар алт олборлогч иргэн «Ү», эрэгтэй, 38 настай.

Бүртгүүлэх шаардлагатай гэж үзэж буй иргэдээс орон нутгийн засаг захиргаанд бүртгүүлэхээр хандаж байсан уу гэж асуухад тэдний 15.0 хувь нь тийм, бусад нь үгүй гэж хариулжээ. Бүртгэлгүй байгаа гар аргаар алт олборлогсдын 67.5 хувь нь эрүүл мэндийн тусламж авахад, 55.0 хувь нь нийгмийн халамж үйлчилгээ хүртэхэд, 32.5 хувь нь энд суурьшихад бүртгүүлэх шаардлагатай гэж үздэг байна.

Хүснэгт 3.2 Иргэний бүртгэлд бүртгүүлэх үеийн хүндрэл, хувийн жин

Үзүүлэлт	Байгууллагаас шалтгаалсан хүндрэл		Нийт	Өөрөөс шалтгаалсан хүндрэл		Нийт
	Тийм	Үгүй		Тийм	Үгүй	
Хүйс						
Эрэгтэй	57.1	66.3	66.0	25.0	66.5	65.6
Эмэгтэй	42.9	33.7	34.0	75.0	33.5	34.4
Насны бүлэг						
15-24	28.6	21.4	21.6	25.0	21.5	21.5
25-34	0.0	33.2	32.0	25.0	31.9	31.8
35-44	28.6	27.3	27.3	50.0	27.2	27.7
45+	42.9	18.2	19.1	0.0	19.4	19.0
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Орон нутгийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхээр хандсан иргэдээс бүртгүүлэх үед гарсан хүндрэлийг тодруулахад тэд 75.0 хувь нь шилжүүлгийн бичиггүй, 52.5 хувь нь бүртгэлийн хураамж төлөх чадваргүй, 25.0 хувь нь бүртгүүлэх аргаа мэдэхгүй гэж хариулснаас харахад иргэдээс өөрсдөөс нь шалтгаалан бүртгүүлэх үед нилээд хүндрэл гардаг байна. Бүртгүүлэх сонирхолтой, бүртгэлийн байгууллагад хандсан иргэдээс тэдэнд нийтлэг тохиолдож байсан шилжүүлгийн бичиг яагаад байхгүй байгаа шалтгааныг тодруулахад шилжүүлгийн бичиг шаардлагатайг мэдээгүй, гээсэн мөн түүнийг авахад их хугацаа зарцуулдаг гэж хариулжээ.

Мөн бүртгэлийн байгууллагын зүгээс тэдэнд учруулж буй хүндрэлд бүртгэлийн ажилтны харилцааны соёл дутмаг (57.1 хувь), бүртгүүлэхэд хэт олон бичиг баримт шаарддаг, шат дамжлага ихтэй (14.3 хувь), бүртгэлийн ажилтантай уулзах боломж муу (28.6 хувь) гэж үзсэн байна. Эдгээр хүндрэлийг Төв, Дархан-Уул аймагт алт олборлодог, бүртгүүлэхээр хандсан иргэд голлон дурьдлаа.

Дээрхи үр дүнгээс үзэхэд иргэд бүртгүүлэх үйл явцын талаар мэдээлэл байхгүйгээс холбогдох баримтадаа бүрдүүлэхгүй байх, нөгөө талаас бүртгэлийн байгууллагын ажилтны зан харилцааны соёл, бүртгэлийн шаталсан явц нь иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна гэж дүгнэж болох юм.

3.3 Ажил эрхлэлт ба орлого

Судалгаанд сонгогдсон аймаг, сумын нутагт гар аргаар алт олборлогсдыг хамруулсан бөгөөд тэдгээр бүлэг хүмүүсийг эдийн засгийн идэвхитэй хүн ам болон орлого олох зорилготойгоор ажил эрхэлж байгаа ажиллах хүч хэмээх ойлголтонд хамааруулж болно. Судалгаагаар алт олборлох болсон шалтгаан, олж буй орлого, түүний зарцуулалт, хуримтлалын асуудлыг тодруулав.

Шигтгээ 3.3 Аав ээж маань нас бараад би эгчтэйгээ алт ухахаар ирсэн. Бид 2 суман дээр огт орлого олдоггүй байсан бол энд ирж ажиллаад ямар ч байсан амьжиргаагаа залгуулаад байгаа учраас эндээ ажилласаар л байна гэж бодож байна.

Өвөрхангай аймаг, Өлтийн уурхай.
О, эмэгтэй, 22 настай

Алт олборлох ажил эрхэлж буй хүмүүсээс энэ ажлыг эрхлэх болсон шалтгааныг тодруулахад 16.5 хувь нь хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөх, 10.2 хувь нь орон байртай болох, 12.5 хувь нь өр зээлээ төлөх, 8.2 хувь нь эмчилгээний зардал олох, 87.2 хувь нь амьжиргаагаа залгуулах зорилгоор гэж хариулжээ (Хүснэгт 3.2). Түүнчлэн тэдний тал хувь нь орлого олох өөр боломжгүй учраас алт олборлох ажил эрхэлж байна гэжээ. Энэ нь орон нутагт ажлын байр хомс, мэргэжилгүй байх зэрэгтэй холбоотой байж болох юм.

Хүснэгт 3.3 Судалгаанд хамрагдсан иргэдийн гар аргаар алт олборлох болсон шалтгаан, насны бүлгээр, хувийн жин

Үзүүлэлт	Насны бүлгээр				Нийт
	15-24	25-34	35-44	45+	
Гар аргаар алт олборлох болсон шалтгаан					
Хүүхдийнхээ сургалтын төлбөр	6.7	6.6	24.4	33.3	16.5
Орон байртай	2.2	10.7	12.2	15.3	10.3
Өр зээлээ	10.0	8.2	17.4	15.3	12.5
Эмчилгээнд	2.2	9.8	6.9	15.3	8.3
Амьжиргаагаа	88.9	88.5	85.2	86.1	87.5
Орлого олох өөр боломжгүй болсон	53.3	52.5	63.5	66.7	58.4
Бусад	3.3	0.8	0.0	1.4	1.3
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Хүний тоо	90	122	115	72	399

Алт олборлох ажил эрхэлж буй шалтгаан нь судалгаанд хамрагдагсдын хувьд ижил бүтэцтэй буюу сонгогдсон аймгуудын хувьд ялгаа ажиглагдсангүй.

Судалгаанд хамрагдагсдын боловсролын түвшин доогуур, мэргэжилтэй хүний тоо бага байгаа нь энэ ажлыг эрхлэх шалтгаан болох үндэслэлтэй бөгөөд тэдний дунд мэргэшүүлэх сургалт явуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 3.4 Гар аргаар алт олборлогсдын хоногт ажилладаг цаг ба өдөрт олборлож буй алтны хэмжээ, хувийн жин

Сонгогдсон үзүүлэлтүүд	Хүйс		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	
Хоногт ажилладаг цаг			
1-8 цаг	32.2	48.9	38.1
9-14 цаг	62.0	46.8	56.6
15 ба түүнээс дээш цаг	5.8	4.3	5.3
Өдөрт олборлож буй алтны хэмжээ (грамм)			
0-1 грамм	84.1	91.5	86.7
2-5 грамм	14.7	7.8	12.3
6 ба түүнээс дээш	1.2	0.7	1.0
Бүгд	100.0	100.0	100.0
Хүний тоо	258	141	399

Хөдөлмөрийн бүтээмж нь нэгж хугацаанд бий болгосон бүтээгдэхүүн, үйлчилгээг хэлдэг бөгөөд алт олборлолтын өдрийн дундаж хэмжээ буюу хөдөлмөрийн бүтээмж нь тухайн орд газрын гарц, ажиллаж байгаа хүмүүсийн ур чадвар, дадлагажилт, нас, хүйс зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.

Алт олборлогсдын хөдөлмөрийн бүтээмжийг судалгаанд хамрагдсан хүмүүсийн насын байдлаар үзвэл 26-35 насын хүмүүсийн хөдөлмөрийн бүтээмж нь бусад насын бүлгийн хүмүүсийг бодвол харьцангуй их буюу өдөрт 2.0-4.0 гр (ойролцоогоор 1 унц¹⁾) алтыг олборлодог байна. Харин эрэгтэйчүүдийн өдрийн хөдөлмөрийн бүтээмж нь эмэгтэйчүүдээс 1-2 пунктээр илүү байна.

Хүснэгт 3.5 Гар аргаар алт олборлогсдын орлогын хэмжээ, ажиллаж буй ордоор, хувийн жин

Өрхийн орлого	Ажиллаж буй орд		Нийт
	Үндсэн орд	Шороон орд	
Өрхийн сарын орлогын хэмжээ			
69,000 төгрөг хүртэл	9.8	13.9	12.5
70,000 -149,000	19.5	23.3	22.1
150,000-299,000	47.4	41.7	43.6
300,000-аас дээш төгрөг	23.3	21.1	21.8
Өрхийн сарын дундаж орлого (төгрөг)	231,879.7	216,041.4	221,320.8
Нийт	100.0	100.0	100.0
Хүний тоо	133	266	399

Гар аргаар алт олборлогсод нь өдөрт дунджаар 0.9 гр (ойролцоогоор 6000 төгрөг²⁾ хүртэлхи алтыг олборлодог бөгөөд зарим өдөрт юу ч олборлохгүй байх тохиолдол цөөнгүй байдаг хэмээн хариулсан байна.

Судалгаанд хамрагдагсдын 57.4 хувь нь тухайн газартаа, 30.9 хувь нь 2-3 газарт, 11.7 хувь нь 4-өөс дээш газарт алт олборлож байна гэж хариулснаас үзэхэд тэдний тал хувийг олон газар дамжин ажиллаж буй «мэргэшсэн» ажилчид гэж үзэх боломжтой байгаа бөгөөд өдөрт олж буй орлогын хэмжээ нь ажилласан жил, ур чадвар, дадал зэргээс хамаарч байгаа учраас тэднийт цаашид албан зохион байгуулалттай бичил уурхайн хэлбэрээр ажиллуулах боломжтой юм.

Шигтгээ 3.4 Би гэр бүлийнхээ хүнтэй Заамарын алтны уурхайд ажиллаж байгаад энд ирсэн. Алт олборлох ажлыг б жил хийж байна. Одоо ямар шороо алттай, тэндээс хэдий хэмжээний алт авах, нүхээ яаж ухах, шороогоо хэрхэн угаах гээд энэ ажилдаа «мэргэшиж» байна. Энд ямар ч туришлагагүй хүмүүс ирээд өдөржин шороо ухаад юу ч олохгүй байгаа нь элбэг. Алт олно гэдэг чинь мэргэжил.

Өвөрхангай, Уянга, гар аргаар алт олборлогч Д, 46 настай, эрэгтэй

1 Монгол Банкны 2006 оны 11 сарын дундаж ханшаар тооцвол 23300 төгрөг байсан.

2 Монгол Банкны 1 унц алтны үнэтэй харьцуулсан.

Өрхийн сарын дундаж орлогын хэмжээг аймгуудаар нь авч үзэхэд Архангай, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай аймгийн уурхайд ажиллаж байгаа иргэдийн өрхийн сарын дундаж орлого нь 100000-300000 төгрөг байхад Баянхонгор аймгийн уурхайд ажиллаж байгаа иргэдийн 57 хувь нь 300000 төгрөг хүртэлх орлоготой, 5 хувь нь 700000 төгрөгөөс дээш орлоготой байна. Эдгээр дүнг «Хүн амын амьжиргааны түвшний доод хэмжээ»-тэй харьцуулан авч үзвэл орон нутгийн 4 бүс болон нийслэл Улаанбаатар хотод тогтоосон хэмжээ (Улаанбаатарын бүсэд амьжиргааны баталгаажих доод түвшин 42800 төгрөг)-ээс 17000-25000 төгрөгөөр илүү буюу дунджаар 60000 төгрөг байна. Энэ нь тэднийг алт олборлох ажлаа үргэлжлүүлэн хийх сонирхол төрүүлж байгаа нэг хүчин зүйл гэж үзэж болох юм. Нөгөө талаар иргэдийн хууль бусаар алт олборлох сонирхлыг ихээр төрүүлдэг нэг гол хүчин зүйл нь одоогийн цалингийн дундаж хэмжээтэй тэнцэх орлогыг харьцангуй богино хугацаанд олж чаддаг явдал юм.

3.4 Алтны борлуулалт ба хуримтлал

Алт олборлогсдын тоо эрс нэмэгдсэнтэй уялдан 2002 оноос эхлэн Монгол банк алт олборлодог хувь хүнээс алт худалдан авдаг болжээ. Олборлосон алтаа борлуулах, түүнийг хадгалахтай холбогдсон зарим асуудлыг судаллаа.

Тэд олборлосон алтаа тухайн нутаг дэвсгэрт оршин байгаа гэр дэлгүүрт (22.0 хувь) эсхүл газар дээр нь монгол хүнд (44.0 хувь) борлуулдаг гэжээ. Олсон алтаа ихэнхдээ орон нутгийн «алтны ченжүүд»-эд өгч борлуулж байгаа бөгөөд тэд харьцангуй бага ханшаар өдөр бүр тэдний гэрээр явж цуглувадаг байна. Заримдаа бараа, архи зэрэг бараа бүтээгдэхүүнээр шууд сольдог бөгөөд хэрвээ тухайн цаг үеийн ханшаар нь авдаг «явуулын банк» ажиллуулбал гар аргаар алт олборлож буй иргэдэд эерэг нөлөөтэй байх хандлага ажиглагдахаас гадна алт олборлогсодод тулгардаг эрсдэлтэй асуудлыг бууруулах боломжтой юм.

Ашиглагдсан шороог дахин олборлож байгаа, алт олборлох тусгай тоног төхөөрөмжгүй өөрөөр хэлбэл түмпэн, шигшүүр, хүрз гэсэн энгийн багаж ашиглан өдөржин ажиллаж байгаа боловч өдрийн орлого бага байгаагаас тэд хуримтлал үүсгэж чадахгүй (88.5 хувь) байгаагийн шалтгаан болдог байж болох юм. Харин мөнгөн хуримтлал бүхий алт олборлогсод (4.5 хувь)-ын хувьд хуримтлалаа арилжааны банкинд хадгалдаг бол 4.0 хувь нь гэрлүүгээ явуулдаг, 0.8 хувь нь бусдад зээлдүүлдэг, 1.8 хувь нь эндээ хадгалдаг хэмээн хариулсан байна.

ШИГТГЭЭ 3.5 Олсон жаахан алтаа алтны ченжүүдийн хэлсэн үнээр өгдөг, заримдаа хоол, хүнс, хувцсаар сольчихдог. Уг нь бололцоо байдал бол төв суурин газар арай өндөр үнээр өгвөл бидэнд хэрэгтэй л байна даа. Чадалтай нэг хэсэг нь ах дүгээрээ дамжуулаад борлуулчихдаг.

Сэлэнгэ, Ерөө, Б.Эмэгтэй, 45 настай

Гар аргаар алт олборлогсдын хувьд алт болон мөнгөө хадгалахтай холбоотой гардаг бэрхшээлд хулгайд алдах, бусдад дээрэмдүүлэх, мөнгө явуулах, шилжүүлэх боломжоор дутмаг байдал гэж хариулжээ.

Судалгаанд хамрагдсан алт олборлогсод алтаа борлуулах хамгийн зохимжтой арга юу вэ? гэсэн асуултанд явуулын банкыг ажиллуулах саналтай байна гэж 35.8 хувь, алтны

ченжүүдийг газар дээр нь ажиллуулах саналтай байна гэж 47.6 хувь нь хариулсан байна.

Алт олборлогч иргэдийг алт олборлож эхэлснээс хойш тодорхой зорилготойгоор зээл авсан эсэх талаар асуухад 16.5 хувь нь зээл авсан бөгөөд нийт зээлийн хэмжээ нь 500000-1000000 төгрөг хүртэл, 83.5 хувь нь зээл аваагүй гэж хариулсан байна.

Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан газарт ажиллаж буй гар аргаар алт олборлогсдын 85.2 хувь нь орон нутгийн, 14.8 хувь нь гаднаас ирсэн иргэд байгаа бөгөөд тухайн газарт ажилласан дундаж хугацаа 3.01 жил байна.
2. Гар аргаар алт олборлогсдын 54.6 хувь нь хоёроос дээш ам бүл, хамаатан, садантайгаа хамтран ажиллаж байгаа болон тэдний алт олборлох чиглэлээр ажиллаж буй мэргэшсэн байдалд нь тулгуурлан нөхөрлөлийн хэлбэрээр бичил уурхайн зохион байгуулалтанд оруулж ажиллуулахад дөхөмтэй байж болох юм .
3. Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь иргэний бүртгэлд хамрагдаагүй байсан бөгөөд бүртгүүлээгүй шалтгаанд бүртгүүлэх шаардлагагүй, бүртгүүлэхээ мэдэхгүй зэрэг хариулт орж байгаа бол бүртгүүлэх шаардлагатай гэж үзэж буй бүртгэлгүй иргэдэд шилжүүлгийн бичиггүй, иргэний үнэмлэх, бусад бичиг баримтгүй, бүртгүүлэхээ мэдэхгүй байх хүндрэл тохиолддог байна. Тэд шилжүүлгийн бичиггүй байгаа шалтгаанаа ийм бичиг шаардлагатайг мэдээгүй, мөн түүнийг авахад их хугацаа зарцуулдагтай холбон тайлбарласан байна.
4. Тэдний алт олборлох ажлыг эрхлэх болсон шалтгаан нь хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөх, орон байртай болох, өр зээлээ төлөх, эмчилгээний зардал олох бөгөөд хамгийн гол шалтгаан нь ажил олдохгүйгээс амьжиргаагаа залгуулах эх үүсвэр болж байгаа гэжээ.
5. Гар аргаар алт олборлолтоос олж буй сарын дундаж орлогын хэмжээ нь Монгол улсын «Хүн амын амьжиргааны түвшний доод хэмжээ»-ээс 20 хувиар их байна.
6. Олборлох үйл ажиллагаанд ашиглаж буй технологи, урьд нь ашиглагдсан шорооноос олборлолт хийж буй, олон цагаар ажилладаг зэргээс болж ихэнхи алт олборлогч иргэд бага орлого олж, олсон орлогынхoo дийлэнх хэсгийг хоол хүнс зэрэг өдрийн хэрэгцээндээ зарцуулж байна.
7. Алт олборлолтоос олж буй орлогын хэмжээ нь ордны төрөл, алт олборлогч иргэний ажилласан хугацаа, дадлага, туршлага, ур чадвараас шалтгаалж байна.
8. Иргэд олсон алтаа борлуулж буй гол хэлбэр нь газар дээр нь бага үнээр хүнсний дэлгүүрт өгөх болон бараагаар солих зэргээр борлуулж байгаа нь хуримтлал үүсгэж чадахгүй байх нэг нөхцлийг бүрдүүлж байна.

Санал, зөвлөмж

1. Гар аргаар алт олборлогч явуулын иргэд, иргэний бүртгэлгүй уугуул оршин суугчдыг иргэний бүртгэлд бүртгэх ажлыг орон нутгаас үе шаттайгаар зохион байгуулж, тэднийг нийгмийн суурь тусламж үйлчилгээнд хамруулах боломжийг бүрдүүлэх
2. Гар аргаар алт олборлогчдыг тэдний сонирхлын дагуу «нөхөрлөл», «баг»-ийн зохион байгуулалтанд оруулж, аж ахуйн нэгж болгон бүртгэлжүүлж, тэдний нийгмийн суурь тусламжинд шаардагдах төсвийг орон нутагт нь хуваарилах асуудлыг шийдвэрлэх
3. Алт олборлогсдын өмнө тулгамдаад байгаа гол асуудлын нэг нь олсон алтаа хадгалах, худалдан борлуулах явдал байдгаас үндэслэн тэдгээр гар аргаар алт олборлож байгаа нутаг дэвсгэрт орон нутгийн нөхцөлд борлуулах арга замыг бий болгох, банкинд газар дээр нь худалдах боломжийг судлах
4. Гар аргаар алт олборлогсдод энгийн, хямд, ашиглаж болохуйц техник, технологийг жижиг зээл олгох, түрээслүүлэх зэрэг замаар тэдний үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажлыг судлан үзэж шийдвэрлэх

Бүлэг IV

АЖЛЫН НӨХЦӨЛ БА ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ



Бүлэг IV. Ажлын нөхцөл ба хөдөлмөр хамгаалал

Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон иргэний хөдөлмөрлөх эрхийг 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн хуулиар «Ажилтан нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах...эрхтэй» /6.1./, «Ажлын байрны зохион байгуулалт нь үйлдвэрлэлийн технологийн шаардлагад зохицсон, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна» /83.1./, «Ажил олгогч нь хөдөлмөрийн нөхцөл, ажил, үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд нөлөө үзүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлнэ» /87. 1, 91.1./ хэмээн заасан байна.

Хөдөлмөрийн харилцаатай холбогдох асуудлыг ЭМНХ-ын сайдын 2000 оны 33 тоот тушаалаар батлагдсан «Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах журам»—аар зохицуулж байна. Гар аргаар алт олборлох үйл ажиллагааны үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл, тэдний хөдөлмөрлөх эрхтэй холбогдсон зарим асуудлыг тодруулан судалсан үр дүнг энэ бүлэгт тусгав.

4.1. Гар аргаар алт олборлогсдын хөдөлмөрийн болон орчны эрүүл ахуйн нөхцөл

Судалгаанд хамрагдсан алт олборлогсдын 33 ажлын байранд эрүүл ахуйн зарим хэмжилт хийж, хяналтын хуудсаар ажиглалтын судалгааг явууллаа.

Гар аргаар алт олборлох явцад тэдний гүйцэтгэж буй ажлыг газар дээр нь ажиглан тухайн орчны тоос, дуу, шуугиан, доргион, агаарын хэм зэрэг үзүүлэлтүүдийг хэмжиж MNS 4930:2000 «Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа ба ерөнхий шаардлага», MNS 4990:2000 «Ажлын байрны орчин, Эрүүл ахуйн шаардлага», MNS 4994:2000 «Доргионы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага, MNS 5002:2000 «Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага» зэрэг норм, стандарттай харьцуулан үнэлгээ өгөв.

Хүснэгт 4.1 Ажлын байрны тоосны өрөнхий хэмжээ

Ажлын байр	Сорьцны тоо	Дундаж хэмжээ мг/м³	Тоосны хэлбэлзэл /range/, мг/м³
Төв аймгийн Жаргалант сум Баянбулагийн тээрэм	1	380.7	380.7
Дархан-Уул аймгийн Шарын гол алтны уурхайн шороон ордны шигшүүр	7	180.2	72.5-379.0
Төв аймгийн Борнуурын Алтны тээрэм	3	71	70-72
Сэлэнгэ аймгийн баянгол сум, чулуу зөөх, бутлах ажлын үед	4	218.5 (ЗДХ-ээс их 7-43.3 дахин их байна.)	99.7-433.3
Тоосны зөвшөөрөгдөх дээд хэмжээ		10 мг/м³	

Алт олборлох бүхий л шатанд (газар ухах, шороо зөөх, шигших, чулуу шороог тээрэмдэх, бутлах үед) тоос ихээр ялгардаг. Түүнчлэн ашигласан газарт нөхөн сэргээлт хийгдэхгүй байгаа учраас алт олборлох ажлын явцад үүссэн сүл шороо, элс тухайн орчинд байнга тоостой орчинг бий болгодог ажээ.



Сэлэнгэ, Баянгол сум, тээрэмдэх үе



Өвөрхангай. Бат-өлзийт, Баруун сөлт, нүхээ гэсгээх, ухах үе

Алт олборлогсдын ажлын байрны тоосны өрөнхий хэмжээг жингийн аргаар хэмжиж тодорхойлоход манай орны эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс (10 мг/м³) ойролцоогоор 7-43.3 дахин их байв. Тухайлбал, Төв аймгийн Жаргалант сумын Баянбулгийн тээрэм дээр тоосны өрөнхий хэмжээ эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 38, Дархан-Уул аймгийн Шарын голын алтны шороон ордны шигшүүрт 7.2-37.9, Төв аймгийн Борнуурын алтны тээрэмд 7.1, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын алт олборлогсдын чулуу бутлах, зөөх ажлын байранд 9.9-43.3 дахин их байлаа.

Хүснэгт 4.2 Судалгаанд хамрагдсан гар аргаар алт олборлогсдын ажлын нөхцөл, ажиллаж буй ордоор, хувийн жин

Үзүүлэлтүүд	Ажиллаж буй орд		Нийт
	Үндсэн орд	Шороон орд	
Ажлын хүнд бэрхшээлтэй нөхцөл			
Тоос ,шороо	86.47	86.47	86.47
Чийг, ус	54.17	50.75	51.88
Хэт халуун	27.82	34.21	32.08
Хэт хүйтэн	72.18	77.44	75.69
Харанхуй	51.88	31.20	38.10
Агааргүй	43.61	48.12	46.62
Давчуу	30.83	37.59	35.34
Гүн	41.35	40.60	40.85
Бусад	0.75	1.88	1.50
Бүгд	100.0	100.0	100.0
Хүний тоо	133	266	399

Тайлбар: Ажлын хүнд бэрхшээлтэй нөхцүүдийг давхардсан утгаас тооцсон.

Зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их тоостой нөхцөлд олон цагаар ажилласнаас алт олборлогсод амьсталын замын ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчин, ялангуяа уушиг тоосжих өвчнөөр өвчлөх эрсдэлтэй байна. Гэтэл энд ажиллаж буй иргэд амьсталын эрхтнийг тоосноос хамгаалах маск, хошуувч зэрэг хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэдэггүй, энэ талын мэдлэгтүй байна.

Алт олборлоход ажлын байр болон хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой хамгийн бэрхшээлтэй зүйлсийг тэднээс тодруулахад 86.5 хувь нь тоос шороо, 75.7 хувь нь хэт хүйтэнд гадаа ажиллах, 51.9 хувь нь ус, чийг ихтэй орчинд алт угаах, 46.4 нь агааргүй, харанхуй, давчуу орчинд ажиллах гэж хариуллаа (Хүснэгт 4.2). Энэ бэрхшээл нь шороон ба үндсэн ордод адил байлаа.

Ажиглалтаас харахад давчuu нүхэнд голлон хүүхэд, жижиг биетэй эмэгтэйчүүд орж ажиллан шороо гаргах, ухах ажлыг хийж байна. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, ЭМНХ-ын сайдын 1999 оны А/204 тушаалд зааснаар эмэгтэй хүн, хүүхдийг «шөнийн ба илүү цагаар, газар дор ажиллахыг хориглосон» байдаг боловч гар аргаар алт олборлогсдын дунд энэ нь зөрчигдсөөр байгаа ажээ. Үүнээс шалтгаалан хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилтөд сөрөг нөлөө гарах, бэртэх, гэмтэх, тэр ч байтугай амиа алдах явдал цөөнгүй тохиолддог байна.

Ажлын байран дахь эрүүл мэндэд үзүүлж буй эрсдэлээс ажилчдыг хамгаалах нэг чухал арга зам нь хувийн хамгаалах хувцас хэрэгсэл учраас тэдэнд түүнийг зөв сонгох, худалдан авах, тогтмол, зөв хэрэглэхэд нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх хэрэгцээ их байгаа нь ажиглагдлаа.

Шигтгээ 4.1 «Ээж нүхэнд багтахгүй болохоор би нүхэнд ордог, эхлээд айдаг байсан, одоо айхаа больсон ...

Өвөрхангай. Уянга.
9 настай Э, эрэгтэй

7 настай зээ хүргээ шороонд даруулж алдсандаа шар махтайгаа хатаж явна даа.
Амьдрахын эрхэнд шороогоо ухаж байна даа...

Баянхонгор, Бөмбөгөр, 75
настай ахмад, эрэгтэй



Баянхонгор, Алтан ус, нүхнээс шороо гаргах үе
Өвөрхангай, Уянга, Газрын дор ажилладаг ээж хүү
хоёр

Газар ухах, чулуу бутлах, тээрэмдэх, шигших үед тухайн орчинд их шуугиан, доргион үүсдэг. Шуугиан, доргион нь зөвшөөрөгдөх хэмжээнээс их үед ажиллагсдын сонгол муудах, амархан ядрах, хөдөлмөрийн чадвар буурах, улмаар яс булчин тулгуур, хөдөлгөөний эрхтэний эмгэг үүсдэг.

Шуугианы ерөнхий түвшинг алт олборлогсдын ажлын байранд хэмжихдээ шуугианыг хэмжигч (Sound levelmeter-TES 1350A) багажаар 45 удаа хэмжиж, үнэлэхэд шуугианы түвшин 5.5 - 110дБА-аар их буюу манай орны эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (85дБА)-нээс 1.1 – 2.3 дахин их байлаа.

Хүснэгт 4.3 Ажлын байрны шуугианы түвшин

Хийсэн ажлын байрны нэр	Хэмжил- тийн тоо	Шуугианы дундаж түвшин, ДБА	Хамгийн их түвшин, ДБА	Хамгийн бага түвшин, ДБА
Сэлэнгэ аймгийн Борнуурын				
Тээрэм	4	93.45	93.4	93.6
Газар ухагч	1	93.6		
Шигшүүр	4	95.5	98	93
Шарын голын Баянбулаг тээрэм				
Баянхонгорын Баян-Овоо сумын Борголтой тээрэм	6	97	98.8	92.5
Баянхонгорын Алтан-ус шороон орд	3	97.9	98.8	96.5
Сэлэнгэ аймгийн Ерөө сум				
Алт угаагч	3	73.6	70	79
Усан буу	3	83.3	82	85
Нүхнээс шороо авах үед	3	52.4	51.9	53.1
Сэлэнгэ аймгийн Баянгол сум				
Чулуу бутлах	1	91.3		
Чулуу тээрэмдэх	3	90.5	90.8	90.3
Сэлэнгэ аймгийн Орхонтуул				
Шороо үрэх ажил (хуурай пивар дээр)	1	195		

Ялангуяа, чулуу үрэх, бутлах, тээрэмдэх ажлын үед 5.5-110 дБА-аар, тээрэм дээр ажиллах үед 8.3-12 дБА-аар зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн шуугиантай орчинд ажиллаж байгаа нь энэ нөхцөлд ажиллагдын сонсгал муудах, дүлийрэх эмгэгт өртөх эрсдэлтэй байгааг харуулж байна. Харин алттай шороог угаах, нүхнээс алтыг гаргах, усан буугаар алт угаах зэрэг ажлын үеийн шуугианы түвшин эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

Ажлын байран дахь доргионы түвшинг хэмжсэн хэмжилтийн дүн, давтамжийг Хүснэгт 4.4-д харуулав.

Хүснэгт 4.4 Ажлын байран дахь доргионы түвшин

Хэмжил хийсэн ажлын байрны нэр	Хэмжил-тийн тоо	Доргионы дундаж түвшин, м ² /с	Хамгийн их утга, м ² /с	Хамгийн бага утга, м ² /с
Сэлэнгэ аймгийн Борнуурын				
Тээрэм	3	0.34-0.30	0.4	0.3
Газар ухагч	2	0.2-0.25	0.25	0.2
Шигшүүр	4	0.8	1.5	0.36
Сэлэнгэ аймгийн Ерөө сум				
чулуу бутлах	3	0.12	0.14	0.1
чулуу тээрэмдэх	1	12.5	15	10
Сэлэнгэ аймгийн Орхонтуул				
Шороо үрэх ажил (хуурай пивар дээр)	1	2.68		

Ажлын байрны доргионы ерөнхий түвшинг доргион хэмжигч (Vibrometer) багажийн тусламжтайгаар 12 удаагийн хэмжилт хийхэд эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (зөвшөөрөгдөх дээд хэмжээ-0.14м/c²)-нээс дунджаар 1.7-19.1 дахин их байлаа. Ялангуяа чулуу бутлах, тээрэмдэх ажлын үед доргион их гарч байна. Энэ нь доргион ихтэй, хүйтэн, чийгтэй (усан дотор алтаа угаадаг) нөхцөлд ажиллаж байгаа ажилчдад яс, булчин, тулгуур хөдөлгөөний эрхтэний эмгэг үүсэх эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

Шуугиан, доргионы түвшин зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их байгаа учраас тээрэмдэх, бутлах багаж хэрэгсэлд нэмж суурилуулдаг доргион, шуугианыг шингээгч, бууруулагчийг зориулалтын багажтай болоход дэмжлэг үзүүлэх, ажилчдын сонсголын эрхтэнийг хамгаалах чихэвч, бөглөө болон гарыг доргиноос хамгаалах зөвлөвчтэй бээлийг хэрэглэх боломжоор хангах, ажиллагдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчнийг эрт оношлон, эмчлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Гар аргаар алт олборлож байгаа хүмүүс гадаа, ил задгай нөхцөлд байнга ажилладаг учраас байгаль цаг уурын тохиромжгүй хүчин зүйлст байнга өртөж байна. Алт олборлож байгаа хүмүүсийн ажиллаж байгаа 8-16 ажлын байранд агаарын температур, харьцангуй чийглэг, агаарын хөдөлгөөнийг хэмжигч багажийн (Thermometer TSI, IR thermometer TES-1326, LCD Digital Hygrometer-3309-50) тусламжтайгаар бичил цаг уурын хэмжилтийг хийхэд ажлын байрны агаарын хөдөлгөөн, харьцангуй чийг манай

орны эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байгаа боловч агаарын температур хэт хүйтэн -25 °C (зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь -15-21°C) хүрсэн үед гадаа алт олборлох ажлыг явуулж байна. Мөн зарим үед чийг ихтэй нөхцөлд ажилладаг, тухайлбал алт угаахын тулд усан дотор 4-6 цаг зогсдог байна.

Хүснэгт 4.5 Ажлын байрны бичил цаг уурын үзүүлэлтүүд

Хэмжилт хийсэн ажлын байрны нэр	Хэмжил-тийн тоо	Темпе-ратур, °C	Харьцаангуй чийг, %	Агаарын хөд-ний хурд, m/s
Сэлэнгэ аймгийн Борнуур Тээрэм	3	16	49-50	0.01-0.2
Газар ухагч	2	3	49-51	0.3-1.1
Шигшүүр	3	-5(7)	50-51	0.2-0.5
Шарын голын Баянбулаг тээрэм	3	-1	49-50	0.2-0.5
Баянхонгорын Баян-Овоо сумын Борголтой тээрэм	2	-5	49-52	
Баянхонгорын Алтан-ус шороон орд	2	-4	53	
Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Дунд өлөнт	2	-3		
Өвөрхангай Уянга	4	-40	48-50	
Өвөрхангай Батөлзий	3	-35		

Тэдний дийлэнх алт олборлох ажлыг хүйтэн нөхцөлд удаан ажиллаж, усан дотор олон цагаар зогсож хийснээс бөөр өвдөх, нүд хавагнах, хөлийн шилбэ янгинаж өвдөх, шээс ойрхон хүрэх зэрэг шинж тэмдэг илэрдэг болсон гэж өгүүлж байсан.

Ийнхүү алт олборлогсдын ажлын хүнд нөхцөл нь тэдэнд сэтгэлзүйн дарамт үүсгэх, архидах, улмаар танхайрах зэрэгт хүргэдэг «дам» нөлөө гэж үзэж болох бөгөөд судалгааны явцад ялангуяа үдээс хойш согтуу, халамцуу хүмүүс их тааралдаж байлаа.

Шигтгээ 4.2 Энэ их хүйтэнд гадаа удаан ажиллахаар голд хүйт ороод хэцүү л дээ. Даарагын эрхэнд архи ууж байна. Тэгээд хэдэн цаг ажиллахаар арай дээр байдаг юм. Олон жил ингэж ажиллаад биегүй болж байна. Залуудаа ч мэддэггүй байж, одоо ч халишираг боллоо. Шээс ойр ойрхон хүрээд, нуруу өвдөөд, өглөөд нүд хавагнаад байдаг болсон.

Өвөрхангай, Уянга, иргэн «Б»,
48 настай, эрэгтэй

4.2 Химиин хүчин зүйлсийн нөлөө

Алтыг шороо, чулуу зэргээс салган авахдаа мөнгөн усыг өргөнөөр хэрэглэж металл мөнгөн ус уурших, тохиромжгүй нөхцөлд хадгалж байгаагаас орчны агаар, хөрс, ус бохирдох зэргээр байгаль орчин, хүн, мал, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

2002 онд МУИС-ийн ХАССТөвөөс хийсэн судалгаагаар Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн алтны үндсэн ордод алт олборлож буй 122 хүүхдийн 37.7 хувь нь мөнгөн усаар алт бариулах ажлыг хийдэг байв. Мөн НЭМХүрээлэнгийн Орчны эрүүл мэндийн судалгааны төвийн судалгаагаар алт олборлогчдын 62.8 хувь нь мөнгөн усыг алт бариулахад хэрэглэдэг бөгөөд түүнд хордох эрсдэл 4.6 дахин их байна гэжээ.

Бид энэ судалгаагаар мөнгөн усаар алт бариулах ажлыг ажиглан бүртгэх, алт бариулах, хадгалах явцад тэдний эрсдэлийг тодруулах, илэрсэн эмгэг шинжийг ярилцан судлав.

Сэлэнгэ аймгийн Борнуурын тээрмийн орчимд гар аргаар алт олборлогсод мөнгөн усаар алт бариулж, мөнгөн ус амьстгал, хоол боловсруулах зам, арьсаар биед нэвтрэн орох боломжтой нөхцөлд ажиллаж байна. Тээрэмдэж шүүсэн шороог мөнгөн устай усаар зайлж шигшээд мөнгөн усаа ууршуулан, гараар базаж шүүгээд мөнгөн усаа дахин ууршуулдаг байна. Энэ үед ууршсан мөнгөн ус амьстгал, арьсаар биед нэвтрэх, гараар базах үед арьсаар мөн бохир гараар хоол, унд барьж идэж уух, тамхи татах, бохь зажлах үед хоол боловсруулах замаар алт олборлогсод болон тэдний гэр бүлийнхэн, ойролцоо оршин суугчдын биед нэвтрэн орох боломжтой байна.

Шарын голын Баянбулгийн алт олборлогсод мөнгөн усаар алт бариулдаг бөгөөд мөнгөн устай ажиллах ихэнх тохиолдолд түмпэн дотор, гар дээрээ алтыг бариулдаг, энэ үедээ хамгаалалтын бээлий, маск хэрэглэдэггүй байна.

Баянхонгорын Баян-Овоо сумын Бортолгойн тээрэм нь автомат ажиллагаатай, тээрмийн тогоонд нэг удаа тээрэмдэхэд 200-300 гр мөнгөн усыг нэмж хийдэг. Мөн тэсэлгээндээ аммонитийг хэрэглэж байна.

Шигтгээ 4.3 *Би гэртээ алт бариулах ажлыг 10 жил хийж байгаагаас сүүлийн 2 жилд гар чичрэх, биеэр улаан тууралт гарах, ядрах зэрэг шинж илэрдэг болсон. 40 гр мөнгөн усаар 5 удаагийн үйлдлээр 1 цэн алт бариулдаг, сард дунджаар 3-4 цэн алт бариулдаг.*

Сэлэнгэ аймгийн Баянгол сум, иргэн «А», 42 настай, эрэгтэй



Сэлэнгэ, Баянгол сум, гэртээ мөнгөн усаар алт бариулж байгаа нь, мөнгөн усыг хадгалж буй байдал

Хүйтний улиралд алт олборлогсод, тухайлбал Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны Дунд-Өлөнт хэмээх газар алт олборлож байгаа хүмүүс алт угаах усаа халаах зорилгоор мод, хуванцар түмпэн зэргийг шатаах үед дутуу шаталтын хортой хий агаарт ялгарч орчны агаарыг бохирдуулаад зогсохгүй ажилчдын нүд, хоолойг хорсгон эмгэгшүүлдэг байна. Мөн алт олборлох хөрс, газраа гэсгээх зорилгоор нүхэнд гал тулэн янз бүрийн хаягдлууд, мод, аргал, хөрзөн (biomass) зэргийг ашиглаж байгаа бөгөөд зарим тохиолдолд угаартах, амиа алдах явдал ч гардаг тухай тэд өгүүлж байв.

Хүснэгт 4.6 Гар аргаар алт олборлогсдын мөнгөн усны хэрэглээ ба хадгалалт

Үзүүлэлт	Боловсролын түвшин						Нийт	
	Бага	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Мэргэжлийн ба техникийн	Дээр	Боловсрол-		
						Гүй		
Мөнгөн усаар алтаа барлуулдаг байдал								
Гар дээр	25.0	30.2	42.2	35.7	20.0	33.3	0.0	34.4
Саванд	100.0	64.2	55.6	57.1	80.0	66.7	100.0	61.6
Бусад	25.0	9.4	11.1	21.4	0.0	33.3	0.0	12.0
Химийн бодис хадгалалт								
Гэртээ	50.0	20.8	33.3	21.4	40.0	0.0	0.0	26.4
Гадаа нүхэнд	25.0	73.6	62.2	71.4	20.0	100.0	100.0	66.4
Бусад	25.0	5.7	4.4	7.1	40.0	0.0	0.0	7.2
Химийн бодис авдаг эх үүсвэр								
Уурхайгаас	0.0	1.9	4.4	0.0	0.0	0.0	0.0	2.4
Хувь хүнээс	50.0	81.1	73.3	71.4	80.0	66.7	100.0	76.0
Захаас	50.0	26.4	33.3	42.9	0.0	33.3	0.0	30.4
Байгууллагаас	25.0	3.8	4.4	0.0	0.0	0.0	0.0	4.0
Бусад	0.0	1.9	2.2	0.0	20.0	0.0	0.0	2.4
Химийн бодистой ус шороогоо хаядаг байдал								
Ус руу	0.0	1.9	8.9	0.0	0.0	0.0	100.0	4.8
Хөрс рүү	75.0	66.0	60.0	71.4	100.0	66.7	0.0	65.6
Нүхэнд	25.0	35.8	28.9	28.6	20.0	33.3	100.0	32.0
Хогын цэг дээр	25.0	17.0	35.6	14.3	0.0	0.0	0.0	20.0
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	30	169	138	37	12	10	3	399

Тайлбар: Давхардсан утгаар тооцсон

Алт олборлогсдын дунд явуулсан асуумж судалгаагаар өдөрт дунджаар 138.4 грамм мөнгөн ус хэрэглэж 1-5 удаа алтаа бариулж байна.

Алтаа мөнгөн усаар бариулахдаа түмпэн саванд (61.6 хувь), гар дээрээ (34.4 хувь) бариулж байна. Мөнгөн усыг гадаа хадгалдаг гэж хариулж байсан ч тэд хэмжээнээс нь хамаарч ихэвчлэн гэр дотроо хүнсний шүүгээ савандаа хоол хүнсний зүйлтэйгээ хамт хадгалж байгаа нь ажиглагдлаа. Мөн мөнгөн устай савны гадна талд шошго байхгүй байгаа нь хүүхэд болон бусад хүмүүс юу байгааг нь мэдэхгүйгээс эсвэл санамсаргүйгээр хэрэглэж хордох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Мөнгөн усаар алт бариулах, ашиглах үед тухайн хүн хордохоос гадна түүнийг буруу хадгалах, хаягдлыг ил задгай хаях зэргээс болж орчин тойрны хүн ам, байгаль орчин бохирдох шалтгаан болж байна.

Гар аргаар алт олборлогсод мөнгөн усыг хувь хүнээс авч хэрэглэдэг, ашигласан мөнгөн ус болон мөнгөн устай шингэн хаягдлаа шууд хөрс рүү (65.7 хувь) асгадаг ажээ. Энэ нь орчны агаар, хөрс, усыг түүнчлэн бэлчээрийг бохирдуулах шалтгаан болж байна.

Үүнтэй уялдуулан мөнгөн усны агууламжийг гол, худгийн уснаас гадна, тэдний хэрэглэж буй торхтой усанд тодорхойлов.

Хүснэгт 4.7 Төв аймгийн Борнуур, Жаргалан сумын уурхай орчмын усны эх үүсвэрүүд дэх мөнгөн усны агууламж (мг/л)

Сумын нэр	Уурхайн газрын нэр	Эх үүсвэрийн төрөл	Зориулалт	Тээрэм хүртэлх зай	Усан дахь мөнгөн усны агууламж
Борнуур	800 үнээний ферм	Голын ус	Сумын хүн амын унд ахуйн хэрэгцээнд	1000 м	0.002 мг/л-ээс бага
		Худгийн ус	Алт олборлогсдын унд ахуйн хэрэгцээнд	300 м	0.002 мг/л-ээс бага
		Торхны ус	Технологийн хэрэгцээнд	Тээрмийн хажууд	0.002 мг/л-ээс бага
Жаргалан	Баянбулаг	Худгийн ус	Алт олборлогсдын унд ахуйн хэрэгцээнд	500 м	0.002 мг/л-ээс бага
		Торхны ус	Технологийн хэрэгцээнд	Тээрмийн хажууд	0.0022 мг/л

Хүснэгт 4.7-д Төв аймгийн Борнуур, Жаргалан сумын алт олборлогсдын болон сумын хүн амын унд ахуйн хэрэгцээнд болон технологийн хэрэгцээнд ашиглагддаг усны эх үүсвэрт агуулагдах мөнгөн усны ионы агууламжийг нэгтгэн харуулав. Усны төрөл бүрийн эх үүсвэрт мөнгөн усны ионы агууламж 0.002 мг/л ($LOD < 0.002$) ба түүнээс бага тодорхойлогдож байгаа нь нэг талаас мөнгөн ус гол төлөв бусад нэгдэлтэй нэгдмэл хэлбэрээр хүрээлэн буй орчинд илэрдэгтэй холбоотой, нөгөө талаас мөнгөн усыг тодорхойлох лабораторийн хамгийн бага хязгаар (LOD)-ийг тогтоох чадавхитай холбоотой. Түүнчлэн хүнд металлууд голын усанд дангаар болон нэгдлийн байдалтайгаар удаан оршдогтуй, голын седимент, орчны хөрсөнд тунаж үлддэг тул дараагийн судалгаагаар мөнгөн усны нэгдлийг голын усны седиментэд тодорхойлж үзэж болох юм.

Хүснэгт 4.8 Төв аймгийн Борнуур, Жаргалан сумын уурхай, тээрэм орчмын хөрсөн дэх мөнгөн усны нэгдлийн агууламж (мг/кг)

Сумын нэр	Mine name	Хөрсөн дэхь мөнгөн усны нэгдлийн агууламж мг/кг
Борнуур	800 үнээний ферм	14.36 mg/kg 8.59 mg/kg
Жаргалан	Баянбулаг	13.67 mg/kg

Хүснэгт 4.8-д харуулснаар хөрсөн дэх мөнгөн усны нэгдэл 8.59 мг/кг–аас 14.36 мг/кг илэрч байгаа нь харьцаангуй өндөр үзүүлэлт бөгөөд энэ нь уурхайн үйл ажиллагаанаас хөрс бохирдож, улмаар экологийн гинжин хэлхээгээр дамжин ургамал, үр тариа, малын бэлчээр мөнгөн усны нэгдлээр бохирдож байгааг харуулж байгаа юм.


Шигтгээ 4.4 Баруун Сөлтийн уурхайд ажилладаг эмэгтэйгээс бага жинтэй, төрөлхийн эмгэгтэй хүүхэд төрсөн. Тэр хүүхэд их өвчлөмтгий байсан, удалгүй эндсэн. Энэ уурхайд ажилладаг хүмүүсээс гарсан хүүхдүүд их өвчлөмтгий, өвдсөн үедээ их хүндэрдэг. Тэр орчимд байдаг малчиid мал нядлах үед гэдэс нь хар, зарим дотор эрхтэн нь чулуужсан байдаг гэж хэлдэг. Энэ нь мөнгөн ус хэрэглэх, мөн алтны дагуу байришсан хөрсний хүнд металлууд ил гарч хөрс, орчныг бохирдуулдагтай холбоотой байж болох юм.

Өвөрхангай, Бат - Олзий, эмч «Ц»

4.3 Хөдөлмөрийн багаж хэрэгсэл ба хөдөлмөрийн хуваарь


Судалгаанд хамрагдсан алт олборлогсод нь нүх ухах, шороо зөөх, шигших, алттай шороог угаах гэсэн үндсэн ажлыг гүйцэтгээд байна.

Зураг 4.01 Гүйцэтгэдэг ажлын төрөл, хүйсээр



Алт олборлогсдын ажлын төрөл тэдний хүйсээс хамаарч байгаа эсэхийг судлахад эрэгтэй ажилчид, эмэгтэйчүүдийг бодвол чулуу бутлах (30.2 хувь), тэсэлгээ хийх (18.9 хувь), газар ухах ажлыг хийдэг бол эмэгтэйчүүд шороо зөөх шигших (80.8 хувь), алттай шороог угаах (76.6 хувь), ус зөөх (48.9 хувь) зэргээр харилцан адилгүй ажлыг хийж гүйцэтгэдэг байна.


Зураг 4.02 Алт олборлогсдын хоногт газар доор ажилладаг хугацаа, цагаар, хүйсээр



Зургаас харахад 15-44 насны, эрэгтэй ажилчид өдөрт дунджаар 5.5-5.8 цаг, харин 15-25, 40-50 насны эмэгтэй ажилчид 2.3–2.7 цаг газар дор тус тус ажилладаг байна.

Гар аргаар алт олборлогсод хүрз (89.5 хувь), шуудай (78.3 хувь), түмпэн (75.5 хувь), хувин (68.8 хувь), лоом (67.8 хувь), жоотуу (64.3 хувь) зэрэг биеийн хүчний хүнд ажил хийхэд зориулагдсан ердийн гар ажиллагаатай багаж хэрэгслүүд зонхилон ашигладаг байна. Эдгээр багаж хэрэгслийг ажиглахад ихэнхдээ хүрз, жоотуу зэрэг нь иргүй, мохoo, шуудай, түмпэн сав нь шаардлагад нийцэх нь ховор байлаа. Энэ нь хөдөлмөрийн багажийн олдоц хомс байдагтай холбоотой байж болох юм. Учир нь тэдний олонхи нь хэрвээ ойролцоо газраас худалдан авах боломж байвал багаж худалдан авна гэж өгүүлж байв.

Зураг 4.03 Алт олборлогсдын хоногт угаадаг шорооны хэмжээ, насны бүлэг, хүйсээр



Гэхдээ биеийн хүчний хөдөлмөрийг хөнгөвчилсөн шигшүүр (34.1 хувь), тээрэм (25.2 хувь), сэнс (17.4 хувь), усан буу (9.7 хувь) зэрэг багаж хэрэгсэл, зарим нэг техникийг олон жил алт олборлож буй санхүүгийн боломжтой хүмүүс нь хэрэглэж байна.

Нүх ухаад «сков» хэмээх багаж хамгийн их хэрэгцээтэй боловч түүний олдоц хомс тул өөрсдөө «монголчилж» хийдэг ажээ.

Тэдний хөдөлмөрийг хөнгөвлөх, бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажлын нөхцөлд нь тохирсон хөдөлмөрийн багаж хэрэгсэл сонгоход нь туслаж, дэмжих, худалдан авах боломжийг бий болгох шаардлага байна.

4.4 Эргономикийн болон осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлс

«Эргономик нь тухайн хүний ажиллах чадвар, биеийн хэмжээс, эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны болон бүтцийн онцлогт нь тохирсон ажлын ачаалал, ажлын байрлал, хөдөлмөрийн багаж хэрэгслийг хэрэглүүлэх замаар хүн-хөдөлмөр хоёрын хамгийн тохиромжтой, шинжлэх ухааны үндэслэлтэй харилцааг бий болгоход чиглэгдсэн хөдөлмөрийн эрүүл ахуйн шинжлэх ухааны нэг салбар юм. Эргономикийн хүчин зүйлс тохиромжгүй байснаас ажилчид яс булчин, тулгуур хөдөлгөөний эрхтэний эмгэг, осол гэмтэлд өртөх, хөдөлмөрийн бүтээмж мую, ядралт их тохиолдох зэрэг сөрөг нөлөөтэй байдаг. Эргономикийн тохиромжгүй хүчин зүйлс нь ажлын ачаалал, хөдөлгөөний давтамж, ажлын байрлал, ажил амралтын горим, хөдөлмөрийн багаж хэрэгсэл зэрэг үзүүлэлтээр тодорхойлогддог.

Гар аргаар алт олборлогсод эргономикийн тохиромжгүй нөхцөлд ажиллаж байгаа болох нь судалгаагаар тогтоогдлоо. Тухайлбал Борнуурын уурхайд гар аргаар алт олборлогсод 40-50 кг жинтэй 3-6 шуудай шороог 3-7 м зайд зөөж байв. Мөн тээрэм дээр ажиллаж байгаа хүмүүс нэг маягийн хөдөлгөөний давталт ихтэй ажлыг хийдэг, нэг цагт 60-аас дээш удаа хүрзээр шороо зөөдөг байна. Шарын голын Баянбулагийн тээрэм дээр ажиллагсад нэг удаад 25-30 кг шороог 5 км зайд үүрч зөөдөг, өдөрт ойролцоогоор 10-15 шуудай шороо зөөж, цагт дунджаар 125 хүрз шороог тээрэмд хүрздэж хийж байв. Баянхонгорын Баян-Овоо сумын Бортолгойн алт олборлогчид 50 кг орчим жинтэй шуудайтай шороог 10 минут тутамд нэг удаа зөөдөг байна. Заримдаа 80 м-ээс 6 км хүртэл газарт шороогоо зөөдөг, мөн тэд шороог гараараа шуудайнд хийж зөөх тохиолдол ч байдаг байна. Тээрмийн машины орчмын ажиллах зайд 3*3м байсан.

Сэлэнгэ аймгийн Орхонтуулын Гадар, Тооройн мод хэмээх газар алт олборлож байгаа хүмүүс өдөрт шуудайтай 25 кг орчим шороог 40 удаа буюу ойролцоогоор бидний ажиглалтаар 1000 кг ачаа үүрч зөөж, буулгаж байв. Мөн тус уурхайд нүхэн дотроос шороог татаж гаргахын тулд хэвтээ байрлалд ажилладаг, өндөрөөс нүх рүү унах, чулуу, шороонд даруулах, халтирч, тээглэж унах, аливаа эд зүйлст цохиулах зэрэг осолд орох эрсдэл өндөртэй нөхцөлд тэд ажилладаг байна.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Нарт хэмээх газар алт олборлогсод 70 кг орчим жинтэй шороо, чулууг 5-10 удаа 15-20м-ийн зайд үүрч зөөдөг буюу өдөрт дунджаар 700 кг ачаа үүрч зөөдөг байна. Мөн Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны алт олборлогсод өдөрт 1500 кг ачаа зөөдөг, тухайлбал нэг удаа 100 кг хүртэл ачаа өргөж зөөдөг. Ачаа зөөх үед юманд тээглэж унах, чулуу, шороонд цохиулах зэрэг осолд орох эрсдэл өндөр байгаа нь ажиглагдлаа.

Өвөрхангай аймгийн Уянга сумын алт олборлогсод 5-15 кг ачааг нүхнээс дээш нь олсоор татаж гаргаад, 400-800м газарт уг шороог зөөж аваачдаг. Мөн нүх ухахад хагас суугаа болон бөгтийсөн байдалд дунджаар 2-3 цаг ажилладаг байна.

Мөн нүхнээс шороо татаж гаргах үед олс тасарч шороонд даруулах, цохиулах зэрэг осолд өртөх аюултай нөхцөлд ажиллаж байна. Ухсан нүхний гүний хэмжээ 5 –50 метр хүртэл, ашиглаж буй олс нь 7-10 хоногийн дараа тасарч, мууддаг нь өндөрөөс унах эрсдэл байгааг харуулж байна.

Шигшүүр дээр ажиллагсад 5 сек тутамд 1 удаа шигшдэг бөгөөд өдөрт 8 цаг орчим нэг маягийн хөдөлгөөний давталт үргэлжилдэг. Заримдаа шигшигч нар газар ухах ажлыг хослуулан хийдэг.

Гар аргаар алт олборлож байгаа хүмүүс ажиллах талбай хүрэлцээгүй, давчуу орчинд ажилладаг нь осол гэмтэлд өртөх нөхцлийг бүрдүүлдэг байна. Борнуурын уурхайн тээрэм дээр ажиллагсад 3^*2 м²-ийн зйтай орчинд, харин газар ухаж байгаа хүмүүс нь 0.5^*1m^2 зйтай давчуу орчинд, Шарын голын Баянбулгийн тээрмийнхэн $0.5-1\text{m}^2$ талбайд үйл ажиллагаагаа явуулж байна. Баянхонгор аймгийн Алтан-Ус шороон ордын нэг нүхний гүн 16 м хүрч байсан ба нүхэн дотор маш бөгчим халуун, агааржуулалт байхгүй байлаа.

Өвөрхангай аймгийн Уянга сумын алт олборлогсод голын мөсөнд цооног ухаж алттай шороог угаах үед мөсөн дээр халтирч унах, мөс ухаадаа гар хөлөө цохих зэрэг жижиг гэмтэлд өртдөг байна. Мөн алттай шороогоо 40-60 м гүнээс, цагт дунджаар 6-7 удаа шороог шуудайлж татаж гаргадаг.

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын алт олборлогсод алт угаах усны эх булаг багатай учраас алттай 20-35 кг жинтэй шороог 1-2 км газарт зөөж угаадаг. Ухсан нүхний хэмжээ нь дунджаар 15-50м-ийн гүнтэй, нүхний амсар хэсэг өргөн боловч гүн рүүгээ илүү нарийссан тул дотор нь хүн мөлхөж ороод хэвтээ байдлаар шороогоо ухаж шуудайлдаг байна. Мөн энэ орчимд 80-120 м-ийн өндөртэй шороон овоолго олноор үүссэн нь байгаль орчинг сүйтгээд зогсохгүй ажилчид, орчин тойрны хүн ам осолд орох эрсдэлийг бүрдүүлж байна. Мөн ажилчид алттай гэсэн газраа булаалдан зодолдож бие

Шигтгээ 4.5 Алт олборлолтын улмаас үүссэн шороон овоо, нүх, гуу зэрэг нь мал, амьтан осолдох, түүнчлэн зарим газарт тээврийн төв замд тулж байгаа нь машин, тэрэг осолдох нөхцөл болж байна. Манай сумын хувьд хөрсний эвдэрлээс гадна бэлчээр маш их сүйдэж байна, тэд тулишинд модыг ихээр огтолж хэрэглээд зогсохгүй, самар жимсийг өвөл зунгүй түүж ойг түймэрдэх, сүйтгэх нь хэрээс хэтэрлээ. Булаг, шанд ширгэж, голдирол нь өөрчлөгдөн, нуга жалгууд «элс, шороон» овоо боллоо. Үүний гол шалтгаан нь хүчирхэг техник ашиглаж буй лицензтэй том компаниуд нөхөн сэргээлт хийхгүй, алт дутуу олборлох, ашигласан газраа бусдад зарж нөхөн сэргээлтээс «бултах» арга хэрэглэж байгаатай холбоотой. Төр засгаас «Ашигт малтмалын тухай хууль», «Бичил уурхай ба гар аргаар алт олборлогсдын тухай» хуулийг боловсруулахдаа цогц байдлаар авч үзэн, орон нутгийн удирдлагууд, холбогдох талуудыг оролцуулан «амь бөхтэй», сайн хууль гаргахад анхаарах нь зүйтэй байна.

Сонгогдсон аймгуудын сумдын засаг дарга, тэдний орлогч, байгаль орчны байцагч нар

биенээ хутгалах, гэмтээх явдал цөөнгүй тохиолддогийг цагдаагийн ажилтнууд өгүүлж байв.

Алттай шороо угаахдаа ажилчид тохиромжгүй албадмал байрлалд буюу хагас суугаа байдлаар 4-8 цагаар ажилладаг. Тухайлбал, чулуу бутлахад (Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Октябрь–Улын алт олборлогсод) хагас суугаа байдалд байнгын бөгтийж ажиллаж байгаа нь эргономикийн тохиромжгүй байрлал тул яс, булчин, тулгуур хөдөлгөөний эрхтэний эмгэг үүсэх эрсдэлтэй байгааг харуулж байна. Мөн уг ажилчид ашиглаж буй иртэй багажинд зүсэгдэх, юманд даруулах, тээглэж, халтирч унах эрсдэл их байна.

Тээрэм дээр ажиллаж байгаа хүмүүсийн ажлын орчин халтирч тээглэж унах эрсдэлтэй байна. Тээрэм болон шигшүүр дээр ажиллаж байгаа ажилчид тээрмийг ажиллаж байхад хүрзээр шороог хийх үед хөдөлгөөнтэй гадаргуутай харьцаж байгаа учраас гарaa гэмтээх, хавчуулагдах зэрэг осолд орох эрсдэлтэй байна.

Газар ухагчид (шруп) өндөрөөс нүх рүү унах, шороонд даруулах, шороо болон бусад зүйлсэд тээглэх, халтирч унах, юманд цохиулах эрсдэл өндөртэй нөхцөлд ажиллаж байна. Мөн хүрз, лоом зэрэг иртэй, гэмтэл үүсгэж болох хөдөлмөрийн багаж зэвсэгтэй ажилладаг тул осолд орох эрсдэл өндөрт тооцож болно.

Баянхонгорын Алтан-ус шороон ордны алт олборлогсод 14-16м-ийн гүн нүхэнд ажиллахдаа бэхэлгээ олс хэрэглэдэг боловч олсны бат бөх чанар муу зэргээс шалтгаалж олс тасарснаас болон халтирч унах, нүхэн дотор шороонд даруулах зэрэг осолд орох эрсдэл өндөртэй нөхцөлд ажиллаж байлаа.

4.5 Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, түүний хэрэглээ

Бид гар аргаар алт олборлогсдыг ажиллах үедээ өмсөж байгаа ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээг хийж буй ажилтай нь уялдуулан газар дээр нь ажиглалт хийв.

Тэд зориулалтын хувийн хамгаалах хувцас хэрэгсэл хэрэглэдэггүй, өөрсдийн өдөр тутам өмсдөг ердийн гутал, хувцастайгаа ажилладаг бөгөөд бээлий, амны маск, шүүгч баг зэргийг огт хэрэглэхгүй байв.

Зөвхөн Өвөрхангай аймгийн Уянга сумын алт олборлогсод цооног ухаж алт угаахдаа ахуйн зориулалттай улаан резинэн бээлий өмсөж байв. Ялангуяа нүх ухах, шороо зөөх болон ажил хийж буй орчинд сүл шороо ихтэйгээс тоос маш их хэмжээтэй байсан хэдий ч маск зүүж буй хүн тун цөөн байсан.




*Алт угаах, нүх ухах, шороо зөөх үед
өмсөж буй хувцас,
Баянхонгорын Алтан Ус,
Өвөрхангайн Уянга*



Гар аргаар алт олборлогсдын нийтлэг хэрэглэж буй хувийн хамгаалах хэрэгсэл нь бээлий, бэхэлгээний олс, маск байна.. Тэдэнд хамгийн их хэрэгцээтэй хувийн хамгаалах хэрэгсэл нь бэхэлгээний олс, комбинзон, маск, хамгаалалтын нүдний шил, усны гутал гэж үзэж байна.

Зураг 4.04 Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл



Судалгаанд хамрагдагсдаас хувийн хамгаалах хэрэгслийг ашиглахтай холбогдон гарч буй хүндрэлийг асуухад тэдний 40.1 хувь нь олдоц мую, үнэтэй, 14.5 хувь нь хаанаас авахаа мэдэхгүй, 12.0 хувь нь ямар хувцас хэрэглэхээ мэдэхгүй, 6.7 хувь нь сонгож чадахгүй гэжээ.

Зураг 4.05 Алт олборлогсдын хөдөлмөр хамгааллын хувцас ашиглахтай холбоотой хүндэрэл



Шигтгээ 4.6 Ярилцлагын үед ямар хувийн хамгаалах хэрэгсэл хамгийн их хэрэгтэй байна вэ гэж асуухад алт олборлогч залуу «Малгайтай цамц байхад л болно. Нүх ухах, шороо зөөхөд толгой, хүзүү рүү шороо ороод байдаг юм» гэж хариуллаа.

Баянхонгор, Алтан ус, «Э» 24 настай, эрэгтэй

Гар аргаар алт олборлогсдын хувийн хамгаалах хэрэгслийг ашиглах түвшин хангалтгүй байгаа нь тэдний хувийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх мэдлэг, хандлага сул байгаатай шууд холбоотой байна

Иймд гар аргаар алт олборлогсдод зориулсан хувийн хамгаалах хэрэгслийн ач холбогдол, хэрхэн зөв сонгох, худалдан авах, тогтмол зөв хэрэглэх талаар сургалт явуулах, аргачилсан зөвлөмж өгөх зэрэг хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх шаардлагатай байгаа юм.

4.6 Ариун цэврийн байгууламж, унд-ахуйн болон технологийн хэрэгцээний усан хангамж

Гар аргаар алт олборлогсдын ажиллаж, амьдарч буй орчинд зориулалтын бие засах газар, гар нүүрийн угаалтуур, ахуйн болон технологийн үйл ажиллагаанаас гарсан бохир усыг зайлцуулах эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байгууламж, цооног зэрэг байхгүйгээс бохир усаа хөрс рүү шууд хаядаг тул хүн ам олноор суурьшсан эдгээр газарт хөрс, ус бохирдох нөхцлийг бүрдүүлж байна.

Тэд ахуйн болон технологийн бохир усаа ил задгай орчинд, ялангуяагуужалгаруухаяжорчныг бохирдуулж байна. Мөн зориулалтын бие засах газар байхгүй, ил задгай бие засдаг. Халуун усны газаргүй, зөвхөн Борнуурт гар аргаар алт олборлогсдын гэр хорооллоос 2 км-ийн зайд халуун усны газар байдаг байна. Тэдний амьдарч буй орчин бохир, ил задгай бие засдаг зэргээс шалтгаалан хүүхдүүд нь ихэвчлэн арьсны эмгэгтэй байхаас гадна, гэдэсний суулгальт халдварт, халдварт шар өвчин их гардаг гэж эмнэлгийн мэргэжилтнүүд дурьдаж байв.

Шигтгээ 4.7 Манай энд жорлон байхгүй.
Анх ирсний дараа ил бие засахад эвгүй байсан.
Одоо ч тоохoo больсон.

Сэлэнгэ, Ерөө, Х, 27 настай, эмэгтэй

Гар аргаар алт олборлогсод унд-ахуйн болон технологийн усны хангамж хүрэлцээ муутай нөхцөлд ажиллаж, амьдарч байна.

Унд-ахуйн усан хангамжийн эх булгийг уурхай тус бүрээр авч үзвэл, Борнуурт гүний худаг байдаг бөгөөд зундаа голын уснаас унд-ахуйдаа хэрэглэдэг. Өдөрт дунджаар 40 л усыг 5 хүн унд ахуйн зорилгоор хэрэглэдэг, харин технологийн усыг гар худгаас зөөж хэрэглэдэг бөгөөд 4-5 шуудай шороог дунджаар 6 тн усаар угаадаг байна. Борнуурын уурхайн алт олборлогсод технологийн бохир усыг 300-500м зайд далан барьж хаяж байлаа.

Шарын голын Баянбулгийнхан технологийн болон унд-ахуйн усaa худгаас машинаар зөөж хэрэглэдэг. Ойролцоогоор 205 кг шороог 6 тн ус зөөж угаадаг байна.

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Гадар, Тооройн мод хэмээх газар гар аргаар алт олборлож байгаа хүмүүс унд-ахуйн болон технологийн усaa 20-1000 метрт байрлах булгаас авч хэрэглэдэг ба нэг хүн хоногт 2-3 литр усыг унд-ахуйдаа хэрэглэж байна.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Октябрь-Уулын алт олборлогсод унд-ахуйн усaa 15 км-ийн зйттай байрлах гүний худгаас авч хэрэглэдэг бөгөөд нэг хүн хоногт 2-3 л усыг унд-ахуйн хэрэгцээндээ хэрэглэдэг байна. Мөн Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны алт олборлогсод нуурын усыг унд-ахуйдаа хэрэглэдэг.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны Дунд-Өлөн хэмээх газрын алт олборлогсод болон Өвөрхангай аймгийн Уянгад өвөлдөө цасны ус, зундаа булгийн усыг унд-ахуйдаа хэрэглэдэг байна.

4.7 Гар аргаар алт олборлогсдын ажил, амралтын горим

Монгол улсын Хөдөлмөрийн хуулийн 5 дугаарбүлэгт зааснаар 7 хоногийн ажлын цаг 40, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 цаг хүртэл гэж заажээ. Гар аргаар алт олборлогсдын хувьд ажлын цагийн үргэлжлэх хугацаа нь алтны гарц, улирлын байдлаас ихээхэн хамааралтай байна. Тэд алттай шороо ихээр олдсон үед болон зуны улиралд өдөрт 8-аас дээш цагаар ажилладаг байна.

Борнуурын алт олборлогсод өдөрт 5-12 цаг, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны Дунд-Өлөнт хэмээх газар алт олборлож байгаа хүмүүс хоногт дунджаар 10-12 цаг ажилладаг бол Шарын голын Баянбулгийн алт олборлогсод 8-19 цаг ажилладаг. Мөн Шарын голын Баянбулгийн алт олборлогсод чулуугаа тээрэмдүүлэх гэж 24 цаг дугаарлан хүлээдэг ажээ. Ачаалал ихтэй үед шөнийн цагаар ажилладаг. Ялангуяа зуны улиралд өдөрт нилээд урт хугацаагаар ажилладаг байна.

Шигтгээ 4.9 Гадаа дулаан үед тэндээ хоолоо идээд, унтаад өгдөг. Алт их үед зундаа цаг наргүй ажиллаад сургалтын төлбөрөө төлдөг явуулын хүмүүс их байдал.
Өвөрхангай. Уянга. «С», 36 настай, эрэгтэй

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Гадар, Тооройн мод хэмээх газар алт олборлож байгаа хүмүүс өдөрт 10–11 цагаар ажилладаг бөгөөд өдөрт 10 минутаас 2 цаг хүртэл хугацаагаар завсарладаг гэсэн байна.

Алт олборлогсод өдөрт 1-2 цаг завсарлаж халуун хоол идэж, унтах, юм ярих байдлаар завсарлагааны цагаа гэртээ өнгөрөөдөг байна.

Өвөрхангай аймгийн Уянга суманд алт олборлож байгаа хүмүүс шөнө нүхээ манаж хонодог, өвөлдөө шөнө нүхэндээ гал түлж гэсгээдгээс хөлдөх, угаартах эрсдэл их байна.

Хүснэгт 4.9 Алт олборлогсдын ажил, амралтын горим

Сонгосон үзүүлэлтүүд	Ажиллаж буй орд		Нийт
	Үндсэн орд	Шороон орд	
Ихэвчлэн ажилладаг улирал			
Өвөл	6.8	2.6	4.0
Зүн	10.5	10.5	10.5
Намар	2.3	3.0	2.5
4 улиралд	80.5	83.8	82.7
Хоногт ихэвчлэн ажилладаг цаг			
Өдрийн цагаар	48.1	65.8	59.9
Шөнийн цагаар	3.0	0.4	1.3
Өдөр, шөнө харгалзахгүй	48.9	33.8	38.8
Ажлын үед завсарлага авдаг хугацаа			
1цаг	39.1	57.5	51.4
2цаг	27.1	18.8	21.6
3цаг	12.8	6.0	8.3
4цагаас дээш	11.3	1.9	5.0
Завсарлага авдаггүй	9.8	15.8	13.8
Өдөрт хооллодог давтамж			
1 удаа	9.8	27.8	21.8
2 удаа	23.3	28.2	26.6
3 удаа	66.2	41.7	49.9
4 удаа	0.8	1.5	1.3
5 ба түүнээс дээш удаа	0.0	0.8	38.8
Долоо хоногт амардаг хугацаа			
1 өдөр	11.3	19.9	17.0
2 өдөр	19.5	11.7	14.3
3 өдөр	12.8	1.1	5.0
3-аас дээш өдөр	11.3	1.1	2.0
Амардаггүй	9.8	66.2	61.7
Хоногт ажилладаг дундаж хугацаа /цагаар/	10.3	9.9	10.1
Нийт	100.0	100.0	100.0
Хүний тоо	133	266	399

Дээрхи хүснэгтээс харахад судалгаанд хамрагдсан гар аргаар алт олборлогсдын 82.7 хувь нь жилийн 4 улиралд алт олборлох үйл ажиллагааг эрхэлдэг бөгөөд үндсэн, шороон ордод ажиллагсдын хувьд улирлын чанартай ажлын ялгаа ажиглагдсангүй.

Шороон ордод ажиллагсдын 65.7 хувь нь, үндсэн ордод ажиллагсдын 48.1 хувь нь өдрийн цагаар ажилладаг бол үндсэн ордын алт олборлогсдын 48.8 хувь нь шороон

ордын алт олборлогсдын 33.8 хувь нь шөнийн цагаар ажилладаг гэж хариулсан байна. Ажлын өдөрт алт олборлогсод дунджаар 10 цаг ажилладаг бөгөөд үндсэн болон шороон ордод ажиллагсдын хооронд ажлын цагийн ялгаа бага байгаа нь дээрхи хүснэгтээс харагдаж байна.

Мөн шороон ордод ажиллагсдын 57.5 хувь нь, үндсэн ордод ажиллагсдын 39.1 хувь нь ажлын үед 1 цаг завсарладаг, 9.7-15.7 хувь нь ямар нэгэн завсарлага авдаггүй гэсэн байна. Ажлын үед завсарлага авдаггүй тохиолдол үндсэн ордтой харьцуулахад шороон орд дээр ажиллагсдад илүү ажиглагдаж (үндсэн ордтой харьцуулахад шороон ордод 6.02 пунктээр илүү) байна. Мөн шороон орд дээр ажиллагсдын 66.1 хувь нь, үндсэн ордод ажиллагсдын 52.6 хувь нь долоо хоног тутамд ямар нэгэн амралтын өдөр байдаггүй гэж хариулсан байна.

Дээрхи үр дүнгийн ажлын өдрийн цаг, ажлын завсарлага, долоо хоногийн амралтын өдөр зэрэг нь алт олдоц, улирлаас хамаардаг, тэдэнд баримтлах хөдөлмөр-амралтын тогтсон горим байдаггүй болохыг харуулж байна.

Судалгаанд хамрагдагсдын 26.1 хувь нь сүүлийн нэг сарын хугацаанд мөнгөгүйн улмаас халуун хоолгүй хонох тохиолдол байсан гэж хариулжээ. Халуун хоолгүй хонох явдал 25 хувьд долоо хоног бүр, 14.4 хувьд сар бүр, 26.9 хувьд зарим сард, 33.7 хувьд сардаа нэгээс хоёр удаа тохиолддог гэжээ.

Дүгнэлт

1. Алт олборлогсдын ажлын төрлийг хүйсээр нь харьцуулан үзэхэд эрэгтэйчүүд чулуу бутлах, тэсэлгээ хийх, мөнгөн усаар алт бариулах ажлыг, эмэгтэйчүүд шороо зөөх шигших, алттай шороог угаах, ус зөөх зэрэг ажлыг хийж гүйцэтгэдэг байна.
2. Гар аргаар алт олборлогсдын ажлын байрны тоос, шуугиан, доргион нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их байна. Энэ нь ажилчид тоосны шалтгаантай ушиг тоосжих, шуугианы гаралтай сонсгол муудах, дүлийрэх зэрэг өвчинд өртөх эрсдэлтэй байгааг харуулж байна. Чулуу бутлах, тээрэмдэх үеийн доргион эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их байгаа нь яс, булчин, тулгуур хөдөлгөөний эрхтэний эмгэг үүсэх эрсдэлийг улам нэмэгдуулж байна.
3. Мөнгөн усаар алт бариулж байгаа алт олборлогсод мөнгөн усны нөлөөнд өртөж, улмаар мөнгөн усны хадгалалт, хаягдлыг зайлзуулж байгаа зэргээс шалтгаалан тэнд ажиллагсдаас гадна орчны ус, хөрс бохирдож байна.
4. Гар аргаар алт олборлогсод эргономикийн тохиромжгүй нөхцөлд ажиллаж, биеийн хүчний хүнд ажлыг хийдэг бөгөөд нэг маягийн хөдөлгөөний давталт ихтэй, биеийн тохиромжгүй, албадмал байрлалд, давчуу зайд ажилладаг, халтирч тээглэснээс унах, юманд цохиулах, даруулах, иртэй болон хөдөлгөөнтэй багаж хэрэгсэлтэй харьцах үед хавчуулагдах, зүсэгдэх зэрэг осол гэмтэлд өртөх эрсдэл өндөртэй байна.
5. Гар аргаар алт олборлогсод зориулалтын хувийн хамгаалах хувцас хэрэгсэл (бээлий, амны маск, шүүгч баг зэргийг) хэрэглэдэггүй, өөрсдийн өдөр тутам

өмсдөг ердийн гутал, ажлын хувцастайгаа ажилладаг бөгөөд хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг сонгох, хэрэглэх мэдлэг, хандлага хангалтгүй байна.

6. Гар аргаар алт олборлогсдын ажиллаж, амьдарч байгаа орчинд зориулалтын бие засах газар, гар нүүрийн угаалтуур, халуун усны газар байхгүй, ахуйн болон технологийн үйл ажиллагаанаас гарсан бохир усыг зайлцуулах эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байгууламж, цооног байхгүйгээс бохир усаа шууд хөрс рүү хаядаг тул хүн ам олноор суурьшсан эдгээр газруудад халдварт өвчин гарч, хөрсний бохирдлыг ихэсгэж байна.
7. Алт олборлогсод унд-ахуйн болон технологийн усны хангамж хүрэлцээ муутай нөхцөлд ажиллаж, амьдарч байна.
8. Ажлын өдөрт алт олборлогсод дунджаар 10 цаг ажилладаг бөгөөд ажлын өдрийн цаг, ажлын завсарлага, долоо хоногийн амралтын өдөр зэрэг нь алтны олдоц, улирлын байдал, цаг агаар зэргээс хамаардаг бөгөөд тэдэнд баримтлах хөдөлмөр-амралтын тогтсон горим байдаггүй байна.

Санал зөвлөмж

1. Гар аргаар алт олборлогсод хөдөлмөрийн эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тоостой, шуугиантай, доргионтой, хэтэрхий хүйтэн, чийг ихтэй нөхцөлд, эргономикийн тохиромжгүй, осол гэмтэлд орох эрсдэл өндөртэй, биеийн хүчний хүнд ажлыг хөдөлмөрийн механикжсан багаж хэрэгсэл бараг байхгүйгээр хийж байгаа учраас албан бусаар алт олборлогсдын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах асуудалд төрийн ба төрийн бус байгууллага, хамт олон, хувь хүн анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Үүний тулд уг судалгаагаар нарийн тодорхойлж, үнэлсэн гар аргаар алт олборлогсдын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын тохиромжгүй /hazards/ хүчин зүйлсийн шалтгааныг арилгах, устгах арга хэмжээг дараахь гурван түвшинд авах.
 - o Эх үүсвэрт авах арга хэмжээ: шуугиан, доргион, тоос, мөнгөн устай эх үүсвэрийг тусгаарлах, чийглэх, хор, аюул ихтэй технологи, химийн бодисыг аль болох хор, аюул багатай технологи, бодисоор орлуулах, хөдөлмөрийн багаж, хэрэгсэл, технологийн бүтэц, үйл ажиллагааг сайжруулах, механикжуулах зэрэг арга хэмжээг авах, ялангуяа мөнгөн усыг хор багатай бодисоор орлуулах бусад орны туршлагыг судалж нэвтрүүлэх, алт бариулахдаа байгаль, орчин, хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй аргыг сонгож хэрэглэх, мөнгөн усны ууршилтыг аль болох багасгасан багаж, хэрэгслийг хэрэглүүлэх, битүүмжлэл сайтай нөхцөлд, хүн амьдардаггүй орчинд алтыг бариулах, алт бариулсан мөнгөн ус, шингэн, хатуу хог хаягдлыг тохиромжтой байдлаар зөв устгаж, зайлцуулах.
 - o Дамжих замд чиглэсэн арга хэмжээ: алттай шороог тээрэмдэх, шигших, чулууг бутлах зэрэг суурь машинд агааржуулалт суурилуулах арга хэмжээ авах
 - o Алт олборлогч хувь хүмүүст чиглэсэн арга хэмжээ: Хувийн хамгаалах хувцас хэрэгслийн ач холбогдол, хангах, зөв сонгох, хэрэглэх талаар сургалт явуулах, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилсан

ба хугацаат үзлэгт хамруулах, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг дээр тодорхойлогдсон хэрэгцээнийх (Хувийн хамгаалах хэрэгсэл, эрүүл хооллолт, ажил амралтын горим, архи тамхи, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар) нь дагуу явуулах.,

2. ЭМНХ-ын сайдын 1999 оны А/206 тоот тушаалаар батлагдсан гараар ачааг байнга өргөх, шилжүүлэх ажлыг цагт 2-с дээш удаа хийж гүйцэтгэх /эрэгтэй 15 кг, эмэгтэй 7 кг буюу түүнээс дээш жинтэй/, өвдөгний үеэр болон явган суух, хэвтээ байрлалд ажлын хугацааны хорин таваас илүү хувьд нь ачаа үүрэх, шилжүүлэх, зөөх ажил үйлчилгээ эрхэлдэг хүмүүс 12 сар тутамд нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт орох журмын дагуу тэднийг эрүүл мэндийн байнгын үзлэгт хамруулах,
3. Гар аргаар алт олборлогсдын дунд тохиолдсон осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөл бүртгэгдэхгүй, мэдээлэгдэхгүй, судлагдахгүй, түүний шалтгааныг нь тогтоохгүй орхигдсоор байгааг анхаарч шинээр боловсруулж байгаа гар аргаар алт олборлогсдын хуулийн төсөлд тухайн орон нутаг өвчлөлийг бүртгэн мэдээлэх, шалтгааныг тодруулах үүрэгтэй байхаар тусгах. Алт олборлох үйл ажиллагаатай холбогдон гарч буй мэргэжлийн өвчин осол гэмтлийн шалтгааныг тогтоон, тэднийг мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговорт хамруулах асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлэх,
4. ЭМНХ-ын сайдын 1999 оны А/204 тушаалын 1-р хавсралтанд дурьдсан эмэгтэй хүн, хүүхэд газар доорхи бүх төрлийн ажил, мөнгөн устай харьцаж ажиллахыг хориглосон заалтыг гар аргаар алт олборлогсдын дунд мөрдүүлэх,
5. Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2002 оны 122 тоот тушаалын дагуу механик үйлчлэлтэй нөхцөлд ажиллагсад буюу нүх ухах, мөс цохих, шороо татаж гаргах зэрэг ажлыг хийж байгаа хүмүүс уналт, нуралт, цохилтоос хамгаалах дуулга, ажлын өмд, цамц, хормогч, нүдний шил зэргийг өмсөх, тоостой нөхцөлд ажиллагсад тухайлбал, тээрэмдэх, чулуу шороог нунтаглах, шигших ажлыг хийхэд амны хаалт зүүх, хамгаалалтын нүдний шил зүүх, ажлын өмд, цамц өмсөх, тээрэм, шигшүүр, чулуу бутлах, үрэх ажил хийж байгаа хүмүүс чихэвч, чихний бөглөөс өмсөх, голын усан дотор зогсоод алттай шороог угаах, мөс цоолох зэрэг ажил хийдэг хүмүүс тусгай зориулалтын чийгнээс хамгаалсан бээлий, хормогч, усны гутал өмсөж ажиллах. Мөн шингэн байдалтай химиийн бодистой харьцаж ажиллагсад буюу мөнгөн усаар алтыг бариулж байгаа хүмүүс тусгай зориулалтын химиийн бодис үл шингэх материалыар хийгдсэн өмд, цамц эсвэл хормогч мөн тусгай зориулалтын бээлий, гутал, малгай, хошуувч, нүдний шилийг хэрэглэх. Энэ талын сургалт, сурталчилгааг мэргэжлийн байгууллага, сайн дурынхан, НЭМ-ийн ажилтнаар дамжуулан гар аргаар алт олборлосдод хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн тусламж, үйлчилгээг хүргэх.
6. ЭМНХ-ын сайдын 2000 оны 213 тоот тушаалын дагуу долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байх бөгөөд ердийн ажлын үргэлжлэх хугацаа 8 хүртэл цаг байх ёстой гэсэн заалт алт олборлогсдын дунд мөрдөгдөх боломжгүй байгааг анхаарч тэдэнд шинжлэх ухааны үндэслэлтэй хөдөлмөр-амралтын горимыг мөрдлөг болгох талаар хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжлийн зөвлөмжийг өгөх, сургалт зохион байгуулах.

Бүлэг V

.....

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ,
ХЭРЭГЦЭЭ**



Бүлэг V. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хүrtээмж, хэрэгцээ

Хүн ямар ч үед эрүүл мэндийнхээ төлөө санаа тавин эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусlamж авах эрхтэй. Энэ эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6-д «Монгол Улсын иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусlamж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн үнэ төлбөргүй тусlamж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно» гэж баталгаажуулсны дагуу уг харилцааг Эрүүл мэндийн тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, Эмийн тухай, Ариун цэврийн тухай зэрэг болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

«Эрүүл мэндээ хамгаалуулах» гэдэг нь эмнэлгийн тусlamж авах, эмчлэн сувилуулах үйлчилгээгээр хангагдах бүрэн боломжтой байх явдал юм. Эрүүл мэндийн даатгалтай нөхцөлд холбогдох хууль, журамд заагдсан эрүүл мэндийн тусlamж үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангагдана.

Иргэдэд төлбөртэй ба төлбөргүй үзүүлэх эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний жагсаалтыг Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлан гаргаж мөрдүүлж байна.

Эмнэлгийн тусlamж үйлчилгээ зарим нөхцөлд төлбөртэй байх боловч тэр нь хүний эрүүл мэндээ хамгаалуулах зүй ёсны шаардлагад нийцсэн байх учиртай гэж үздэг. Энэ судалгааны гол зорилтын нэг нь гар аргаар алт олборлогсдын эрүүл мэндээ хамгаалуулах, тусlamж авах эрхтэй холбогдсон асуудлыг тодруулах явдал юм.

5.1 Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хүrtээмж

Судалгаанд хамрагдагсдын 22.8 хувьд сүүлийн нэг жилийн дотор эмнэлгийн тусlamж авах шаардлага гарсан байна. Энэ нь харьцангуй идэр насны залуучууд ажилладагтай уялдан эмнэлгийн тусlamж авах хэрэгцээ бага гарсан гэж үзэхээс гадна яаралтай, амь насанд аюул учруулсан тохиолдлоос бусад үед эрүүл мэндийн байгууллагад хандах, урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө авах хандлага сул байдагтай холбоотой.

Түүнчлэн иргэдэр эрүүл мэндийн даатгалын хууль, төрөөс хариуцах эрүүл мэндийн тусlamжийн талаар дуттуу дулимаг мэдлэгтэйгээс өөрт шаардлагатай тусlamжийг цаг тухайд нь авч чадахгүй байгаа нь ажиглагдлаа.

Шигтгээ 5.1 *Би б сарын өмнө умайн хорт хавдартай гэж оношилгэдсон ч гурван хүрхдээ тэжээхийн тулд алт олборлож байгаагаа зогсоох боломжгүйгээс эмчилгээнд хамрагдаж чадахгүй байна. Надад эмнэлэгт үзүүлээд явах мөнгө ч байхгүй. Шороогоо ухаж байгаад л үхнэ гэж бодож байгаа.*

Баянхонгор аймгийн Баян-Овоо сум, Б. 52, настай, эмэгтэй

Дээрхи тохиолдолд умайн хорт хавдар гэсэн оноштой, гар аргаар алт олборлогч «Б» ЭМСайдын 2006 оны 393 тоот тушаалд заасны дагуу хэрэв тухайн хавдар гурав, дөрөвдүгээр шатандаа орсон бол эмээр үнэгүй үйлчлүүлэх эрхтэй ч эмчийн хяналт, эмчилгээнд хамрагдахгүй байгаа нь нэг талаас тэдний эмнэлэгт хандаагүй байдал, нөгөө талаас орон нутгийн эмнэлгийн үйлчилгээ гар аргаар алт олборлогсодод хүрэхгүй байгааг харуулж байна.

Эмнэлгийн тусlamж авах шаардлага эрэгтэйчүүдтэй харьцуулахад (16.3 хувь) эмэгтэйчүүдэд илүү (34.8 хувь) гардаг байна. Энэ байдал нь эмэгтэйчүүд өөрийн эрүүл мэндийн төлөө анхаардаг байдал, тэд голдуу усанд зогсож алт угаадаг, хүнд ачаа зөөдөг зэрэг хүнд нөхцөлд хөдөлмөр эрхэлж байгаатай нь холбоотой гэж үзэж болно.



Өвөрхангай Уянга, алт угааж буй эмэгтэйчүүд



Баянхонгор, шороо шигшиж байгаа нь

Алт олборлогсдын 56.9 хувь нь сумын, 16.8 хувь нь аймгийн, 10.5 хувь нь багийн эмнэлгээр үйлчлүүлдэг байна. Тухайлбал Өвөрхангай аймгийн Уянга, Баянхонгор аймгийн Алтан ус, Сэлэнгэ аймгийн уурхайнууд сумын төвд ойрхон байдгаас тэнд ажиллаж буй иргэд сумын эмнэлэгт ихэвчлэн ханддаг бол сум, аймгийн төвөөс хол уурхайд ажиллагсад багийн эмнэлэг, эмчид илүү ханддаг байна.

Ажиллаж буй газрын байршилаас хамааран гар аргаар алт олборлогсод үйлчилгээ авах эмнэлгээ сонгож байгаа боловч багийн эмчийн мэдлэг чадвар, харилцаа зэрэг нь тусlamж авах мэргэжилтнээ сонгоход нөлөөлдөг нь ярилцлагын явцад ажиглагдсан.

ШИГТГЭЭ 5.2 Бид эрүүл мэндтэй холбоотой асуудал гарвал багийн эмчдээ ханддаг.

Олон жил ажилласан туршилагатай, сайхан ааштай хүүхэн байгаа юм. Энэ эмч байхад бид болоод л байна.

Өвөрхангай. Бат - Өлзий. Иргэн «Х», 42 настай, эрэгтэй

Хүснэгт 5.1 Гар аргаар алт олборлогсдын хүртэж буй

эрүүл мэндийн тусlamжийн төрөл

Indicator	Sex		Total
	Male	Female	
Need for medical services in the past year			
Needed	16.3	34.8	22.8
Not needed	83.7	65.2	77.2
Most commonly visited provider			
Emergency	0.8	2.8	1.5
State hospitals	3.9	2.8	3.5
Aimag hospitals	15.1	19.9	16.8
Family doctor's clinics	6.2	7.1	6.5
Soum hospitals	55.8	58.9	56.9
Private clinics	1.9	1.4	1.8
Mine's, bagh's hospitals	12.8	6.4	10.5
Other	3.5	0.7	2.5
Mostly commonly visited provider when ill*			
Doctor	57.0	68.8	61.2
Assistant doctor, nurse	38.8	54.6	44.4
Health volunteer	0.4	0.7	0.5
Chiropractor	3.5	2.8	33.3
Monk	2.7	6.4	4.0
Family members	41.1	23.4	34.8
Friends and relatives	12.0	10.6	11.5
Other	2.7	0.7	2.0
Most common places/types for treatment *			
Ambulance	12.0	14.9	13.0
Visit soum, family doctor	62.4	67.4	64.2
Visit specialized doctor	15.1	18.4	16.3
Visit spa and sanatoriums	1.9	2.8	2.3
Get treatment at hospital	10.5	9.9	10.3
Vaccination	3.1	3.5	3.3
Other	13.2	5.7	10.5
Total	100.0	100.0	100.0
Number of people	258	141	399

Тайлбар: * давхардсан утгаар тооцсон болно

Алт олборлогсдын авч байгаа эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг төрлөөр нь авч үзвэл 64.2 хувь нь анхан шатны, 13.0 хувь нь яаралтай, 10.3 хувь нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, оношуулах, 16.3 хувь нь нарийн мэргэжлийн тусlamж үйлчилгээг авсан байна.

Судалгаанд хамрагдсан алт олборлогсод иргэний бүртгэлтэй эсэхээс үл хамааран өвдсөн үедээ давхардсан тоогоор авч үзвэл ихэвчлэн эмнэлгийн мэргэжилтэнд цөөнхи нь наиз нөхөддөө ханддаг байна. Эндээс хараход тэд хэрэгцээ гарсан үедээ ойролцоо аймаг, сумын эмнэлгийн их эмчид ханддагаас гадна тэдэнд иргэний бүртгэлтэй эсэхийг үл хамааран сум, орон нутгийн эмнэлэг тусlamж, үйлчилгээ үзүүлж байгааг харуулж байна.

Орон нутгийн эмнэлэгт алт олборлогсдоос үүдсэн ачаалал нэмэгдэх, эмч, эмнэлгийн ажилчдыг сүрдүүлэх, эмнэлгийн төсөв хүрэлцэхгүй байх зэрэг хүндрэл учирдаг талаар сум, орон нутгийн удирдлага, сумын эмч наортай хийсэн ярилцлагад дурьдагдаж байлаа.

Сумын эмнэлгийн ачаалал тухайн сумын нутагт ажиллаж буй гар аргаар алт олборлогсдын тооноос хамаарч янз бүр байдаг. Жишээ нь, Уянга, Ерөө сумын эмнэлгийн амбулаторийн үйлчилгээний 70 хувийг тус сумын харьяаллын бус алт олборлогсод үзүүлсэн үзлэг эзэлж, жилд дунджаар 20 гаруй харьяаллын бус алт хүн гэмтэл, мэс заслын өвчний улмаас хэвтэн эмчлүүлж, эмнэлгийн жилийн төсвийн 10 гаруй хувийг тэдэнд зарцуулдаг байхад Цэнхэр, Бат-Өлзий, Жаргалант, Шарын гол зэрэг сумын эмнэлэгт үзүүлэх ачаалал харьцангуй бага байдаг байна.

Шигтгээ 5.3 *Бид нэгэнт тангараг өргөсөн эми нар учраас гар аргаар алт олборлож буй хүмүүст эрүүл мэндийн даатгалгүй, бүртгэлгүй байсан ч яаралтай тусlamж, эмэгтэйчүүд, хүүхдүүдэд зохих тусlamж үзүүлдэг. Дийлэнх тохиолдолд согтуу, танхай залуучууд ирдэг учраас үг хэлээр доромжлох, хүчирхийлэхийг завдах зэрэгээр олон дарамт учруулдаг.*

Өвөрхангай, Уянга.
Эмч «О», эмэгтэй

Гар аргаар алт олборлогсдын эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд зориулсан төсөв байдаггүйгээс зарим тохиолдолд боломжтой иргэдээс шаардлагатай эм, тариа, боолтын материалын өртгийг гаргуулдаг тухай эмнэлгийн мэргэжилтнүүд ярилцлагад дурьдсан байна. Гэвч ихэнхи тохиолдолд эмнэлэгт үйлчлүүлж буй алт олборлогсод эрүүл мэндийн даатгалгүйгээс үйлчилгээний, яаралтай тусlamж үзүүлж буй үед түргэн тусlamжийн дуудлагын зардал, үзлэг, шинжилгээ, эм, тариа болон бусад зардлыг эмнэлэг хариуцаж байна. Сумын засаг дарга, түүний орлогч, эмнэлгийн удирдлагууд гар аргаар алт олборлогсдын тоо, тэдний харьяаллыг харгалzan сумын эмнэлгийн төсвийг нэмэгдүүлэх шаардлагатай талаар онцлон дурьдаж байв.

Иймд эрүүл мэндийн тусlamжийн дээрхи хэрэгцээ, эмнэлэгт үзүүлэх төсвийн ачааллыг багасгах үүднээс сум, багийн эмнэлгийн төсөвт тэдэнд шаардлагатай байгаа тусlamжийн зардлыг тусгах нь зүйтэй байна.

Гар аргаар алт олборлох ажлыг насанд хүрэгчдээс гадна хүүхдүүд, өндөр настангууд эрхэлж байгаа, мөн тэдний гэр бүлийн бага насны хүүхдүүд бүртгэлгүй учраас вакцинжуулалтанд хамрагдахгүй байх, жирэмсэн эхчүүд хяналтгүй төрөх нь түгээмэл тохиолддог гэж сумын эмнэлгийн ажилчид өгүүлж байв.

Шигтгээ 5.4 Эмэгтэй О, 27 настай. Хяналтанд оролгүй байж байгаад төрөхөөр ирсэн бөгөөд ихэс гардуулан, цус алдаж маш хүндрэлтэй төрж, ураг эндэн эцэст нь умай тайрах хагалгаа хийлгэн амьд гарсан. Энэ эмэгтэй цаашид төрөх боломжгүй болсон.

Өвөрхангай, Уянга сумын хүний их эмч «О»

Түүнчлэн тэдний ахуйн нөхцөл эрүүл ахуйн шаардлагад нийцдэггүй, бие засах газар байхгүй, унд ахуйн ус хүрэлцээгүй буюу хүний амьдралын наад захын эрүүл ахуйн хэм хэмжээ зөрчигдөж байгаатай уялдан гэдэсний халдварт өвчин, суулгалт эмгэгүүд, арьсны өвчин хүүхдийн дунд түгээмэл тохиолддог ажээ. Өвөрхангай аймгийн Өлт, Баруун Сөлт, Төв аймгийн Борнуурын уурхайд гар аргаар алт олборлогсдын дунд халдварт шар өвчний тохиолдол нилээд олон илэрсэн байна.

Өвөрхангай аймгийн Уянга сумын захиргаанаас, сумын эмнэлгээс санаачлан үзлэг хийхийн зэрэцээ зарим олон улсын байгууллагатай хамтран жилдээ 2–3 удаа явуулын үйлчилгээ буюу хүүхдийг вакцинжуулах, үзлэг хийх, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг байна. Гэвч эдгээр үйлчилгээнд гэр, урцаа сахиж үлдсэн хөгшид, хүүхдүүд хамрагдаж, харин алт олборлож буй насанд хүрэгчид өдрийн цагаар ажилладаг учраас тэр бүр хамрагдахгүй үлддэг байна. Харин сургалт, сурталчилгаа, эрүүл мэндийн үйлчилгээг өвлийн улиралд явуулбал хүйтэrsэнтэй холбогдон гэрээр байх хүний тоо их байдаг гэж санал тавьж байв.

Түүнчлэн сургуулийн насны охидууд жирэмслэх, үр хөндүүлэх нь хэвийн үзэгдэл болсон ба энэ талаар эмнэлгийн ажилчид сэтгэл түгшин ярьж байлаа. Зуны цагт сургуулийн хүүхдүүд олноороо ажилладаг, уурхайд ажилладаггүй ч 14-17 насны охидууд эх эцэг нь алт олборлож буй үед гэртээ харах хүнгүй үлддэг, мөн тэдэнд туслан алт угаах зөөх ажил хийн янз бүрийн насны эрчүүдтэй хамт ажилладаг зэргээс охидын дундах жирэмслэлт, үр хөндөлт нэмэгдэх, бэлгийн замын халдварт өвчин ихсэх хандлагатай байгааг сумын эмнэлгийн мэргэжилтнүүд өгүүлж байна. Орон нутгийн эмнэлгийн хүч хүрэлцдэггүй учраас гар аргаар алт олборлож буй иргэдийн дунд ХДХВ/БЗХӨ-ийг илрүүлэх үзлэг, шинжилгээ хийх, ухуулга сурталчилгаа явуулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран нэгдсэн байдлаар зохион байгуулах хэрэгцээтэй байна гэж орон нутгийн удирдлагууд ярьж байв.

Шигтгээ 5.5 Манай сумын иргэд дулаарахаар бүгд алт ухдааг. Хүүхдүүд энэ үеэр эзэнгүйдэж хэрэг төвөөгт орох, эрт бэлгийн хавьтад орох зэрэг сөрөг нөлөө ихэслээ. Манай сумын охидын дундах жирэмслэлт, үр хөндүүлэх явдал нэмэгдэж байна.

Баянхонгор, Бөмбөгөр сумын эмнэлгийн эмч «О»

Гар аргаар алт олборлож буй эмэгтэйчүүдийн хувьд газар дор, усан дотор удаан зогсох зэргээр хүнд нөхцөлд ажиллаж байгаатай уялдан бөөр, шээсний замын болоод эмэгтэйчүүдийн эмгэгээр өвдөх, цаашилбал, тэдний дунд жирэмслэлт, төрөх үеийн хүндрэл элбэг тохиолддог байна. Түүнчлэн эмэгтэйчүүд, охид бэлгийн хучирхийлэлд өртөх, алт олборлох газар олох, эзэмшихийн тулд биеэ үнэлэх зэрэг тохиолдол ч гардаг ажээ. Гар аргаар алт олборлогсдын өгүүлж байгаагаар дулааны улиралд тухайн сумын болоод бусад газраас ирсэн биеэ үнэлэгч эмэгтэйчүүд нилээд элбэгшдэг,

тэдний үйлчлүүлэгч нар ч их байдаг гэж өгүүлж байв. Бид зарим гэр дэлгүүрээр орж үзэхэд бэлгэвч зарж байсан нь сайшаалтай байлаа.

Шигтгээ 5.6 «*Би дүү охинтойгоо хамт энд ажилладаг. Хэдийгээр хайр сэтгэлгүй ч бид бусдын бэлгийн дарамтад ортөхгүй, аюулгүй байдлаа хамгаалах үүднээс 2 нинжа залуутай хамтран амьдарч байна.*»

Баянхонгор, Баян-овоо, Алтан ус, иргэн Ц, эмэгтэй, 26, настай

Монгол улсын үндсэн хуульд зааснаар хүний жам ёсны эрхийн нэгамьдявах, халдашгүй чөлөөтэй байх, гэр бүл, үр хүүхэдтэй байх бөгөөд гар аргаар алт олборлогсдын хувьд эдгээр тохиолдоос авч үзвэл халдашгүй чөлөөтэй байх эрх зөрчигдөж байгаа ажээ.

Шигтгээ 5.7 *Алт олборлох газартай байхын тул лицензи бүхий нэгэн уурхайн хамгаалалтын орос ажилтантай бэлгийн харьцаанд орж улмаар хүүхдийг нь төрүүлсэн тохиолдол гарсан.*

Архангай Цэнхэр сумын эмч »Ц«

Хүнд шороо зөөх, хөдөлгөөн хязгаарлагдсан албадмал байдлаар нүхэнд удаан ажиллах, даарах, тоостой орчинд ажилладагтай нь холбоотойгоор алт олборлогсдын 22.0 хувь нь ууц нуруугаар өвдөх, 16.1 хувь нь ханиах, 15.5 хувь нь үе мөч өвдөх, 10.4 хувь нь нүд улайх, нулимс гоожих зэрэг зовиуртай байна.

Осол гэмтэлд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2.4 дахин илүү өртдөг байна. Алт олборлохдоо нүх ухах, шороо шигших, алтаа угаахдаа ихэвчлэн гэмтдэг байна. Осолд орж бэртэх эрсдэл нь өдөр, шөнө тасралтгүй ажилладаг хүмүүст илүү байна. Ялангуяа бэхэлгээний олс нь зориулалтын биш байдаг, 8–10 хоног ашиглаад цаашид ашиглах боломжгүй байдаг учраас олс тасарснаас унах, шуудай, савтай шороо, чулуунд цохиулах нь элбэг байнга гэж ярилцлагын үед эрчүүд өгүүлж байв.

Хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой ослын шалтгаанд 57.8 хувь нь шороонд дарагдах, 15.6 хувь нь бэхэлгээний олс тасрах, 32.8 хувь нь нүхэнд унах зэрэг шалтгаан тэргүүлж байна.

Нийт судалгаанд хамрагдагсдын 18.7 хувь нь ахуйн буюу зодуулж гэмтсэн байгаа нь ихэнхи аймагт нийтлэг байна. Энэ нь алт олборлогсдын дунд архи, согтууруулах ундаа их хэрэглэдэгтэй холбоотой байж болохыг осолд өртөх үедээ алт олборлогсдын 10 хувь орчим нь согтууруулах ундаа хэрэглэсэн байсан гэж хариулснаас харагдаж байна.

Судалгаа явуулж байх үед гадаах агаарын хэм хасах 10–15 байсан бөгөөд насанд хүрсэн ба ахимаг насны эрчүүд гадаа хүйтэн учраас дулаацах зорилгоор архи хэрэглэдэг тухайгаа өгүүлж байлаа. Ажлын байран дээр нүх рүү унах, дарагдах зэрэг ослууд нь голдуу согтуу эрчүүдэд тохиолдохоос гадна хоорондоо зодолдсоноос бэртэх, хутгалах зэрэг танхайн хэрэг нилээд гардаг тухай цагдаагийн ажилтнууд төдийгүй гар аргаар алт олборлогсод өөрсдөө ч өгүүлж байлаа.

Хүснэгт 5.2 Гар аргаар алт олборлогсодод тохиолдож буй осол, түүний шалтгаан

Сонгосон үзүүлэлтүүд	Ажиллаж буй орд		Нийт
	Үндсэн орд	Шороон орд	
Осол гэмтэлд өртсөн эсэх			
Тийм	10.5	18.8	16.0
Үгүй	89.5	81.2	84.0
Осол гэмтэл авч байсан давтамж			
1-2 удаа	85.7	76.0	78.1
3-4 удаа	1.1	22.0	18.8
5-аас дээш удаа	1.1	2.0	3.1
Осол гэмтлийн төрөл*			
Хөл гарса гэмтээсэн	71.4	44.0	50.0
Унаж гэмтсэн	14.3	30.0	26.6
Доргисон	14.3	4.0	6.3
Цохигдсон	14.3	30.0	26.6
Бусад	14.3	22.0	20.3
Хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой гэмтэл*			
Гэмтэл*	50.0	49.2	57.8
Шороонд дарагдах	0.0	16.4	15.6
Бэхэлгээний утас тасарсан	28.6	27.9	32.8
Нүхэнд унасан	14.3	1.6	4.7
Гэмтэл аваагүй	7.1	4.9	6.3
Бусад			
Ахуйн нөхцөлтэй холбоотой гэмтэл			
Зодуулсан	28.6	16.0	18.8
Хутгалуулсан	0.0	2.0	1.6
Бэртэл аваагүй	64.3	76.0	73.4
Бусад	7.1	6.0	6.3
Осолд өртөхдөө согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх			
Хэрэглэсэн	14.3	8.0	9.4
Хэрэглэсэн	85.7	92.0	90.6
Хэрэглээгүй			
Бүгд	100.0	100.0	100.0
Хүний тоо	133	266	399

Тайлбар: * давхардсан утгаар тооцсон болно

Алт олборлох ажил эрхэлснээс хойш ажлын байран дээр байхдаа тэдний 78.1 хувь нь 1-2 удаа, 18.6 хувь нь 3-4 удаа, 5-6 хувь нь 5-аас дээш удаа гэмтсэн давтамжтай байв. Осол гэмтлийн төрлөөр нь авч үзвэл арьс, салст, зөөлөн эд, үе мөчдийн гэмтэл давамгайлж байна. Хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой гэмтлийн зонхилон тохиолдож буй шалтгаанд шороонд дарагдсан 57.8 хувь, бэхэлгээний олс тасарсан 15.6 хувь, нүхэнд унасан 32.8 хувь тус тус эзэлж байна.

Шигтгээ 5.8 Манай сумын их сайхан биетэй бөх залуу байсан. Тэр алт олборлох ажлыг хийдэг бүр «азарга» болсон. Тэгээд газраа булаачалдаад гаднаас ирсэн нинжа нартай муудалцаад согтуу залуучууд 30 метрийн нүх руу түлхээд амь насыг нь хороосон.

Өвөрхангай, Уянга, байгаль орчны байцаагч «Д»

Судлагдсан аймгуудаас Баянхонгор, Сэлэнгэ аймгуудад осол гэмтэл өндөр бүртгэгдсэн ба осолд орж байсан нийт алт олборлогсдын 15.8 хувь нь 1 удаа, 26.3 хувь нь 3-4 удаа осолд орж байсан байна. Алт олборлогсодод унаж гэмтэх цохигдох, доргих зэрэг гэмтлүүд давамгайлж байна. 45-аас дээш насныхан хөл гаралт, 15-24 насныхан чулуу, шороонд дарагдах, цохигдох шалтгааны улмаас арьс салст, биений ил хэсгээ тус тус илүү гэмтээдэг байна.

Монгол улсын Засгийн Газрын 2000 оны 107 тоот тушаалаар баталсан «Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг бүртгэх» дүрэмд ажлын байран дээр гарсан осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчний үед авах тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговрыг тодорхой заасан байдаг. Гэвч гар аргаар алт олборлогсодод ажлын байран дээр гэмтэж осолдох, мөнгөн усны хордлогод өртөх нь элбэг тохиолддог ч энэ тогтоолд заасан тэтгэмж, тэтгэвэрт хамрагдахгүй байгаа бөгөөд цаашид аж ахуйн нэгжийн зохион байгуулалтанд оруулж, тэднийг дээрхи үйлчилгээнд хамрагдах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Шигтгээ 5.9 2 жилийн өмнө энд албан бусаар ажиллаж байсан эмэгтэй шороонд дарагдаад хүнд гэмтсэн. Тэр бүсэлхийнээс дооши мэдээгүй, тахир дутуу болсон ч одоог хүртэл осол гэмтлийн даатгал, тэтгэмжид хамрагдахгүй байна.

Өвөрхангай, Цэнхэр сум, багийн эмч, «Н»

Эрүүл мэндийн байгууллагаас алслагдсан байгаа нь эрүүл мэндийн тусlamж авахад тулгардаг хамгийн гол бэрхшээл гэж үзсэн байна. Тэдний дунд ажлын нөхцөл, үйл ажиллагаатай холбогдон эмнэлгийн яаралтай тусlamжийн хэрэгцээ гарахад шаардлагатай тусlamж авахад цаг алдснаас тусlamж авч чадахгүй амь насаа газар дээрээ алдах явдал цөөнгүй гардаг байна.

Зураг 5.01 Алт олборлогсдын эрүүл мэндийн тусlamж авахад тулгардаг бэрхшээл




Гар аргаар алт олборлогсод сумын эмнэлгээс тусlamж авахад эмнэлгийн дуудлага цаг тухайдаа ирдэгтгүй, нөгөө талаас хаяггүй, тодорхой бус байршдаг учраас тэднийг олж туслалцаа үзүүлэхэд хүндрэлтэй байдаг байна. Тухайлбал зарим газарт тогтсон ханшаар (3000-5000 төг) мотоцикл хөлслөн сум, ойролцоо эмнэлгийн байгууллагад хүргэдэг жишиг тогтсон байна.

5.2 Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хэрэгцээ

Сумын эмч нарын өгүүлж байгаагаар оройн 4 цагаас хойшхи дуудлагын 85–90 хувь нь гар аргаар алт олборлож буй иргэдтэй холбоотой байдаг, очоод тэднийг олж туслахад хэцүү, маш их шатахуун, хугацаа зарцуулдаг ажээ. Иймд нөхөрлөл байгуулах, байршилаар нь хаягжуулах зэргээр зохион байгуулалтанд оруулах, эмнэлгийн төсвийг нэмэх зэрэг арга хэмжээ авбал гар аргаар алт олборлогсодод үйлчилгээ үзүүлэхэд дөхөмтэй гэсэн саналтай байв.

Зураг 5.02 Гар аргаар алт олборлогсдын эрүүл мэндийн тусlamжийн хэрэгцээ, хувийн жин



Сэлэнгээс бусад аймагт алт олборлож буй судалгаанд хамрагдсан 3 хүн тутмын 2 нь эмнэлгийн болон яаралтай тусlamжийг цаг хугацаанд нь авах боломжгүй гэж үзэж байна.

Нийт судалгаанд хамрагдагсдын 50 хувь нь 2 цаг хүртэлх хугацаанд, 37.6 хувь нь 2-12 цагийн дотор, 12.3 хувь нь 12 цагаас дээш хугацаанд хамгийн ойр байдаг эмнэлгийн тусlamж авах боломжтой гэжээ.

Алт олборлогсод шаардлагатай үед хэрэглэх эм тариагаа сумын төвийн эмийн сангаас (53.4 хувь), гэр дэлгүүрээс (33.3 хувь), хувь хүнээс (15.5 хувь) авдаг бөгөөд 5.5 хувь нь өөрт байгаа эм тариагаа хэрэглэдэг гэснээс үзэхэд тэдний 41.1 хувь нь баталгаагүй газраас эм, тариагаа худалдан авч байна. Энэ байдал Баянхонгор, Дархан уул, Өвөрхангай аймгуудад илүү түгээмэл ажиглагдаж байна.

Нийт судалгаанд хамрагдагсдын 59.4 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдснаас эмэгтэйчүүд (63.1 хувь) эрэгтэйчүүдээс (57.4 хувь) даатгалд илүү хамрагдсан байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан хүмүүсийн 70 хувь нь сүүлийн жилийн даатгалын хураамжаа төлсөн гэж хариулсан байна. Үлдсэн хүмүүсийг нэгэнт даатгалын шимтгэлээ төлөөгүй учир эрүүл мэндийн даатгалтай гэж үзэх боломжгүй.

Иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байгаа шалтгаанд

- мөнгөний боломжгүй 55 хувь
- ажилгүй 24.5 хувь
- бүртгэл, бичиг баримтгүй 14.2 хувь
- даатгуулах шаардлагагүй 4.3 хувь
- мэдэхгүй гэж 11.2 хувь нь хариулсан байна.

ШИГТГЭЭ 5.10 Нийгмийн даатгалын дэвтэртэй боловч даатгалаа төлөх мөнгөгүйгээс хэдэн жил төлөөгүй байгаа. Уул нь төлж байгаад наасаа болохоор тэтгэвэрт гарах юмсан гэж бодох л юм. Осол гэмтлийн даатгал байдгийг дуулж байсан, гэхдээ хаана яаж даатгуулдгийг мэдэхгүй байна. Энд ажиллаж байхад тэр даатгалд хамрагдвал хэрэгтэй л дээ. Гэвч өдрийн хоолоо олж ядаж байхад шимтгэл төлөх боломжгүй байх.

Өвөрхангай, Уянга, 48 настай, эрэгтэй

Ярилцлагаар алт олборлогсдын дунд урьд нь ажил хийж байсан хүн цөөн, нийгмийн даатгал, эрүүл мэндийн дэвтэртэй хүн ховор, дэвтэртэй хэсэг нь шимтгэлээ олон жилээр төлөөгүй байх нь түгээмэл байна. Осол гэмтэл, гэнэтийн ослын даатгалд хамрагдсан хүн нэг ч тааралдаагүй бөгөөд энэ тухай огт дуулаагүй байх нь олон байна.

Дүгнэлт

1. Гар аргаар алт олборлогч эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусlamж авах хэрэгцээ эрчүүдтэй харьцуулахад 2 дахин илүү байна. Энэ нь тэдний эрүүл мэнддээ хандах хандлага, ажлын хүнд нөхцөлд ажиллаж байгаатай холбоотой байж болох юм.
2. Алт олборлогсдын дийлэнх нь эмнэлгийн тусlamжийг иргэний бүртгэлтэй эсэхээс үл хамааран сумын эмнэлгээс авч байна.
3. Хөдөлмөрийн хүнд нөхцөл, гүйцэтгэж буй ажил үүргийн төрлөөс шалтгаалан тэдний дунд шээс, бэлэг, амьсгалын замын болон тулгуур эрхтэний, мөн халдварт өвчинүүд зонхилон тохиолдож байна. Түүнчлэн эрхэлж буй ажлаас нь үүдсэн олстасрах, нүхэнд унах, шороо, нурангад дарагдах осол гэмтэл элбэг тохиолддог байна.
4. Алт олборлогсдын тал хувь нь гэнэтийн яаралтай тохиолдолд эмнэлгийн тусlamжийг 2 цагийн дотор авах боломжгүй байна. Эрүүл мэндийн тусlamж авахад учрах гол бэрхшээлд тэдний хаяг тодорхойгүй, алслагдмал байдал, тээврийн хэрэгсэл дутмаг, холбоо харилцаа байхгүй зэрэг шалтгаан орж байна.
5. Алт олборлох үйл ажиллагаатай холбогдсон осол гэмтэл, мэргэжлийн өвчинд өртөж байгаа боловч тэтгэмж, нөхөн олговорт аж ахуйн нэгжийн зохион байгуулалтгүй, нийгмийн даатгалгүйгээс хамрагдах боломжгүй байна.
6. Алт олборлогсдод баталгаат эмийн үйлчилгээ, эмчийн үзлэг, оношлогоо, нарийн мэргэжлийн үзлэг, осол гэмтлээс сэргийлэх, өвчинөөс сэргийлэх мэргэжлийн зөвлөгөө, сургалт, хяналт, эрүүлжүүлэх үйл ажиллагаа, нөхөн үржихүйн тусlamж, үйлчилгээ шаардлагатай байна.

Санал, зөвлөмж

1. Гар аргаар алт олборлогсдыг орон нутагт түр ба байнгын оршин суугчаар бүртгэсний үндсэн дээр эрүүл мэндийн даатгалд хамруулж, тэдэнд шаардагдах төсвийг орон нутгийн эмнэлгийн төсөвт тусгах
2. Орон нутгийн эмнэлгийн хүч хүрэлцдэггүй учраас гар аргаар алт олборлож буй иргэдийн дунд явуулын үйлчилгээгээр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, эрүүл мэндийн сургалт сурталчилгаа хийх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран нэгдсэн байдлаар зохион байгуулах хэрэгцээтэй байна
3. Алт олборлогсдын дундах бага насын хүүхэд, ахмад настан, төрөх насын эмэгтэйчүүдэд нийгмийн эрүүл мэндийн зохих тусlamжийг үзүүлэх /жирэмсний хяналт, хүүхдийн дархлаажуулалт/ шаардлагатай өвчтөнд төрөөс төлбөргүй үзүүлэх тусlamжууд
4. Осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдол их байгааг харгалзан тэднийг осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговорт хамруулах боломжийг тодруулан судлаж, нөхцлийг бүрдүүлэх

Бүлэг VI

НИЙГМИЙН ХАЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ



Бүлэг VI. Нийгмийн халамж, үйлчилгээний хүртээмж

Гар аргаар алт олборлогсдын нийгмийн халамж, үйлчилгээг хүртэж буй байдал, тохиолддог бэрхшээлийг илрүүлэн, тэднийг энэ үйлчилгээнд хамруулах боломжийг нэмэгдүүлэх талаар судлан энэ бүлэгт тусгалаа.

Нийгмийн халамжийн тухай Монгол улсын хуулинд «Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан иргэнд чиглэсэн нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, тэдгээрийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулахад чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээг нийгмийн халамж гэнэ» хэмээн тодорхойлжээ.

Одоогийн мөрдөж буй хууль, тогтоомжийн дагуу гар аргаар алт олборлогсод өндөр настны ба тахир дутуугийн (ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар байнга буюу удаан хугацаагаар алдсан бол), тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хүүхдийн, шинээр гэрлэгсийн, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, ажилгүйдлийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, тусlamжи хамрагдах боломжтой байна. Судалгаагаар дээр дурьдсан тэтгэвэр, тэтгэмж, гар аргаар алт олборлогсдын хамрагдаж буй байдал, тэдний хэрэгцээ зэргийг тодруулав.

6.1 Гар аргаар алт олборлогсдын нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдалт

Судалгааны дүнгээс үзэхэд 12.5 хувь нь ямар нэг тэтгэвэр, тэтгэмж авдаг, 87.5 хувь нь авдаггүй гэж хариулсан. Харин тэтгэвэр тэтгэмжид хамрагддаг гар аргаар алт олборлогсдын 64.0 хувь тухайн орон нутгийн иргэд байв. Үүнээс үзэхэд тэтгэвэр, тэтгэмж шаардлага бүхий өөр нутгийн харьяат алт олборлогсод түүнийг авч чадахгүй байгаа нь харагдаж байна.

Тэтгэвэр авагчдын дундаж нас 50.4 бөгөөд тэдний дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа бол тэтгэмж авагч иргэдийн дундаж нас 34.0 байв.

Судалгаанд оролцсон алт олборлогсдын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдлыг нийгмийн халамж, орон нутгийн харьяаллаар нь Хүснэгт 6.1-д үзүүлэв.

Хүснэгт 6.1 Тэтгэвэр, тэтгэмж ба эрүүл мэндийн даатгалын хамрагдалт

Үзүүлэлт	Нийт судалгаанд хамрагдагсад		Тэтгэвэр, тэтгэмж авагч иргэд		Total
	Тухайн орон нутагт бүртгэлтэй	Тухайн орон нутагт бүртгэлгүй	Тухайн орон нутагт бүртгэлтэй	Тухайн орон нутагт бүртгэлгүй	
Эрүүл мэндийн даатгалтай	65.10	53.90	90.50	69.00	59.40
Эрүүл мэндийн даатгалгүй	34.90	46.10	9.50	31.00	40.60
Total	100.0	100.0	100.0	100.0	100.0

Алт олборлогсдын 12.5 хувь нь нийгмийн даатгалын шимтгэлээ төлж байгаагаас тэдний 54 хувь нь тухайн орон нутагтаа, үлдсэн хувь нь өөр газарт төлдөг байна. Тухайн газраас өөр орон нутагт хүнээр дамжуулан шимтгэл төлөх нь цаг хугацаа их шаардсан, дамжлага ихтэй төвөгтэй ажил болдог гэж ярилцлагын үед дурьдаж байв.

Түүнчлэн өөр орон нутгаас ирж ажиллагсдын хувьд хүүхдийн ба хүүхэд асарсны тэтгэмж, шинээр гэр бүр бологсдын тэтгэмжийг авч чадахгүй байгаа талаар ганцаарчилсан ярилцлагын явцад эмэгтэйчүүд нилээд хэлж байлаа.

Шигтгэ 6.1 Би энэ уурхайд 5 дахь жилдээ ажиллаж байна. Ирээд энэ сумын эмэгтэйтэй хамтран амьдарч байна. Бид нэг охинтой. Хүүхдийн мөнгөө авч байгаа. Гэрлэлтээ батлуулах, шинээр гэрлэгсдийн тэтгэмж авах гэхээр би өөрөө иргэний бичиг баримтгүй учраас болохгүй юм байна лээ.

Өвөрхангай, Уянга, «С», 28 настай, эрэгтэй

Гар аргаар алт олборлогсдын 71.9 хувь нь сард 150 000 төгрөгөөс доош орлоготой байгаагаас 31.1 хувь нь Засгийн газраас тогтоосон цалингийн доод хэмжээнээс доогуур орлоготой байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлт орлогын хэмжээнээс хамаарч байсан бөгөөд 70000-149000 төгрөгийн сарын дундаж орлого бүхий хүмүүсийн нийгмийн даатгалд хамрагдах байдал бусад бүлгээсээ илүү байв.


Хүснэгт 6.2 Нийгмийн даатгалын шимтгэл төлж буй байдал, сарын дундаж орлогын хэмжээ

Average monthly income	Percentage among survey participants		Number of people paying social insurance and its share in average monthly income	
	Number	Percent	Number	Percent
<69000MNT	124	31.1	13	10.5
70000-149000MNT	163	40.8	27	16.6
150000-299000MNT	102	25.6	9	8.8
<300000MNT	10	2.5	1	10
Total	399	100	50	12.5

Монгол улсын Нийгмийн даатгалын хуульд зааснаар нийгмийн даатгал нь тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний ба ажилгүйдлийн даатгалаас бүрдэнэ. Нийгмийн даатгал нь заавал даатгуулах ба сайн дураар даатгуулах гэсэн 2 хэлбэртэй байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч нь нийгмийн даатгалд заавал даатгуулна гэж заасан байна.


Судалгаанд сонгогдсон аймгуудын хувьд нийгмийн даатгалд хамрагдалтын түвшин эрүүл мэндийн даатгалд хамрагдалтай харьцуулахад 3–6.4 дахин бага байв. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт Баянхонгор, Сэлэнгэ, Төв аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад илүү байна.

Зураг 6.01 Гар аргаар алт олборлогсдын нийгмийн даатгал ба эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, аймгаар




Одоогийн байдлаар нийгмийн даатгалд даатгуулаагүй байгаа судалгаанд хамрагдсан гар аргаар алт олборлогсдын 92.8 хувь нь нийгмийн даатгалд даатгуулах хүсэлтэй байгаа ажээ. Тэд төлбөрийн чадваргүй, төлөх аргаа мэдэхгүй байх, нийгмийн даатгалын ажилтантай уулзаж чадахгүй байгаа зэргээс шалтгаалан нийгмийн даатгалын шимтгэлээ (88.3 хувь) төлж чадахгүй байна.

Зураг 6.02 Нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байгаа шалтгаан



Нийгмийн даатгалд даатгуулснаар 76.2 хувь нь тэтгэвэр, 31.3 хувь нь тэтгэмж, 2.9 хувь нь осол гэмтлийн даатгал авахад ач холбогдолтой гэж (давхардсан тоогоор) хариулжээ.


Зураг 6.03 Нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдлыг үнэлсэн байдал



Монгол улсын Нийгмийн даатгалын хуулийн 4-ийн 3-т зааснаар «... хувиараа хөдөлмөр эрхлэх замаар үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхлэж байгаа бол ...нийгмийн даатгалд даатгуулах эсэх, түүний ямар төрлийг сонгохоо өөрөө шийдвэрлэнэ» гэж заасны дагуу сайн дурын даатгалд гар аргаар алт олборлогсод даатгуулах боломжтой юм. Сайн дурын даатгалын талаар мэдэх үү гэсэн асуултанд судалгаанд хамрагдагсдын 72.0 нь үгүй гэж хариулсан бөгөөд тэдний 79.0 хувь нь боломж олдвол энэ даатгалд хамрагдана гэжээ.

Сайн дурын даатгалын талаар 35-50 насын хүмүүс илүү мэдлэгтэй байгаа нь ажиглагдаж байна.

Зураг 6.04 Сайн дурын даатгалын талаар мэднэ гэж хариулсан алт олборлогчид, насын бүлгээр



Судалгаанд хамрагдсан ахмадын ихэнх нь өндөр настны тэтгэврээ орон нутгаасаа авч байсан бөгөөд зарим ахмадууд улсад цөн жил ажилласан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт хангалтгүй, бүртгэлгүй байсан зэрэгээс тэтгэврээ авч чадахгүй байна.

Эдгэрээс харахад даатгалын ач холбогдол болон түүнд хамрагдах арга, сайн дурын даатгалыг мэдэхгүй байгаа зэрэг нь нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байгаад нөлөөлж байж болох юм.


Гар аргаар алт олборлогсдын дийлэнх нь залуучууд байгаа бөгөөд тэд ид хөдөлмөрийн насандаа нийгмийн даатгалаа төлөхгүй байснаар 20–25 жилийн дараа хөдөлмөрийн чадваргүй өндөр насанд хүрэх үедээ тэтгэвэр авах нөхцлийг хангаж чадахгүйгээс орлогогүй иргэдийн тоо нэмэгдэх хандлагатай байна.

6.2 Гар аргаар алт олборлогсдын нийгмийн даатгалын хэрэгцээ

Хэдийгээр гар аргаар алт олборлогсдын нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн талаар мэдлэг хангалтгүй байсан ч бид тэдгээрийг тайлбарлан асууж, ярилцан тодруулан судлав.

Тэдэнд шаардлагатай байгаа нийгмийн даатгалд осол гэмтлийн даатгал (55.4 хувь), ажилгүйдлийн даатгал (47.7 хувь), амь насны даатгал (32.9 хувь) зэрэг хамрагдаж байв. Мөн тэдний зарим хэсэг нь эрүүл мэндийн, тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалыг нэрлэсэн байна.

Зураг 6.05 Гар аргаар алт олборлогчдын нийгмийн даатгалын хэрэгцээ, даатгалын төрлөөр /хувиар/




Гар аргаар алт олборлогсдын тал хувь нь осол гэмтлийн даатгал хэрэгцээтэй гэсэнтэй уялдан түүний ач холбогдлыг тодруулахад давхардсан тоогоор тэдний 63.4 хувь нь осол гэмтэлд өртвөл нөхөн олговор авахад, 25.6 хувь нь тахир дутуугийн тэтгэвэр, төлбөр авахад, 28.8 хувь нь хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмж авахад гэж хариулсан байна.

Шигтгээ 6.1 Хүмүүс даатгалын талаар нэг их мэддэггүй. Тэгээд ч даатгалын янз бүрийн газрууд ч нинжа нарыг бүртгэх талаар ажил хийдэггүй. Хүмүүсийг осол гэмтэл, амь насны даатгалаар даатгуулах ч юм уу хэрэгцээтэй даатгалд хамруулна гээд ирвэл хүмүүс даатгуулах л байх. Гэхдээ хүмүүсийн бүртгэлийг нь харвал бэрхицээлтэй. Гол нь нутгийн хүмүүс л хамрагдах байх.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Багануур,
»Г«. 30 настай, эрэгтэй

Тэднээс нийгмийн халамжийн ямар үйлчилгээ шаардлагатай байгаа талаар асуухад 22.3 хувь нь өндөр насын, 5.0 хувь нь хүүхэд асарсны, 21.5 хувь нь нэн ядуугийн, 3.7 хувь нь тахир дутуугийн гэж хариулжээ.

Зураг 6.06 Одоо шаардлагатай байгаа нийгмийн халамж, үйлчилгээ, хүйсээр



Энэ хэрэгцээг насын бүлгээр тодруулан үзэхэд 55-аас дээш насын гар аргаар алт олборлогсод өндөр насын тэтгэвэр шаардлагатай гэж байгаа нь тэтгэвэрт хамрагдаагүй өндөр настанууд гар аргаар алт олборлон амьдарч байгааг илэрхийлж байна.

Алт олборлолтоос олж буй орлого нь амьдралын баталгаажих түвшингээс өндөр байгаа хэдий ч 25–45 насын алт олборлогсдын нилээд хувь нь нэн ядуугийн тэтгэмж шаардлагатай гэж хариулжээ. Энэ нь тэдний мэргэжилгүй, боловсролын түвшин доогуур, ажлын байр хомс байгаатай уялдан албан ажил эрхлэх боломж дутмаг нөгөө талаас нэн ядуугийн тэтгэмж өгөх заалтын талаар тодорхой мэдлэгтүй байгаатай холбоотой байж болох юм.

Гар аргаар алт олборлогсод сүүлийн үед харьцангуй зохион байгуулалтад орж, жижиг суурингийн хэлбэрт шилжих хандлагатай байгаатай уялдан харьяалалгүй иргэдийг бүртгэх, тэдэнд шаардлагатай халамж үйлчилгээг хүртэх боломж олгох нь чухал байна.

Дүгнэлт

- Гар аргаар алт олборлогсод тухайн орон нутагт бүртгэлгүй, иргэний бичиг баримтгүй байх зэргээр халамжийн үйлчилгээнд хамрагдах шаардлагыг хангаагүйгээс түүнийг хүртэж чадахгүй байгаа бөгөөд энэ нь судалгаанд хамрагдсан аймгуудад нийтлэг байна.
- Тэтгэврийн насанд хүрэх үедээ нийгмийн даатгалын шимтгэлийг 20-иос дээш жил төлөх боломжгүй болсон буюу бүрэн тэтгэвэр тогтоолгох нөхцлийг хангаж чадахгүй болсон алт олборлогсод нилээд хувийг (одоогийн байдлаар 45 наслас дээш эрэгтэй 9 хувь, 40 наслас дээш эмэгтэйчүүд 20 хувь) эзэлж байна.

3. Гар аргаар алт олборлож буй эмэгтэйчүүдийн 27.3 хувь нь 35-аас дээш настай, эрэгтэйчүүдийн 36.4 хувь нь 40-өөс дээш настай байгаад анхаарал хандуулж, тэдний тодорхой хувийг ч гэсэн 20 жилээс дээш хугацаагаар шимтгэл төлсний үндсэн дээр бүрэн тэтгэвэрт гарах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тэтгэврийн даатгалд яаралтай хамруулах арга хэмжээг авахгүй бол тэдний нилээд хувь нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн ч тэтгэвэр авч чадахгүй болохоор байна.
4. Судалгаанд хамрагдагсад нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байгаа гол шалтгаанаа төлбөрийн чадваргүйтэй холбож байгаа хэдий ч 70 орчим хувь нь цалингийн доод хэмжээнээс дээш цалинтай байгаа нь нийгмийн даатгалд хамрагдахгүй байгаагол шалтгаан нь нийгмийн даатгалд хамрагдсаны ач холбогдол, төлөх журмын талаарх мэдлэггүй байгаагаас шалтгаалж байгааг харуулж байна.
5. Гар аргаар алт олборлож буй ахмадуудад өндөр насны тэтгэвэр, хүүхэд, эмэгтэйчүүдэд хalamжийн тэтгэмж нэн шаардлагатай байна.
6. Нийгмийн даатгалын төрлөөс үйлдвэрлэлийн ослын даатгалыг илүү хэрэгцээтэй байна гэж үзсэн нь хөдөлмөрийн нөхцөл мүү, аюулгүй байдал зөрчигдэж, осол их тохиолддогтой холбоотой.

Санал, зөвлөмж

1. Гар аргаар алт олборлогсдын нийгмийн халамж хүртэх эрхийг хангахын тулд тухайн орон нутагт нь түр болон бүр оршин суугч хэлбэрээр бүртгэх
2. Сум, орон нутгийн төр захиргааны байгууллагууд болон нийгмийн даатгал, нийгмийн халамжийн байгууллагууд хамтран гар аргаар алт олборлогсдод нийгмийн хамгааллын үйлчилгээний төрөл, ач холбогдлын талаар сургалт, сурталчилгаа явуулах
3. Гар аргаар алт олборлогсод нийгмийн даатгалд хамрагдахгүй байгаагаас хөдөлмөрийн чадваргүй, мөн ахмад настай болох үедээ ямар ч орлого, тэтгэвэр, тэтгэмжгүй болж төрийн нуруун дээр ачаалал нэмэхээс сэргийлэх, тэднийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах талаар хууль эрх зүйн зохицуулалтыг хийх, хэрэгжилтийг төрөөс дэмжсэн үйл ажиллагаа явуулах
4. Гар аргаар алт олборлогсдыг аж ахуйн нэгжийн зохион байгуулалтанд оруулж, нийгмийн даатгалын заавал төлөх тогтолцоонд хамруулах

Бүлэг VII

ЗАН ҮЙЛ, СОЁЛЫН
ЗАРИМ АСУУДАЛ



Бүлэг VII. Зан үйл, соёлын зарим асуудал

Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхэд нийгэм, соёл ба хувийн эрх, эрх чөлөө байдаг. Гар аргаар алт олборлогсдын дундах зан үйл, соёлын зарим асуудлыг судласан бөгөөд энэ бүлэгт соёлын үзэгдэлтэй уялдан гар аргаар алт олборлогсдын хувьд илэрсэн нийтлэг бэрхшээл, ажилдаа хандах тэдний сэтгэлзүйн байдал, тухайн хүнд гарсан зан байдлын өөрчлөлт, амьдрах арга барилтай нь холбоотой үнэлэмж, бусдын харилцааг үнэлсэн хандлага зэргийг авч үзсэн болно.

«Соёл» гэдгийг нийгэм болон бүлгийн гишүүний хувь хүний сурч эзэмшсэн эсвэл бүтээн бий болгосон эдлэг болон оюунлаг утга холбогдол бүхий үзэгдэл, үйл явдал хэмээн маш өргөн утгаар тодорхойлдог. «Соёлын бараа» гэдэгт үзэл санаа, бэлэгдэл, амьдрах хэв маягийг дамжуулдаг хэрэглээний бараа, жишээ нь, ном, сэтгүүл, кино, CD, хувцасны загвар гэх мэтийг, «соёлын үйлчилгээ» гэдэгт хүмүүсийн соёлын хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагаа, мөн соёлын мэдээлэл, хамгаалал, жишээ нь, урлагийн тогтолт, жүжиг, киноны үзүүлбэр, соёлын арга хэмжээ, мөн номын сан, архив, музей, театр, концертын танхимиын үйлчилгээ гэх мэтийг хамруулдаг.

Гар аргаар алт олборлодог иргэдийн дунд тэдний ажлын нөхцөл, нийгмийн тусламж үйлчилгээний талаар хийсэн судалгаа нилээд байдаг боловч тэдэнд тохиолддог соёл, зан заншилтай холбоотой бэрхшээл, сэтгэл зүйн хүчин зүйлийн талаар судалсан үр дүн, мэдээлэл хомс байдаг. Энэхүү мэдээллийн цоорхойг нөхөх үүднээс тэдний зан үйл, соёлын холбогдол бүхий зарим бэрхшээлийг судлав.

7.1 Нийтлэг бэрхшээл

Бие хүн хөгжихөд нөлөөлдөг гол хүчин зүйлийн нэг нь ажлын орчин, хүмүүс хоорондын харилцаа байдаг.

Гар аргаар алт олборлогч нийт 399 хүн судалгаанд хамрагдснаас 46.1 хувь нь бие хүний хувьд хөгжих боломжгүй байхыг хамгийн бэрхшээлтэй зүйлээ хэмээн тодорхойлжээ. Соёлын бараа, үйлчилгээний хомсдол, хэл яриа, ойлголцол зөрөх зэрэг нь мөн тэдэнд бэрхшээлтэй байдаг байна (Хүснэгт 7.1)

Бие хүний хувьд хөгжих боломжгүй байна гэж хариулсан хүмүүсийн 26,9 хувь нь 16-25 насныхан, 21,7 хувь нь 26-35 насныхан, 24,3 хувь нь 36-45 насныхан, 20,4 хувь нь 46-55 насныхан, 21,4 хувь нь 56-дээш насныхан байна (давхардсан тоогоор).

Нилээд хэсэг нь буюу 42,6 хувь нь үйл ажиллагааг зохицуулах хууль эрхийн акт байхгүйг бэрхшээл гэж үзэж байгаа нь нэг талаас гар аргаар алт олборлох үйл ажиллагааг зохицуулах хууль, тогтоомж хэрэгцээтэй байгааг илтгэх боловч нөгөө

талаас бүгдийг дээрээс албадуулж шийдээд сурчихсан монголчуудын бэлэнчлэх сэтгэлгээ, нийтээрээ хэлцэж үйл ажиллагаагаа зохицуулж чаддаггүй занг харуулах талтай.

Хүснэгт 7.1 Гар аргаар алт олборлогсодод тулгарч буй соёлын бэрхшээл

Үзүүлэлт	Хүйс		Нийт
	Эр	Эм	
Итгэл бишрэлээр гадуурхагдах	2.3	1.4	2.0
Зан заншилаа сахиж чадахгүй	4.3	8.5	5.8
Хэл яриа, ойлголцол зөрөх	10.9	14.2	12.0
Соёлын бараа, үйлчилгээний хомсдол	21.7	26.2	23.3
Хувцаслалт муухай	17.4	11.3	15.3
Хоол бэлтгэх, хэрэглэх арга өөрчлөгдсөн	8.5	17.0	10.8
Үйл ажиллагаа зохицуулах албан хууль байхгүй	4.3	46.8	42.6
Бие хүний хувьд хөгжих боломжгүй байх	43.0	51.8	46.1
Харилцаа хүмүүжил доголдох	23.3	31.2	26.1
Бусад	14.3	9.2	12.5
Бүгд	100.0	100.0	100.0
Хүний тоо	285	141	399

Тайлбар: Үзүүлэлтийг давхардсан утгаар тооцсон болно

Итгэл бишрэлээрээ гадуурхагдах, зан заншилаа сахиж чадахгүй байх зэрэг бэрхшээлийг 56-аас дээш насынхан илүүтэй (7.1 хувь ба 14.3 хувь) тоочжээ. Мөн иргэд алтны уурхайд ажилласнаас хойш соёлын үйлчилгээнд хамрагдах боломжгүй болсон буюу үзвэр үзэх, ном, сонин, хэвлэл уншихгүй байх, улс оронд болж буй үйл явдлын мэдээнээс хол хөндий болсноо өгүүлж байв.

Шигтгээ7.1 *Би сүүлийн 3 жил ямар ч үзвэр үйлчилгээ үзээгүй, залуу наасаа шороо, нүхэнд өнгөрөөж байна. Сургалтын төлбөр төлөх мөнгөтэй болвول сурх бодолтой байгаа.*

Өвөрхангай, Уянга, 21 настай «Д»

Соёлтой холбогдох бэрхшээлийг алт олборлоход тохиолддог бусад бэрхшээлтэй харьцуулж үзэхэд дарагдах, нурах, осол гэмтлээс айх түгшүүр (72.7 хувь) гэсэн сэтгэлзүйн хүчин зүйлийн дараагаар ахуйн соёлтой холбоотой ус, цахилгаангүй байх (32.1 хувь) гэсэн бэрхшээлийг хамгийн их сонгосон байна. Үүний дараа эрүүл мэндийн тусламж хүртэх боломжгүй байх (29.6 хувь) бэрхшээлийг дурьджээ.

Гар аргаар алт олборлогсдын хүүхдүүд эрүүл, аюулгүй, тохь тухтай орчинд сурч боловсрох хэрэгцээгээ хангаж чадахгүйн дээр соёлжих, хүмүүжих наад захын боломжгүй нөхцөлд амьдарч байна.

Тэдний ажиллаж, амьдарч буй орчинд соёлын бараанд тооцогдох зүйлсийг гэр дэлгүүр, явуулын наймаачид төдийлөн худалдаалахгүй байгаа нь ажиглагдсан бөгөөд гар аргаар алт олборлогсод бидэнд үзвэр үйлчилгээ үзэх, ном, сонин үзэх зэргээр мэдээлэл авах боломж байхгүй гэж өгүүлж байв.

Алтнаас олж буй орлогоосоо эрүүл ахуй, ариун цэврийн хэрэгцээндээ сард дунджаар 12994 төгрөг зарцуулдаг бөгөөд тэдний нилээд хэсэг нь тамхи, согтууруулах ундаа, мөрийтэй тоглоомд мөнгөө зарцуулдаг байна (Хүснэгт 7.2).

Хүснэгт 7.2 Гар аргаар алт олборлогсдын зохисгүй хэрэглээ

Үзүүлэлт	Баян-Хонгор	Дархан-Уул	Сэлэнгэ	Төв	Өвөрхангай	Нийт
Согтууруулах ундаа	75.5	61.5	36.5	60.0	60.2	57.4
Мөрийтэй тоглоом	20.4	15.4	5.8	10.0	13.3	12.3
Биеэ үнэлэгч	7.1	7.7	2.9	5.0	9.6	6.0
Тамхи	90.8	92.3	81.7	86.7	66.3	81.5
Бусад	16.3	12.8	20.2	16.7	37.3	22.6
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100
Хүний тоо	98	39	104	60	83	399

Тайлбар: Үзүүлэлтийг давхардсан утгаас тооцсон

Дээр өгүүлсэн зохисгүй хэрэглээ нь тэдний чөлөөт цагаа зөв, үр ашигтай өнгөрүүлэх нөхцөл, орчин байхгүй, «соёлын бараа», үйлчилгээ хомс байдалтай уялдаатай байж болох юм.

Тэдний 33.3 хувь нь тогтмол хэвлэл, мэдээлэл, 36.8 хувь нь үзвэр үйлчилгээ хэрэгцээтэй байна гэж хариулжээ.

Дээрхи үр дүнг нэгтгэн үзвэл гар аргаар алт олборлогсодод ажлын нөхцлөөс шалтгаалсан айдас, сэтгэлийн дарамт нилээд байгаа бөгөөд соёлын орчин, нөхцөл хангалтгүй байна.




«Эцэг эхээ алт олборлож байхад хүүхдүүд тоглож байгаа нь»

Өвөрхангай. Бат -Өлзийт

7.2 Осол гэмтэлд өртөх, амь насаа алдах зэрэгт хандах байдал

Нийгэмд баримталж буй хэм хэмжээ, хорио цээрийг дагах нь соёлын нэгэн чухал үзүүлэлт бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрсөн хорио цээрийг ул ойшоо нь нийгэмд сөргөөр нөлөөлдөг. Гар аргаар алт олборлогсдын дунд хорио цээрийн тогтолцоо (табу), хүнлэг ёсны харилцаа ямар байдгийг тодруулах зорилгоор алт олборлогсод осол гэмтэлд өртөх, алт олборлож буй газраа амь насаа алдах, бүдүүлэг үг, яриа хэрэглэх зэрэгт та хэрхэн ханддаг вэ гэсэн асуултанд 63.9 хувь нь надад ийм явдал тохиох вий гэж айдаг, 42,1 хувь нь осол болсон нүх рүү орохоос жихүүцдэг, 37.3 хувь нь тусалж чадахгүй байгаадаа санаа зовдог, 15.8 хувь нь бүдүүлэг үг, яриаг тэвчихэд хэцүү байдаг, 6.5 хувь нь ийм зүйл байнга тохиолддог болохоор тоодоггүй гэж хариулжээ. (Зураг 7.1)

Зураг 7.01 Алт олборлогсдын осол гэмтэлд өртөх, амь насаа алдах зэрэгт хандах хандлага, хувийн жин



Эндээс хувь хүний өөрийгөө хичээх, аюулаас сэрэмжлэх сэтгэлзүйн эерэг хандлага давуу ажиглагдаж байна. Гэхдээ айдас, түгшүүрийн энэ мэдрэмж нь тэдний зан байдалд нөлөөлөөгүй гэж ихэнх (62.7 хувь) нь өөрсдийгөө үнэлж байна. Харин бодит байдлаас үзэхэд гар аргаар алт олборлох ажил хүмүүсийн сэтгэлзүй, зан байдал, уламжлалд ихээхэн өөрчлөлт оруулсан нь анзарагдаж байна. Жишээ нь, нүхэнд амь насаа алдсан хүнийг оршуулалгүй дээр нь хадаг тавьчихаад олборлолтоо үргэлжлүүлэн хийдэг явдал юм. Ийм зүйл байнга тохиолддог болохоор тоодоггүй гэж хариулж байв.

Шигтгээ 7.2 Хүмүүс шороонд даруулах, эрүүл мэндээр хохирох явдал их болсон. Хүн үхсэн газар улам ч их алт олдог гэсэн яриа хүмүүсийн дунд тархаж, уламжлалт ёсоо сахихгүй байх, хүн чанаргүй зан гаргах зэрэг нь улам их ажиглагдаж байна...

Баянхонгор аймгийн Засаг дарга

Алт олборлодог иргэд ба орон нутгийн оршин суугч, байгаль хамгаалагч, цагдаа нарын хоорондын харилцаанд сөрөг хандлага ажиглагдсан. Өөрөөр хэлбэл цагдаагийн ажилтны хувьд гар аргаар алт олборлогсдоос нутгийн иргэдээ хамгаалах тал руу илүү хандсан, байгаль орчны байцаагчийн хувьд ялангуяа газар ашиглалт, нөхөн сэргээлтийн асуудал болон зөвшөөрөлгүй газрыг эзэмшүүлэхийг хориглох чиглэлээр ажилладаг учраас тэдэнд гар аргаар алт олборлогсод таагүй байдлаар хандах нь түгээмэл ажиглагдлаа. Гар аргаар алт олборлож буй иргэд ихэнхдээ нийгмийн эмзэг бүлгийн, тухайлбал, талаас илүү нь бүрэн бус дунд буюу түүнээс доош боловсролтой, сөрөг зан үйл ихтэй, зан харилцааны доголдолтой байдаг зэргээс тэдний дунд хэрэг зөрчил нилээд гардаг бөгөөд тэд нутгийн иргэдэд сэтгэл зүйн дарамт учруулдаг байна.

Шигтгээ 7.3 *Манай сумын газар нутаг алтны уурхайн үйл ажиллагаанаас болж дэндүү их сүйдэж байна. Газраас гадна тэд ой модыг түлиинд хэрэглээд огтолж дууслаа. Намар, өвөлдөө хонуутаар самар түүж ой түймэрдэх болсон. Бид зүй ёсны шаардлага тавихад «ална» гэх мэтээр сүрдүүлж, дарамталдаг учраас шөнийн цагаар эргүүл хийх боломжгүй болсон.*

Өвөрхангай, Уянга, Байгаль орчны байцаагч

Цагдаа, хууль сахиулах байгууллагын ажилчид, орон нутгийн удирдлагын өгүүлж байгаагаар гар аргаар алт олборлогсдын дунд тохиолддог хэрэг зөрчил нь сумын иргэдийн дундахь зөрчлөөс их байдаг бөгөөд тэд сумын иргэдийг зодох, малыг нь хулгайлах зэргээр эрх чөлөөнд нь халдах, эд материалын хохирол учруулдаг байна.

Шигтгээ 7.4 *Уурхай ид ажиллаж байх үед гар аргаар алт олборлогсдын дунд газраа булаалдах, хоорондоо зодолдох, бие биенээ хүтгалах, нүх рүү шидэх зэрэг гэмт хэргүүд их гардаг байсан. Манай нутгийн Залуу сураггүй алга болсон. Жилийн дараа алт угаадаг »тогтоосон« нуурнаас 2–ынх нь шарил нь гарч ирсэн. Одоо хүртэл нэгнийх нь шарил олдоогүй. Нутгийн хүмүүс гар аргынхнаас их эмээж, жихүйцдэг.*

Архангай, Цэнхэр сум. Цагдаагийн ажилтан

7.3 Зан байдлын өөрчлөлт, амьдрах арга барилын үнэлэмж


Ажиллаж буй хүмүүсийн хоорондын харилцаа, орчин зэрэг нь хувь хүний төлөвшилд нилээд үүрэгтэй байдаг. Алт олборлох үйл ажиллагаа эрчимжсэн сүүлийн 10 жилд албан уурхайт дагасан гар аргаар алт олборлогсод бий болсноор амьдралын шинэ орчин, бүлэг үүссэн. Алт олборлох ажил хийж эхэлснээс хойш хувь хүний зан байдалд өөрчлөлт гарсан эсэхийг тодруулав .

Хүснэгт 7.3 Алт олборлох ажил хийж эхэлснээс хойш
 зан чанар өөрчлөгдсөн байдал, хувийн жин

Үзүүлэлт	Зан чанарын хувьд өөрчлөгдж байгаа эсэх			Нийт
	Тийм	Үгүй	Мэдэхгүй	
Насны бүлэг				
15-24	21.5	22.6	25.8	22.6
25-34	26.2	31.8	35.5	30.6
35-44	39.3	26.1	16.1	28.8
45 +	13.1	19.5	22.6	18.0
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
Хүний тоо	107	261	31	399

Судалгаанд оролцогчдын 65.0 хувь нь өөрсдийгөө зан байдлын хувьд өөрчлөгдөөгүй хэмээн үзэж байгаа бол өөрчлөгдсөн гэж хариулсан хүмүүсийн 57.1 буюу дийлэнх хувь нь хүнд итгэхээ больсон гэжээ. Цөхрөмтгий, мөрөөдөмтгий болсон гэж нийт 58.0 хувь нь, өөдрөг бодолтой болсон гэж 16.8 хувь нь хариулсан байна.

Зураг 7.02 Алт олборлогсдын зан байдалд гарч байгаа
өөрчлөлт, хувийн жин



Зан байдал нь өөрчлөгдөөгүй гэж үзэж байгаа хүмүүсийн 49.5 хувь нь алт олборлох ажилдаа сэтгэл дундуур байдаг бол 29.0 хувь нь сэтгэл хангалаа, 21.5 хувь нь хангалаа бус байдаг гэжээ.

Насаар нь авч үзвэл хүнд итгэхээ больсон хүмүүсийн дийлэнх нь буюу 37.2 хувь нь 26-45 насны хүмүүс байна. Өөдрөг бодолтой болсон гэж хариулагчдын 55.6 хувь нь 16-35 насныхан байлаа.

Ар талдаа гэр бүлтэй боловч орой үдшийн цагаар амар тайван байлгахгүй байдлыг шийдвэрлэхийн тулд алт олборлогч хоёр залуутай хамтран амьдрах болсон эгч, дүү хоёрын жишээнээс гэр бүлийн харилцааны зан байдал хэрхэн өөрчлөгдж байгааг харж болно. Мөн гар аргаар алт олборлож буй газарт гэмт хэрэгт холбогдож байсан, широнгоос гарсан гэх мэт зүсэн зүйлийн хүмүүс/архидах, зодоон цохион хийх, бусдыг дарамтлах/ сөрөг зан үйлд бусдыг уруу татах хандлага их гардаг байна. Хэдийгээр судалгаанд оролцогчдын дийлэнх нь зан байдлын хувьд өөрчлөгдөөгүй гэж хариулж байгаа ч тэд «газар», »алт»-ны төлөө амь өрсөн тэмцдэг болж, өөрийгөө хамгаалах зөнгөө хамгийн сайн хэрэгжүүлдэг болсон байв.

Одоогийн ба алт олборлооос өмнөх амьдрах арга барилын алийг нь илүүд үзэж байна вэ гэсэн асуултанд 54.4 хувь нь өмнөх гэж, 30.1 хувь нь одоогийнх гэж, 15.5 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулжээ.

Хүснэгт 7.4 Алт олборлох болон түүнээс өмнөх амьдрах арга барилаа үнэлсэн байдал

Үзүүлэлт	Хүний тоо	Эзлэх хувь
Өмнөх нь	217	54.4
Одоогийнх нь	120	30.1
Хэлж мэдэхгүй	62	15.5
Нийт	399	100.0

Амьдралын өмнөх арга барилаа илүү гэж үзсэнийг соёлд холбогдох бэрхшээлтэй холbon үзвэл 46.1 хувь нь бие хүний хувьд хөгжих боломжгүй, 26.1 хувь нь харилцаа, хүмүүжил доголдох гэсэн хариултыг сонгосон хамаарал гарч байна.

Алт олборлох ажил эрхэлдэггүй хүмүүсийн зүгээс тэдэнд хандах байдлыг үнэлэхэд 84.2 хувь нь хэвийн, 4.3 хувь нь дээрэнгүй, 1.5 хувь нь гадуурхдаг, 7.3 хувь нь дэмждэг, 6.0 хувь нь дургүйцэж, 1.3 хувь нь бусад хэмээн үзжээ.

Алт олборлож буй энэ ажилдаа судалгаанд оролцогчдын 25.3 хувь нь сэтгэл хангалиун, 56.6 хувь нь сэтгэл дундуур, 18.0 хувь нь сэтгэл хангалиун бус байлаа.

Дээрхи байдлаас харахад гар аргаар алт олборлогсдын дийлэнх нь энэ ажилдаа сэтгэл дундуур, хангалиун бус байгаа бөгөөд тэдний эрүүл мэндэд «сэтгэл зүй»-н сөрөг хүчин зүйлсийн нөлөө их байна.

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан алт олборлогсдод бие хүний хувьд хөгжих боломжгүй байх, үйл ажиллагаа зохицуулах хууль эрхийн акт байхгүй, харилцаа, хүмүүжил доголдох, соёлын бараа, үйлчилгээний хомдол зэрэг бэрхшээл зонхилон тохиолддог байна. Бие хүний хувьд хөгжих боломжгүй гэж хариулсан хүмүүсийн дийлэнх нь 16-35 насныхан байлаа.
- Гар аргаар алт олборлогсдод чөлөөт цаг, завсарлагааг үр өгөөжтэй өнгөрөөх, бие хүний хувьд хөгжихөд нөлөө бүхий хэвлэл, мэдээлэл, үзвэр үйлчилгээ зэрэг соёлын зүйлс нэн шаардлагатай байгаа ажээ.
- Хэдийгээр хүний амиа бodoх төрөлх зөн, аиж эмээх үндсэн зан чанар гар аргаар алт олборлогсдын дунд хэвээр байгаа ч нийтлэг баримталдаг зарим нэг хорио цээр (табу)-үүд алдагдаж, хэнээс ч юунаас ч үл эмээх, үл хүндэтгэх сөрөг байдал илэрч байна.
- Алт олборлох ажил эрхэлснээр тэдний нилээд хэсэгт нь хүнд итгэхээ болих, цөхрөмтий болох, зан байдал нь өөрчлөгдөх зэрэг зан төрхийн өөрчлөлтүүд илэрсэн байна.

- Тэдний дийлэнх нь алт олборлооос өмнөх амьдрах арга барилаа илүүд үзэж энэ ажилдаа сэтгэл дундуур буюу сэтгэл хангалуун бус байв.

Санал, зөвлөмж

- Гар аргаар алт олборлогсодод соёлын хэрэгцээ их байгаа нь судалгаанаас харагдаж байгаа учраас соёлын бараа, үйлчилгээг зохих хэмжээнд нийлүүлж, тэдний амьдрах, ажиллах орчинг сайжруулах боломж байна. Жишээ нь, ном, сонин, сэтгүүлийн захиалга, түгээлт, гар аргаар алт олборлогсдын хүүхдийг сургах, хүмүүжүүлэх гэр цэцэрлэг байгуулах гэх мэт зүйлийг сэдэж, өөрсдөөр нь гардан хийлгэж, зохион байгуулж болох юм.
- Судалгаандоролцогчдын дийлэнх нь боломж олдвол өөржилхийх сонирхолтойгоо илэрхийлж байгаагаас тэдэнд шаардлагатай мэргэжлийн сургалт явуулах, алт олборлооос өөрөөр амьдрах арга ухаан зааж сургасан зөвлөгөө, зөвлөмж бүхий сонин, сэтгүүл эрхлэн гаргах зэрэг үйл ажиллагааг эхлүүлбэл тэдний амьдралд эерэгээр нөлөөлж болох талтай.
- Амралт, чөлөөт цагаараа цагийг үр дүнтэй өнгөрүүлэх орчин /тусгайлан тохижуулсан тоглоомын талбай, спортын талбай гэх мэт/ бүрдүүлбэл тэдний социаль зан үйл, соёлд эерэг нөлөө үзүүлнэ
- Эдгээрийг цогц байдлаар шийдвэрлэх нь тэдний дундах сэтгэл зүйн сөрөг нөлөө, хэрэг зөрчлийг бууруулах ач холбогдолтой.

Бүлэг VIII

НЭГДСЭН ДҮГНЭЛТ,
БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ



Бүлэг VIII. Нэгдсэн дүгнэлт, бодлогын зөвлөмж

I. Дүгнэлт

- Судалгаанд хамрагдагсдын голч нас 33, хүйсийн харьцаа 1.8 байгаа бөгөөд 20-24 наасны, ганц бие эрчүүд, 35-39 наасны эмэгтэйчүүд гэр бүлийн хамт гар аргаар алт олборлох ажлыг хийж байна. Тэдний дийлэнх нь бүрэн бус дунд боловсролтой, алт олборлох ажлыг эрхэлсэн дундаж хугацаа 4.1 жил байв. Алт олборлогсдын ажлын төрлийг хүйсээр нь харьцуулан үзэхэд эрэгтэйчүүд чулуу бутлах, тэсэлгээ хийх, мөнгөн усаар алт бариулах, эмэгтэйчүүд шороо зөөх, шигших, алттай шороог угаах, ус зөөх зэрэг ажлыг хийдэг байна.
- Гар аргаар алт олборлогсдын ажлын байр, амьдрах орчин буюу сууц нь нэг дор, унд-ахуйн болон технологийн усны хангамж хүрэлцээ муутай нөхцөлд ажиллаж, амьдарч байдгаас алт олборлох явцад үүсдэг эрсдэлт хүчин зүйлсийн нөлөөнд 24 цагийн туршид өртөж байгаа тул тэд эмгэг үүсэх «хүч нэмэгдүүлэх» шалтгааны нөлөөнд байнга байна. Тэдний ажиллаж, амьдарч байгаа орчинд зориулалтын бие засах газар, гар нүүрийн угаалтуур, халуун усны газар байхгүй, ахуйн болон технологийн үйл ажиллагаанаас гарсан бохир усыг зайлцуулах эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байгууламж, цооног байхгүйгээс бохир усаа шууд хөрс рүү хаядаг тул хүн ам олноор суурьшсан эдгээр газарт хөрсний бохирдлыг ихэсгэж байна.
- Судалгаанд хамрагдсан уурхайд ажиллаж буй гар аргаар алт олборлогсдын 85.2 хувь нь орон нутгийн, 14.8 хувь нь гаднаас ирсэн иргэд байгаа бөгөөд тал хувь нь хоёроос дээш ам бүл, хамаатан, садны хүнтэйгээ хамтран олон жил ажиллаж мэргэшсэн байдал нь тэднийг нөхөрлөлийн хэлбэрээр бичил уурхайн зохион байгуулалтанд оруулж ажиллахад дөхөмтэй байж болох юм.
- Өөр нутгийн харьят гар аргаар алт олборлогсдын дийлэнх нь иргэний бүртгэлд хамрагдаагүй, бүртгүүлээгүй шалтгаанд бүртгүүлэх шаардлагагүй, мэдэхгүй зэрэг орж байгаа бол бүртгүүлэх шаардлагатай гэж үзэж буй бүртгэлгүй иргэдэд шилжүүлгийн бичиггүй (шилжүүлгийн бичиг шаардлагатайг мэдээгүй, түүнийг авахад их хугацаа зарцуулдаг), иргэний үнэмлэх, бусад бичиг баримтгүй, бүртгүүлэхээ мэдэхгүй байх хүндрэл тохиолддог байна.
- Тэдний алт олборлох ажлыг эрхлэх болсон шалтгаанд хүүхдийн сургалтын төлбөр, өр зээлээ төлөх, орон байртай болох, эмчилгээний зардал олох бөгөөд хамгийн гол шалтгаан нь ажил олдохгүйгээс амьжиргаагаа залгуулах эх үүсвэр болж байгаа

гэжээ. Сарын дундаж орлогын хэмжээ нь Монгол улсын «Хүн амын амьжиргааны түвшний доод хэмжээ»-ээс 20 хувиар их бөгөөд орлогын хэмжээ нь ордын төрөл, алт олборлогчийн ажилласан хугацаа, дадлага, туршлага, ур чадвараас шалтгаалж байгаа ба олсон алтаа борлуулж буй гол хэлбэр нь газар дээр нь бага үнээр хүнсний дэлгүүрт өгөх, бараагаар солих зэрэг ажээ.

6. Гар аргаар алт олборлогсдын ажлын байрны тоос, шуугиан, доргион эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их байгаа нь ажилчид тоосны гаралтай уушиг тоосжих, шуугианы гаралтай сонсгол муудах, дүлийрэх, яс булчин тулгуур хөдөлгөөний эрхтэний эмгэг үүсэх эрсдэлтэй байна. Мөнгөн усаар алт бариулж байгаа алт олборлогсод түүний нөлөөнд өртөж улмаар түүний хадгалалт, хаягдлыг зайлцуулж байгаа зэргээс шалтгаалан тэнд ажиллагсдаас гадна, ус, хөрс бохирдож байна.
7. Гар аргаар алт олборлогсод эргономикийн тохиромжгүй нөхцөлд ажиллаж, биеийн хүчний хүнд ажлыг хийдэг бөгөөд нэг маягийн хөдөлгөөний давталт ихтэй, биеийн тохиромжгүй, албадмал байрлалд, давчуу зайд ажилладаг, халтирах, тээглэх, унах, юманд цохиулах, даруулах, иртэй болон хөдөлгөөнтэй багаж хэрэгсэлтэй харьцах үед хавчуулагдах, зүсэгдэх зэрэг осол гэмтэлд өртөх эрсдэл өндөртэй байна.
8. Тэд зориулалтын хувийн хамгаалах хувцас хэрэгсэл (бээлий, амны маск, шүүгч баг зэргийг) хэрэглэдэггүй, өөрсдийн өдөр тутам өмсдөг ердийн гутал, ажлын хувцастайгаа ажилладаг бөгөөд хувийн хамгаалах хэрэгслийг сонгох, хэрэглэх мэдлэг, хандлага хангалтгүй байна.
9. Ажлын өдөрт алт олборлогсод дунджаар 10 цаг ажиллан ажлын өдрийн цаг, завсарлага, долоо хоногийн амралтын өдөр зэрэг нь алтны олдоц, улирлын байдал, цаг агаар зэргээс хамаардаг бөгөөд тэдэнд баримтлах хөдөлмөр-амралтын тогтсон горим байдаггүй байна.
10. Гар аргаар алт олборлогч эмэгтэйчүүдийн дунд эмнэлгийн тусlamж авах хэрэгцээ эрчүүдтэй харьцуулахад 2 дахин илүү байгаа бөгөөд дийлэнх нь эмнэлгийн тусlamжийг иргэний бүртгэлтэй эсэхээс хамаarahгүйгээр сумын эмнэлгээс авч байна.
11. Хөдөлмөрийнхүнднөхцөл, гүйцэтгэж буй ажилүүргийн төрлөөс шалтгаалантэдний дунд шээс бөөрний замын, амьсталын замын, тулгуур эрхтэний болон халдварт өвчинүүд зонхилон тохиолдож байна. Түүнчлэн ажил эрхлэлттэй холбоотойгоор олс тасрах, нүхэнд унах, шороо, нурангад дарагдах зэргээс шалтгаалсан осол гэмтлүүд элбэг тохиолддог байна. Алт олборлох үйл ажиллагаатай холбогдсон осол гэмтэл, мэргэжлийн өвчинд өртөж байгаа боловч тэдгээрийн тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговорт аж ахуйн нэгжийн зохион байгуулалтгүйгээс шалтгаалан хамрагдах боломжгүй байна.
12. Алт олборлогсдын тал хувь нь гэнэтийн, яаралтай тохиолдолд эмнэлгийн тусlamжийг 2 цагийн дотор авах боломжгүй байна. Эрүүл мэндийн тусlamж авахад гардаг гол бэрхшээлд тэдний хаяг тодорхойгүй, алслагдмал байдал, тээврийн хэрэгсэл дутмаг, холбоо харилцаа байхгүй зэрэг орж байна. Тэдэнд баталгаат, зайлшгүй шаардлагатай эмийн үйлчилгээ, эмчийн үзлэг, оношлогоо, нарийн

мэргэжлийн үзлэг, осол гэмтлээс сэргийлэх, өвчнөөс сэргийлэх мэргэжлийн зөвлөгөө, хяналт, эрүүлжүүлэх үйл ажиллагаа, нөхөн үржихүйн тусlamж, үйлчилгээ шаардлагатай байна.

13. Гар аргаар алт олборлогсод тухайн орон нутагт иргэний бүртгэлгүй, иргэний бичиг баримтгүй байх зэргээс халамжийн үйлчилгээнд хамрагдах шаардлагыг хангаагүйгээс түүнийг хүртэж чадахгүй байгаа төдийгүй тэтгэврийн насанд хүрэх үедээ нийгмийн даатгалын шимтгэлийг 20-иос дээш жил төлөх боломжгүй болсон буюу бүрэн тэтгэвэр тогтоолгох нөхцлийг хангаж чадахгүй болсон алт олборлогчид нилээд хувийг эзэлж байна. Гар аргаар алт олборлож буй ахмадуудад өндөр насны, хүүхэд, эмэгтэйчүүдэд халамжийн тэтгэмж, харин нийгмийн даатгалын төрлүүдээс үйлдвэрлэлийн ослын даатгалыг нийт гар аргаар алт олборлогсодод илүү хэрэгцээтэй байгаа ажээ.
14. Судалгаанд хамрагдсан алт олборлогсод зонхилон тохиолддог бэрхшээлтэй зүйлсд бие хүний хувьд хөгжих боломжгүй байх, үйл ажиллагаа зохицуулах хууль эрхийн акт байхгүй, харилцаа, хүмүүжил доголдох, соёлын бараа, үйлчилгээний хомсдол байдал байна. Гар аргаар алт олборлогсод чөлөөт цаг, завсарлагааг үр өгөөжтэй өнгөрөөх, бие хүний хувьд хөгжихэд нөлөө бүхий хэвлэл, мэдээлэл, үзвэр үйлчилгээ зэрэг соёлын зүйлс нэн шаардлагатай байгаа ажээ.
15. Тэдний хувьд алт олборлох үед хамгийн түрүүнд тохиолддог бэрхшээл нь ус, цахилгаан, гэр оронтой байхаас илүүтэйгээр дарагдах, нурах, осол гэмтлээс айх, түгшүүртэй байдал гэж үзэж байгаа нь «байр, хоол, хувцас зэрэг хүний суурь хэрэгцээнээс» илүүтэйгээр сэтгэлзүйн бэрхшээл давамгайлж байна
16. Хэдийгээр хүний амиа бodoх төрөлх зөн, аиж эмээх үндсэн зан чанар гар аргаар алт олборлогсдын дунд хэвээр байгаа ч нийтлэг баримталдаг зарим нэг хорио цээр (табү)-үүд алдагдаж, хэнээс ч юунаас ч үл эмээх, үл хүндэтгэх сөрөг байдал илэрч байна. Алт олборлох ажил эрхэлснээр тэдний нэлээд хэсэгт нь хүнд итгэхээ болих, цөхрөмтгий болох, зан байдал нь өөрчлөгдөх зэрэг зан төрхийн өөрчлөлтүүд илэрсэн бөгөөд дийлэнх нь алт олборлохоос өмнөх амьдрах арга барилаа илүүд үзэж энэ ажилдаа сэтгэл дундуур буюу сэтгэл хангалуун бус байв.

II. Бодлогын зөвлөмж

«Гар аргаар алт олборлогсдын нийгэм, эдийн засгийн байдал, тусlamж үйлчилгээний хүртээмж, хэрэгцээ» судалгааны ажлын үр дүнд үндэслэн Монгол улсын бодлого боловсруулагчид, энэхүү асуудалд холбогдох гол түншүүдийн анхааралд дараах зөвлөмжийг толилуулж байна. Үүнд:

Гар аргаар алт олборлогсдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг баталгаажуулах талаар

- Гар аргаар алт олборлогсдын уг ажлыг эрхэлж буй зорилго (амьжиргаагаа залгуулах), олон жил ажиллан, алт олборлох ажлын тодорхой туршлагатай болсон, дийлэнх нь ам бүл, хамаатан саднаараа хамтран ажиллаж байгааг харгалзан тэднийг сонирхлынх нь дагуу «нөхөрлөл» эсвэл «ажлын баг»-ийн хэлбэрээр зохион байгуулалтад оруулж, хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж болгон бүртгэлжүүлэх;

- Гар аргаар алт олборлогсдын тухай мэдээллийг тухайн орон нутгийн засаг захиргаагаар дамжуулан жил тутам гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн асуудал, хөдөлмөрийн зах зээлийн албан бус хэвшил дэх тэдний үүрэг, оролцоог тодорхойлж байх, бодлого боловсруулагч, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангадаг болох;
- Гар аргаар алт олборлогсдын эрхэлж буй ажил хөдөлмөр зарцуулалт ихтэйг анхааран тэднийг энгийн, хямд төсөр, ашиглаж болохуйц техник, тоног төхөөрөмжтэй болоход туслах, үүнийг бичил санхүүгийн харилцаа буюу жижиг зээл, түрээсээр дамжуулан хэрэгжүүлэх;
- Гар аргаар алт олборлогсдын өмнө тулгамдаж буй гол асуудлын нэг нь олборлосон алтаа борлуулах, хадгалахтай холбоотой хүндрэлүүд тул тухайн ажиллаж байгаа нутаг дэвсгэр, орон нутгийн нөхцөлд худалдаалах, борлуулах арга замыг (явуулын банк ажиллуулах, орон нутгийн банкны салбаруудадалт худалдан авах, худалдаалах эрх олгох гэх мэт) бий болгох боломжийг судалж, санхүүгийн эрсдэлт байдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх;
- Гар аргааг алт олборлогсдын өөр ажил хийх хүсэл эрмэлзэлтэй байгааг анхааран тэдний мэргэжил, ур чадварт тохирох ажлын байр бий болгох, алт олборлохоос өөр ажлын ур чадвар, арга ухаан эзэмшүүлэхийн тулд сургалтад хамруулах, зөвлөлгөө өгөх, тэднийг гарын авлага, зөвлөмж зэрэг баримт материалаар хангах үйл ажиллагааг явуулах;
- Гар аргаар алт олборлогсдын ажлын байран дах ялгаварлан гадуурхал, хүчирхийлийг арилгах үүднээс орон нутгийн засаг захиргаа, цагдаагийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын үйл ажиллагааг чиглүүлэх, тэдний хүчин чармайлтыг дэмжих;

Гар аргаар алт олборлогсдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулах талаар

- Гар аргаар алт олборлогсдын ажлын байрны үнэлгээний талаарх судалгааны дүнт ашиглан ОУХБ-аас гаргасан Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн арга хэмжээ, ЭМНХ-ын сайдын 1999 оны А/204, А/206, НХХ-ын сайдын 2002 оны 122 дугаар тоот тушаалыг хэрэгжүүлэх замаар хөдөлмөрийн нөхцөл ба орчинг сайжруулахын тулд: (i) эх үүсвэр (ashiглаж буй багаж, техникийг боловсронгүй болгох); (ii) дамжих зам (ажлын явц, дамжлагын үед хүнд очих эрсдэлийг бууруулах); (iii) алт олборлогч хувь хүмүүс гэсэн чиглэлээр сургалт, сурталчилгаа, практик үйл ажиллагааг явуулах. Үүнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд, хамт олон, сайн дурынхан, хувь хүмүүсийг татан оролцуулах;
- Гар аргаар алт олборлогсдын эрхэлж буй үйл ажиллагааны аюултай, эрсдэлтэй, эрүүл мэндэд хор хөнөөлтэй байдлыг харгалзан эрүүл мэндийн байнгын үзлэгт жилд хоёроос доошгүй удаа хамруулж байх нөхцөл бололцоог хангаж, энэхүү ажлыг нэн даруй эхлүүлэх;
- Гар аргаар алт олборлогсдын хөдөлмөрийн эрүүл ахуйн талаарх мэдлэг, хандлага, дадал туршлага хангалтгүй байгааг анхааран энэ талаарх сургалт, сурталчилгаа, мэргэжлийн тусламж, үйлчилгээ, зөвлөлгөө өгөх ажлыг мэргэжлийн байгууллага, сайн дурынхан, НЭМ ажилтнаар дамжуулан зохион байгуулах;
- Гар аргаар алт олборлогсдын хортой, аюултай бодис (мөнгөн ус, тэсэлгээний бодис гэх мэт) хэрэглэж байгаа байдлыг таслан зогсоох үүднээс эдгээр бодисуудыг алт олборлох үйл ажиллагаандаа хэрэглэх, худалдан борлуулахыг хориглосон заалтуудыг шинээр боловсруулагдаж буй «Гар аргаар алт олборлогсдын тухай хууль»-ийн төсөлд тусгах;

- Гар аргаар алт олборлогсдын дунд мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн осол гэмтэл түгээмэл байгааг анхааран орон нутгийн засаг захиргаа, хөдөлмөрийн байцаагч нарыг энэхүү асуудлыг бүртгэдэг, шалтгаан үр дагаврыг тогтоодог, урьдчилан сэргийлдэг болгох талаар шинээр боловсруулагдаж буй «Гар аргаар алт олборлогсдын тухай хууль»-ийн төсөлд тусгах;

Гар аргаар алт олборлогсдыг эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ, нийгмийн даатгал, халамжид хамруулах талаар

- Гар аргаар алт олборлогсдыг нийгмийн даатгал, нийгмийн суурь тусlamж үйлчилгээнд хамруулах боломжийг бүрдүүлэх. Үүний тулд Монголулсын одоогийн мөрдөгдөж буй нийгмийн даатгал, халамжийн талаарх хууль тогтоомжийг албан бус хэвшлийнхнийг нийгмийн даатгалд хамруулах талаарх олон улсын хэм хэмжээ, «Нийгмээс тусгаарлах ба ядуурлын эсрэг байдлын тухай ОУХБ-ын стратеги хөтөлбөр (STEP)» зэрэгтэй харьцуулан судалж, сайн дурын нийгмийн даатгалд хамруулах талаар арга хэмжээ явуулах;
- Алт олборлох үйл ажиллагаатай холбогдон гарч буй мэргэжлээс шалтгаалах өвчин, осол гэмтлийг цаг тухайд нь бүртгэн, гар аргаар алт олборлогсдыг мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, нөхөн олговорт хамруулах боломжийг бүрдүүлэх;
- Гар аргаар алт олборлогсдыг тухайн орон нутагт түр ба байнга оршин суугчаар бүртгэх замаар нийгмийн даатгал, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ, нийгмийн халамжид хамруулах боломжийг бүрдүүлж, шаардагдах төсөв хөрөнгийг орон нутгийн эмнэлгийн төсөвт тусгах, зарцуулах эрхийг хангах;
- Гар аргаар алт олборлогсдын дунд явуулын үйлчилгээгээр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран нэгдсэн байдлаар зохион байгуулах;
- Гар аргаар алт олборлогсдын гэр бүлийн гишүүд ялангуяа, бага насын хүүхэд, ахмад настан, төрөх насын эмэгтэйчүүдэд нийгмийн эрүүл мэндийн яаралтай болон зохих тусlamжийг цаг тухайд нь үзүүлэх;

Гар аргаар алт олборлогсдын соёл, ахуйн хэрэгцээг сайжруулах талаар

- Гар аргаар алт олборлогсдын амьдарч, ажиллаж буй юрчин ахуй эрүүл мэндийн эрсдэлийг бий болгох, байгаль орчинд хор хөнөөл учруулахаас урьдчилан сэргийлэх үүднээс явуулын нийтийн ариун цэврийн хэрэгслүүд, халуун усны үйлчилгээтэй болгох;
- Гар аргаар алт олборлогсод сургуулийн өмнөх болон сургуулийн насын хүүхдүүдийн хамт амьдарч, ажиллаж байгааг харгалзан хүүхдүүдийг сургуулиас завсардахаас сэргийлэх, хүүхдүүдийг суралцах, хүмүүжих нөхцлөөр хангах үүднээс гэр цэцэрлэг, сургууль ажиллуулах;
- Гар аргаар алт олборлогсдын хувьд бие хүний хувьд хөгжих боломж хязгаарлагдмал, хүмүүс хоорондын харилцаа сул, доголдолтой байдгаас сэтгэлээр унах, айж эмээх, сэтгэл санаа тавгүйтэх зэрэг үзэгдэл түгээмэл байдаг тул тэдэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх;

Дээрх асуудлуудад төр засаг анхаарал хандуулан, цогц байдлаар арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлбээс гар аргаар алт олборлогсодтой холбоотой зарим тулгамдсан асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэх боломжтой юм.

Хавсралт

.....

- АШИГЛАСАН НОМЫН ЖАГСААЛТ
- ГАР АРГААР АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН АСУУЛГА
- ГАР АРГААР АЛТ ОЛБОРЛОГЧДЫН НИЙГМИЙН ТУСЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙХ ЯРИЛЦЛАГЫН УДИРДАМЖ
- ХӨДӨЛМӨРИЙН БОЛОН ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙН ТОХИРОМЖГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТОДОРХОЙЛОХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хавсралт I. Ашигласан номын жагсаалт

1. Монгол улсын Засгийн газар. 1996. Монгол улсын хүн амын бодлого. Улаанбаатар.
2. Монгол улсын Үндэсний Статистикийн Газар. 1999. Монгол улсын статистикийн эмхэтгэл . Улаанбаатар.
3. Монгол улсын Үндэсний Статистикийн Газар. 2000. Монгол улсын хүн ам, орон сууцны тооллого. Улаанбаатар.
4. Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар. 2000. Амьжиргааны түвшинг тооцооны аргаар судлах нь. Улаанбаатар,
5. Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар. 2003. Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан 2002-2003. Улаанбаатар.
6. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс. 2003. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл. Улаанбаатар.
7. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс. 2004. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл. Улаанбаатар.
8. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс. 2005. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл. Улаанбаатар.
9. Улсын Их Хурлын Нийгмийн Бодлогын Байнгын Хороо, НХХЯ, Хүн Амын Хөгжлийн Асуудлаарх Азийн Парламентчдын Форум, НҮБ-ын Хүн Амын Сан. 2005. Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаарх үндэсний дээд хэмжээний уулзалт. Улаанбаатар.
10. Улсын Их Хурлын Тамгын газар. Төрийн мэдээлэл 15. 2003. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл. Улаанбаатар.
11. Нэгдсэн Үндэсний Байгууллага. 1994. Хүн ам ба хөгжил Олон улсын бага хурлаас гаргасан баримт бичиг. Кайро.
12. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүн Амын Сан, Үндэсний Статистикийн Газар. 2003. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа. Улаанбаатар.

13. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо. 2005. Алтны шороон ордыг гар үйлдвэрлэлийн аргаар олборлох үеийн аюулгүй ажиллагаа. Улаанбаатар.
14. Дэлхийн Банк. 2005. Монгол орны уул уурхайн салбараас байгаль орчин болон нийгмийн салбарт үзүүлж буй нөлөө. Улаанбаатар.
15. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, МУИС-ийн ЭЗС-ийн Хүн Ам, Сургалт Судалгааны Төв. 2006. Албан бусаар алт, жонш олборлож буй хүүхэд, насанд хүрэгчдийн суурь судалгаа. Улаанбаатар.
16. Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам, Хүн Амын Сургалт Судалгааны төв, НҮБ-ын Хүн Амын Сан. 2001. Хүн амын дотоод шилжилт хөдөлгөөний микро түвшний судалгаа. Улаанбаатар.
17. Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам. 2006. Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн хууль, тогтоомжийн эмхтгэл. Улаанбаатар.
18. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага. 2006. Монгол дахь албан бусаар алт олборлолт. Улаанбаатар.
19. Монголмаа, Н. 2005. Монгол улсын жижиг уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт. Улаанбаатар.
20. Худалдаа, Аж Үйлдвэрийн яам. 2004. Геологийн салбарын тайлан сар тутмын хэвлэл. Улаанбаатар.
21. Монгол Улсын Засгийн Газар. 2005 оны 9 сарын 16. Гар үйлдвэрлэлийн аргаар ашигт малтмал олборлох тухай хуулийн төсөл.

Хавсралт II. Гар аргаар алт олборлогч иргэдийн асуулга

Таны нууцыг хадгална

Аймгийн нэр	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>		
Сумын нэр	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>		
Уурхай, газрын нэр	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>		
Хариулагчийн дугаар	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>		
Та ямар уурхайн ордод ажилладаг вэ	Үндсэн орд - 1	Шороон орд - 2	<input type="checkbox"/>
Ярилцлага авсан	Cap	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>	Өдөр
Ярилцлага авагчийн нэр	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>		
Багийн ахлагчийн нэр	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>		
Засварлагчийн нэр	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>		
Шивэгчийн нэр	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>		

Бүлэг 1. Ерөнхий шинж байдал

No.	Асуулт	Хариулатын код	Алхам
101	Та хэдэн настай вэ? (бүтэн жилээр)	Нас	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>
102	Хүйс	Эрэгтэй Эмэгтэй	1 2
103	Таны тэрлэлтийн байдал	Огт гэрлээгүй Гэрлээн Тусгаарласан/цуцалсан Бэлэвсэн Хамтран амьдардаг	1 2 3 4 5
104	Та ямар боловсролтой вэ?	Бага Бүрэн бус дунд Бүрэн дунд Мэргэжлийн болон техникийн Дээд Боловсролгүй бичиг үсэг мэддэг бичиг үсэг мэддэггүй	1 2 3 4 5 6 7

Section 2. Migration and registration

201	Та хаанаас ирж ажиллаж байна	Аймаг / хот Сум / дүүрэг	
202	Энэ уурхайд танай ам бүлээс хэдэн хүн ажиллаж байна вэ?	Too <input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>	
203	Энэ газраа ажиллаж эхэлсэн хугацаа	Жил <input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/> Cap <input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>	
204	Таны алт олборлох ажил эрхлэх болсон гол зорилго тань юу вэ?	Xүүхдийнхээ сургалтын төлбөр төлөх A Орон байртай болох B Өр зээлээ төлөх C Эмчилгээнд зарцуулах D Амьжиргаагаа залгуулах E Орлого олох өөр боломжгүй болсон F Бусад X	
205	Алт олборлох ажил эрхлэхэд тань хамгийн түрүүнд тохиолддог бэрхшээлийг нэрлэнэ үү	Байр, орон сууц A Газрын зөвшөөрөл олдохгүй байх B Ус, цахилгаангүй C Хуучин ажиллаж байсан хүмүүсээс айх/дарамтлуулах D Дарагдах, нурах, осол гэмтлээс айх, түгшүүртэй байх E Сургууль, цэцэрлэг олдохгүй байх F Нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдахгүй байх G Эрүүл мэндийн тусlamж хүртэх боломжтүй байх H Бусдад ялгаварлан гадуурхагдах I Танил тал хамаатан садангийн дэмжлэг байхгүй J Бусад X	
206	Та хэдэн газар алт олборлох ажил эрхэлж байна вэ?	Too <input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>	
207	Танд одоо иргэний бүртгэлийн ямар нэгэн бичиг баримт байгаа юу? /Жишигээлбэл иргэний үнэмлэх/	Иргэний үнэмлэх A Гадаад поспорт B Эрүүл мэндийн даатгалын дэвтэр C Нийгмийн даатгалын дэвтэр D Жолооны үнэмлэх E Төрсний гэрчилгээ F Ажлын газрын үнэмлэх G Ямарч бичиг баримтгүй H Бусад X	
208	Та энэ орон нутагтаа иргэний бүртгэлд бүртгүүлсэн үү?	Тийм 1 Үгүй 2	213

209	Та яагаад иргэний бүртгэлд бүртгүүлээгүй вэ?	Бүртгүүлэх шаардлагагүй Шилжүүлгийн бичиггүй Иргэний үнэмлэхгүй Бусад иргэний бичиг баримтгүй Санхүүтийн боловсруулжгүй Хаана бүртгүүлэхийг мэдэхгүй Бүртгүүлэх сонирхолгүй Завгүй Бүртгүүлэх үйл ажиллагаа шат дамжлаг ихтэй Бусад	A B C D E F G H I X	301
210	Та орон нутгийнхаа бүртгэлийн байгууллагад ер нь хандаж байсан уу?	Тийм Үгүй	1 2	
211	Ер нь орон нутгийн засаг захиргаанд бүртгүүлэх шаардлагатай юу	Тийм Үгүй	1 2	301
212	Ямар тохиолдолд бүртгүүлэх шаардлагатай гэж бодож байна	Эрүүл мэндийн тусlamж авах Яаралтай тусlamж авах Давхар ажил эрхлэх Энд суурьших Нийгмийн халамж үйлчилгээ хүртэх Бусад	A B C D E X	301
213	Бүртгүүлэх үед танаас шалтгаалсан хүндрэл гарсан уу?	Тийм Үгүй	1 2	215
214	Ямар хүндрэл гарсан бэ?	Шилжүүлгийн бичиггүй Иргэний үнэмлэхгүй Бусад иргэний бичиг баримтгүй Бүртгэлийн хураамж төлөх чадваргүй Завгүй Эрүүл мэндийн байдлаас Бүртгүүлэх аргаа мэдэхгүй Бүртгүүлэх хүсэлгүй Бусад	A B C D E F G H X	217
215	Бүртгүүлэх үед бүртгэлийн байгууллагаас шалтгаалсан хүндрэл гарсан уу?	Тийм Үгүй	1 2	301
216	Бүртгэлийн байгууллагаас юу шалтгаалж байна вэ?	Дараалал ихтэй байдал Бүртгэлийн ажилтантай уулзах боломж хомс Хэтэрхий олон баримт шаардлаг Бүртгэхээс татгалздаг, бүртгэх сонирхолгүй Ажилтны харилцааны соёл дутмаг Бүртгүүлэх үйл явцын тухай мэдээлэл хомс Олон очих шаардлагатай болох Шилжүүлэг хийж өгдөггүй Бусад	A B C D E F G H X	301
217	Шалга! Хэрэв 214=A	Хэрэв 214 А-аас бусад тохиолдол бол		301

218	Та яагаад шилжүүлэг хийлгээгүй бэ?	Бүртгүүлэхэд шилжүүлгийн бичиг шаардлагатайг мэдээгүй	A
		Шилжүүлгийн бичгийг өгөхөөс татгалзсан	B
		Шилжүүлэг авахад хугацаа их шаарддаг	C
		Шилжүүлгийн бичиг авах шаардлагагүй гэж бодсон	D
		Шилжүүлгийн бичгээ хаясан	E
		Бичиг баримтын зөрчилтэй байсан	F
		Зээлтэй байсан	G
		Санхүүгийн боломжгүйгээс	H
		Бусад	X

Бүлэг 3. Ажил эрхлэлт ба хөдөлмөр амралтын горим

301	Т ямар чиглэлийн мэргэжилтэй вэ?	ХАА	A
		Боловсролын	B
		Техник, мэргэжлийн	C
		Эрүүл мэндийн	D
		Эдийн застийн	E
		Төрийн удирдлагын	F
		Худалдаа, үйлчилгээ	G
		Хууль, хяналт, хүчиний байгууллага	H
302	Та хэзээнээс гар аргаар алт олборлох ажил эрхэлж байна вэ?	Бусад	X
		Жил	<input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>
303	Та гар аргаар алт олборлохоос гадна өөр ямар нэг ажил эрхэлж байна уу?	Cap	<input type="checkbox"/> <input type="checkbox"/>
		Тийм	1
304	Та алт олборлох ажлаа орхиод өөр ажил эрхэлмээр байна уу?	Үгүй	2
		Тийм	1
		Үгүй	2
305	Та яагаад өөр ажил эрхлэх сонирхолтой байна вэ?	Тийм	1
		Үгүй	2
		Хангалттай мөнгө олсон	A
		Эрүүл мэнд муудсан	B
		Албан уурхай газраасаа хөөснөөс	C
		Цаг агаарын хүндрэл	D
		Ажлын нөхцөл хүнд	E
		Осол их гардаг	F
		Хяналт шалгалтын дарамт	G
		Гэр бүлээсээ хол	H
		Алтаа барьж чадахгүй	I
306	Хангалттай мөнгөтэй болсон бол яаж зарцуулах сонирхолтой байна вэ?	Алтны гарц муу	J
		Бусад	X
		Мал худалдаж авах	A
		Наймаа хийх	B
		Үйлдвэрлэл эрхлэх	C

307	Та жилийн ямар улиралд алт олборлох ажлыг ихэвчлэн хийдэг вэ?	Өвөл Хавар Зун Намар 4 улиралд	1 2 3 4 5	
308	Та хоногт дунджаар хэдэн цаг ажилладаг вэ?	Цаг	<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>	
309	Та хоногийн ямар цагт ихэвчлэн ажилладаг вэ?	Өдрийн цагаар Шöнийн цагаар Өдөр, шöнө харгалзахгүй	1 2 3	
310	Та ажиллаж байх үедээ хэдий хугацаанд завсарлага авдаг вэ?	1 цаг 2 цаг 3 цаг 4 цагаас дээш Завсарлага авдаггүй	1 2 3 4 5	
311	Та завсарлагааны үеээрээ юу хийдэг вэ?	Хоолоо илдэг Гэр орны ажлаа амжуулдаг Хүүхдээ асардаг Хөзөр даалуу гм тоглодог Биеийн тамирын дастал хийдэг Унтаж амардаг Наргиж цэнгэдэг Бусад	A B C D E F G X	
312	Та ажлын өдрүүдэд хэдэн удаа хооллодог вэ?	1 удаа 2 удаа 3 удаа 4 удаа 5 ба түүнээс дээш	1 2 3 4 5	
313	Сүүлийн 1 сарын хугацаанд ямар нэгэн шалтгаанаар халуун хоолгүй хонох тохиолдол байсан ўу	Тийм Үгүй	1 2	315
314	Халуун хоолгүй хонох тохиолдол хэр олон удаа тохиолдож байсан бэ?	7 хоног бүр Бараг сар бүр Зарим сард Зөвхөн ганц, хоёр сард	1 2 3 4	
315	Та долоо хоногт дунджаар хэдэн хоног амардаг вэ?	Нэг өдөр Хоёр өдөр Гурван өдөр 3-аас дээш өдөр Амардаггүй	1 2 3 4 5	
316	Та яг ямар төрлийн ажил гүйцэтгэдэг вэ?	Нүх ухах Шороо зөөх, шигших Алтаа угаах Тэсэлгээ хийх Чулух бутлах Мөнгөн усаар бариулах Ус зөөх Бусад	A B C D E F G X	
317	Та өдөрт хэдий хэмжээний шороо угаадаг вэ?	Газар доор ажилладаггүй Газар доор ажилладаг (цаг)	1 <input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>	

318	Та өдөрт хэдий хэмжээний шороо угаадаг вэ?	Угаадаггүй 1 Угаадаг (кг) <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
319	Танд ажлын дараах нөхцлөөс хүнд, бэрхшээлтэй нь юу вэ?	Тоос шороо A Чийг, ус B Хэт халуун C Хэт хүйтэн D Дуу шуугиан E Харанхуй F Агааргүй G Давчuu H Гүн I Бусад X	
320	Та дараах багажуудаас алийг нь хэрэглэдэг вэ?	Хүрз A Жоотуу B Лоом C Хувин D Түмпэн E Шуудай F Шигшүүр G Сэнс H Тээрэм I Усан буу J Бусад X	
321	Тэсэлгээ хийхдээ тэсэлгээний ямар бодис хэрэглэдэг вэ?	
322	Та алтаа барихдаа ямар бодис хэрэглэдэг вэ?	Мөнгөн ус A Салхи-сэнс B Ус C Аммонит D Цианит E Бусад X	327
323	Та хэдий хугацаанд мөнгөн ус ашиглаж байна вэ?	Cap <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
324	Өдөрт хэдэн грамм мөнгөн ус хэрэглэж байна вэ?	Грамм <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
325	Та өдөрт хэдэн удаа алт бариулдаг вэ?	The number <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
326	Мөнгөн усаар алтаа яаж бариулдаг вэ?	Гар дээр A Саванд B Бусад X	
327	Хэрэглэдэг химийн бодисуудаа хаана хадгалдаг вэ?	Гэртээ A Гада нүхэнд B Бусад X	
328	Химийн бодисуудаа хаанаас олж авдаг вэ?	Үурхайгаас A Хувь хүнээс B Захаас C Байгууллагаас D Бусад X	

329	Химиийн бодистой ус шороогоо хаана хаядаг вэ?	Усруу Хөрс рүү Нүхэнд Хогын цэг дээр Бусад	A B C D X
330	Та ажиллах үедээ эдгээр хувцаснуудыг хэрэглэдэг үү?	Каск Бээлий Маск Хошуувч Ханцуйвч Комбинзон Бэхлэгч Бэхэлгээний олс Хормогч Хамгаалах нүдний шил Бусад	A B C D E F G H I J X
331	Энэ хувцаснуудаас хамгийн их хэрэгцээтэй нь юу вэ?	Каск Бээлий Маск Хошуувч Ханцуйвч Комбинзон Бэхлэгч Бэхэлгээний олс Хормогч Хамгаалах нүдний шил Бусад	A B C D E F G H I J X
332	Танд хөдөлмөр хамгааллын хувцас ашиглахтай холбоотой ямар хүндрэл гардаг вэ?	Ямар хувцас хэрэглэхийг мэддэггүй Сонгож чаддаггүй Үнэ өндөр Хаанаас авахаа мэддэггүй Хэрэглэх сонирхолгүй Олдлоггүй Мэдэхгүй Бусад	A B C D E F G X

Бүлэг 4. Орлого ба зарлага

